



**Хууль зүй, дотоод
хэргийн яам**



**“Шүүх, эрх зүйн
шинэчлэлт” төсөл**

ФИЛОСОФИ

Гарын авлага

Зөвлөх: Б.Батчулуун

**Боловсруулсан: М.Отгонбаяр
Б.Дагзмаа
Л.Өнөржаргал
Т.Энхтунгалаг
Б.Галиндэв**

*Энэхүү гарын авлагыг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас
хэрэгжүүлж буй Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт”
төслийн хүрээнд боловсруулав.*

Улаанбаатар 2007

DDC
100'077
Ф-561

Философи
Гарын авлага

Хөтөлбөр боловсруулсан:

Зөвлөх: **Б.Батчулуун** (*Доктор (Ph.D)*)

Багийн ахлагч: **М.Отгонбаяр** (*Доктор (Ph.D), дэд профессор*)

Багийн гишүүд: **Б.Дагзмаа** (*Доктор (Ph.D)*)

Л.Өнөржаргал (*Магистр (MA)*)

Т.Энхтунгалаг (*Магистр (MA)*)

Гарын авлага боловсруулсан:

Зөвлөх: **Б.Батчулуун** (*Доктор (Ph.D)*)

Багийн ахлагч: **М.Отгонбаяр** (*Доктор (Ph.D), дэд профессор*)

Багийн гишүүд: **Б.Дагзмаа** (*Доктор (Ph.D)*)

Л.Өнөржаргал (*Магистр (MA)*)

Т.Энхтунгалаг (*Магистр (MA)*)

Б.Галиндэв (*Доктор (Ph.D)*)

Хэвлэлийн хэмжээ: 10.1 х.х

Номын хэмжээ: 70х100/16

Хэвлэсэн газар: "Содпресс" ХХК

ISBN: 978-99929-54-28-0



“ШҮҮХ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛТ” ТӨСЛИЙН ТУХАЙ

Хууль зүйн сургуулийн багш, оюутнуудад



"Шүүх, эрх зүйн
шинэчлэлт" төслийн
зохируулагч
Д.ОЮУНЧИМЭГ

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төсөл 2002 оноос хэрэгжээд дуусах шатандаа орж байна.

Энэ төслийн хүрээнд эрх зүйн дээд боловсролыг чанаржуулах чиглэлээр эхний шатны зарим ажлыг хийж дуусгалаа. Эдгээр ажлын үр дүн нь таны гар дээр очиж буй энэ гарын авлага юм. Бид энэ ажлыг зохион байгуулахдаа гадаадын зөвлөх гэхээсээ монголчууд бидний оюун ухаанд тулгуурлаж, дотоодын эрдэмтэн, багш нараар хийлгэсэн юм. Энэ номыг бүтээхэд хууль зүйн сургуулиудаас нэр хүндтэй, туршлагатай ахмад багш, нөгөө талаар идэвхтэй, санаачлагатай, хийж бүтээе, өөрийгөө боловсруулъя гэсэн эрмэлзэлтэй залуу багш нарыг баг болгон оролцуулсан юм. Энэ гарын авлагыг бүтээх явцад багш нар хамтран ажиллаж, бие биенээсээ харилцан суралцаж, цаашид судалгаа шинжилгээний ажил, эрх зүйн сургалтын шинэчлэлтийг хамтран хийхэд үр дүнд хүрнэ гэдгийг харуулсан болно.

Оюутанд зориулсан цогц гарын авлага (хичээлийн хөтөлбөр, тойм лекц) нь Монголд анх удаагаа гарч байгаа билээ. Оюутны гарын авлага нь тэдний судалж буй хичээлд хандах хандлагыг өөрчилж, “бэлэнчлэх” сэтгэлгээнээс ангижруулахад хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.

Төсөл бол тодорхой хугацаанд хэрэгжээд дуусдаг жамтай. Харин төсөл хэрэгжүүлэх явцад танилцсан, хамтарч ажилласан багш нар цаашдаа өөрсдийгөө боловсруулах, сургалтынхаа арга барил, чанарыг сайжруулах чиглэлээр хийж эхэлсэн ажлаа үргэлжлүүлнэ гэдэгт найдаж байна. Хичээлийн хөтөлбөр, оюутны гарын авлага бүтээхэд оролцсон 100 орчим эрдэмтэн, багш нар болон энэ ажлыг гардан зохион байгуулж, уялдаа холбоог нь хангах талаар идэвх зүтгэлтэй ажилласан төслийн ажилтан Б.Сарантуяад талархал илэрхийлье.

Үр дүнд чиглэсэн сургалтын хөтөлбөр



"Шүүх, эрх зүйн
шинэчлэлт" төслийн
зөвлөх **У. ТУЯА**

Оюутан залуус та бүхэнд их мэдлэгийг хуримтлуулах нь чухал уу, харин уг мэдлэгээ ашиглах чадвар, мэргэжлийн үнэт зүйлсийг эзэмших нь чухал уу. Аль замыг чухал гэж сонгосноос таны суралцах арга барил, цаашлаад сургалтад хандах хандлага тань тодорхойлогддог байна. Сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулахад ч энэ хоёр талаас авч үзэх хэрэгтэй болдог.

Бид 2003 оноос Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн “Хууль зүйн бакалаврын боловсролыг сайжруулах” дэд төслийн хүрээнд энэхүү сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсруулахдаа дараах шаардлагыг харгалзсан бөгөөд оюутан таныг ч энэ тухай мэдэж сургалтын хөтөлбөр, гарын авлагаа ашиглахыг зөвлөж байна. Үүнд:

- ❖ Оюутан ямар зорилгоор уг хичээлийг судалж, ямар үр дүнд хүрэхээ мэдэж байх ёстой.
- ❖ Мэргэжлийн мэддэг нь мэргэжлийн ур чадвар болон хөгжиж, үнэт зүйл болон төлөвшсөн байх нь чухал. Иймээс мэдээлэл болгоныг боловсруулах бие даалтын ажил оюутанд хэрэгтэй.

БАГИЙН ТАНИЛЦУУЛГА



Балдандоржийн Батчулуун Доктор (Ph.D).

Философи, улс төр судлал, соёлын антропологи, нийгмийн психологийн салбарт сургалт, судалгааны ажил хийдэг. Бие даан 6, хамтран 6 ном бүтээл тус тус туурвисан. Нийт 8 ном, сурах бичгийн редактороор ажилласан. Төвийн сонин хэвлэлд нийт 120-иод өгүүлэл нийтлүүлжээ. Мөн англи хэлнээс 8, орос хэлнээс нэг бүтээл орчуулсан. 1992 онд "Үг", 2006 онд "Ардын эрх" сонины оны тэргүүн бичлэгийн шагнал хүртэж байв.



Момолын Отгонбаяр Доктор (Ph.D), дэд профессор

МУИС-ийн философийн тэнхмийн багш. Логик, эпистемологи, шинжлэх ухааны философи, феминист философийн чиглэлээр ажилладаг. Эрдэм шинжилгээний өгүүлэл 20 гаруй, ном сурах бичиг 4-ийг бичиж нийтлүүлсэн ба 2 ном орчуулсан, 14 бүтээл редакторласан.



Балдоо Дагзмаа Философийн ухааны доктор (Ph.D)

МУИС-ийн философийн тэнхмийн багш. Орчин үеийн философи, ёс зүй, феминист философийн чиглэлээр ажилладаг. Эрдэм шинжилгээний өгүүлэл 10 гаруй, ном сурах бичиг 2-ыг бичиж, 2 бүтээл редакторласан.



Лханаа Өнөржаргал Философийн магистр (MA)

МУИС-ийн философийн тэнхмийн цагийн багш. Логик, эпистемологи, нийгмийн философийн чиглэлээр ажилладаг.

Мэдлэгийн нийгэм-соёлын уг чанарын асуудал (УБ.,2002), Философийн мэдлэг шалгах тест (УБ.,2007 тус тус хэвлүүлсэн.



Тогтохын Энхтунгалаг Философийн магистр (MA)

МУИС-ийн философийн тэнхмийн багш. Логик, хэлний философи, логикийн философийн чиглэлээр ажилладаг.

Эрдэм шинжилгээний өгүүлэл 5, орчуулсан ном 1, философийн мэдлэг шалгах тест тус тус хэвлүүлсэн.



ӨМНӨХ ҮГ

Эрхэм оюутан залуус танаа!

Залуу анд минь, энэхүү гарын авлага таныг философич болгох зорилгоор бичигдээгүй гэдгийг шулуухан хэлчихье. Гэхдээ гарын авлагын үндсэн агуулга ялангуяа сэдэв бүрээр цаашид уншиж судлах ном зохиолуудтай оюуны чармайлт гарган ухамсартай харилцах аваас сэтгэлгээний соёлтой хүн болж төлөвшихөд тань багагүй тус болох вий.

Гарын авлага дээр ажилласан манай багийнхан хууль зүйн сургалт явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн их, дээд сургуулийн багш, оюутнуудтай уулзаж ярилцах, семинар хийх, социологийн судалгаа явуулах, тухайн сургуулиуд дээр заагдаж буй философийн хичээлийн агуулгад анализ хийх, Өрнөдийн өндөр хөгжилтэй орнуудын их, дээд сургуулийн философийн хичээлийн хөтөлбөртэй харьцуулах, тэдгээр орны их, дээд сургуульд ашиглагдаж буй философийн сурах бичгүүдийг орчуулах гээд багагүй хөдөлмөр зарцуулсныг энд дурьдах ёстой. Энэ бүхний үр дунд гарын авлага маань монгол хэл дээрх философийн уламжлалт сурах бичгүүдээс агуулга, хэлбэрийн хувьд арай өвөрмөц бөгөөд шинэлэг болсон хэмээн найдаж байна.

Алаг эрээн ертөнцийн адармаатай бүх асуудалд хууль-ёсны үүднээс төдийгүй хүн-ёсны үүднээс хандахаас өөр аргагүй нөхцөл байдал тулгардаг, нийгмийн олон талт амьдралыг зөвхөн хуулийн хэм хэмжээгээр "баглаж" болохгүй юм байна гэдгийг ойлгоход энэ гарын авлага тус болно. Ер нь хүмүүний аж төрөл нь үнэхээрийн төгс төгөлдөр гэж нэрлэгддэг ямар ч хууль зүйн системээс баялаг зүйл билээ. Үүнийг ойлгоход философи тусалдгийг түүхэн дэх их сэтгэгчид цохон тэмдэглэж байсан нь олонтаа. Энэ бүхнийг ойлгосноор та мэргэжилдээ дурамжхан ханддаг нэгэн болох биш харин ч бүр сайн хуульч болж болох юм. Бидний ойлгож байгаагаар сайн хуульч гэдэг бол олон хуулийн зүйл, ангийг цээжээр мэддэг байх биш харин тэдгээр хуулийн амин сүнс, утга учир, философийг ойлгодог хүнийг хэлэх болов уу! Ийм хуульч болоход тань энэ бяцхан гарын авлага нэмэр болох аваас бид бүхэнд ирж буй хамгийн том шагнал тэр болно.

Дашрамд хэлэхэд, миний бие өөрийн санаа нэгт шавь нарын хамт философийн бус ангиудад үздэг философийн хичээлийн агуулгыг уйтгартай, номчирхсон бас тэгээд марксист үнэр ханхалсан одоогийн агуулгаас нь салгах юмсан гэж эртнээс хүсэж байсан бөгөөд завшаанаар Дэлхийн Банкны төслөөр хэрэгжиж буй энэ төслийн хүрээнд анхны алхам маань хийгдлээ. Иймд энэхүү гарын авлагыг гарахад санхүүгийн туслалцаа үзүүлсэн Дэлхийн Банкны төслийн хамт ол онд гүнээ талархаж буйгаа илэрхийлье.

Хөтөлбөр, гарын авлага дээр зөвлөх,
редактороор ажилласан

Б.Батчулуун

ГАРЧИГ

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
БАГИЙН ТАНИЛЦУУЛГА	4
ӨМНӨХ ҮГ	5
ФИЛОСОФИЙН ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР	
1. Философийн хичээлийн тодорхойлолт	7
2. Философийн хичээлийн агуулга	10
3. Философийн хичээлийн заах арга зүй	40
4. Философийн хичээлийн үнэлгээ	48
ФИЛОСОФИЙН ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА	
I бүлэг. УДИРТГАЛ	
1. Философийн тухай ерөнхий ойлголт	52
2. Мэдлэгийн системд философийн эзлэх байр суурь	55
II бүлэг. ЕС ЗҮЙ	
1. Сонгодог философи дахь ёс зүйн үндсэн баримтлалууд	56
2. Ёс зүйн орчин үеийн үндсэн баримтлалууд	62
3. Орчин үеийн хэрэглээний ёс зүйн асуудал	66
III бүлэг. УЛС ТӨРИЙН ФИЛОСОФИ	
1. Улс төрийн философийн үндсэн асуудлууд ба баримтлалууд	69
2. Зүй ёсны онол	72
3. Биологийн ялгааны улс төрийн үр дагаварын философи асуудал	76
IV бүлэг. МЕТАФИЗИК БА ОНТОЛОГИ	80
V бүлэг. ЭПИСТЕМОЛОГИ	
1. Мэдлэгийн төрөл хэлбэрүүд, тэдгээрийн харилцаа	84
2. Үнэний талаархи баримтлалууд, үнэний шалгуурын асуудал	87
3. Мэдлэгийн эх сурвалжийн тухай баримтлалууд	92
VI бүлэг. ШАШНЫ ФИЛОСОФИ	
1. Шашны философи асуудлууд	94
2. Монголын буддист философи	98
VII бүлэг. ҮНЭЛЭМЖИЙН ОНОЛ	102
VIII бүлэг. УРЛАГИЙН ФИЛОСОФИ	106
IX бүлэг. ӨНӨӨГИЙН ФИЛОСОФИ ЗАРИМ ЧИГЛЭЛЭҮҮД	
1. Орчин үеийн философийн үндсэн баримтлалууд I (Позитивизм, прагматизм, герменевтик)	109
2. Орчин үеийн философийн үндсэн баримтлалууд II (Амьдралын философи, экзистенциализм, феноменологи, фрейдизм, постструктурализм)	113
3. Хүний философийн орчин үеийн зарим чиглэл	117
4. Герменевтик, постструктурализм, постмодернизм	119



ФИЛОСОФИЙН ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

1. Философийн хичээлийн тодорхойлолт

Философи хичээлийн танилцуулга

Хичээлийн нэр: Философи

Индекс:

Кредит цаг: 2 кр

Нийт цаг: 40 (лекц - 24, семинар 16)

Семестр:

Философи хичээлийг судлах хэрэгцээ, шаардлага:

Философи нь зөвхөн тухайн мэргэжлийн хувьд төдийгүй, ерөөс амьдралд бүхэлд нь тустай оюуны чадварыг хөгжүүлдэг. Бакалаврын түвшний эрх-зүйч мэргэжилтний хувьд философийг судлах нь шүүмжлэлт сэтгэлгээ, эргэцүүлэн бодох, үндэслэгээ гаргах, асуудлыг олон талаас нь авч үзэж, зөв шийдвэр гаргах зэрэг чадварыг эзэмшихэд нь тус болно.

Хичээлийн зорилго:

Онолын (метафизик, эпистемологи) ба практик (үнэлэмжийн) философийн үндсэн асуудлууд, гол гол баримтлалтай танилцаж ерөнхий мэдлэг олж авна.

Энэ хичээлийг үзсэнээр бие даасан, шүүмжлэлт сэтгэлгээтэй болох, асуудлыг олон талаас нь авч үздэг байх, мэдээллээс зөв сонголт хийдэг байх, нэг асуудлаархи ялгаатай үзлүүдэд хүлээцтэй ханддаг байх, мэтгэлцэх тодорхой чадвар эзэмшинэ. Философи суурь асуудлуудыг дэвшүүлж, эргэцүүлснээр аливаа асуудлыг шийдвэрлэхдээ олон талаас нь ханддаг болоход тусална.

Хичээлийн зорилтууд:

- ▲ Метафизик суурь асуудлууд: бодит байдлын уг чанар, шалтгаан, өөрчлөлт, олон янз байдлын талаархи философи асуултуудтай тулгарч эргэцүүлэл хийх
- ▲ Мэдлэг, түүний уг сурвалж, төрөл хэлбэрүүд, хүрээ, хязгаар, мэдлэгийн өсөлт, үнэн мэдлэгийн шалгуур зэрэг асуудлуудтай тулгарч эпистемологи эргэцүүлэл хийх
- ▲ Урлаг, шашин, ёс суртахуун, улс төрийн талаархи үнэлэмжийн орчин үеийн философи баримтлалуудын талаар суурь мэдлэгтэй болж, түүнийхээ үүднээс нийгмийн амьдралын үзэгдлүүдэд эргэцүүлэл хийж, үнэлгээ өгөх

Залгамж холбоо: Логик, эрх зүйн философи, мэргэжлийн ёс зүй, эрх зүйн онол

Философийн хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, цаг хуваарилалт

№	Бүлэг	Сэдвийн нэр	Цаг	хэлбэр
I	Удиртгал	1. Философийн тухай ерөнхий ойлголт	2	Лекц 1
		2. Мэдлэгийн системд философийн эзлэх байр суурь	2	Семинар 1
II	Ёс зүй	1. Сонгодог философи дахь ёс зүйн үндсэн баримтлалууд	2	Лекц 2
		2. Ёс зүйн орчин үеийн үндсэн баримтлалууд	2	Лекц 3
		3. Орчин үеийн хэрэглээний ёс зүйн зарим асуудал	2	Семинар 2
III	Улс төрийн философи	1. Улс төрийн философийн үндсэн асуудлууд ба баримтлалууд	2	Лекц 4
		2. Зүй ёсны онол	2	Семинар 3
		3. Биологийн /хүйс, арьс/ ялгааны улс төрийн үр дагаварын философи асуудал	2	Семинар 4
IV	Метафизик, онтологи		2	Лекц 5
V	Эпистемологи	1. Мэдлэгийн төрөл хэлбэрүүд, тэдгээрийн харилцаа	2	Лекц 6
		2. Үнэний талаархи баримтлалууд, үнэний шалгуурын асуудал	2	Лекц 7
		3. Мэдлэгийн эх сурвалжийн тухай баримтлалууд	2	Семинар 5
VI	Шашны философи	Шашны философи асуудлууд	2	Лекц 8
		Монголын буддист философи	2	Семинар 6
VII	Урлагийн философи		2	Лекц 9
VIII	Үнэлэмжийн онол		2	Лекц 10



IX	Өнөөгийн философи зарим чиглэлүүд	1. Орчин үеийн философийн үндсэн баримтлалууд I	2	Лекц 11
		2. Орчин үеийн философийн үндсэн баримтлалууд II	2	Лекц 12
		3. Орчин үеийн хүний философийн зарим чиглэл	2	Семинар 7
		4. Герменевтик, постструктурализм, постмодернизм	2	Семинар 8
X	Бүгд	Лекц-24 цаг, Семинар-16 цаг	40 цаг	

2. Философийн хичээлийн агуулга

I бүлэг. УДИРТГАЛ

Сэдэв 1. Философийн тухай ерөнхий ойлголт

Зорилго: Философи гэж юу болох, мэдлэгийн тогтолцоонд философийн эзлэх байр суурь, түүний мэдлэгийн бусад төрлүүдтэй харилцан холбоо, судлах зүйл, философи мэдлэгийн бүтэц, философийг судалсны ач холбогдол зэргийн талаар анхны суурь ойлголттой болно.



Нэр томъёо

- ▲ Phileo-Sophia /цэцэн мэргэнд дурлах/
- ▲ Онолын ба үнэлэмжийн /практик/ философи
- ▲ Философийн салбарууд: Метафизик, Эпистемологи, Этик, Үнэлэмж, Эстетик
- ▲ Философи асуултуудын нийтлэг байдал



Сэдвийн агуулга

- ▲ Философи гэж юу вэ?
- ▲ Философийн тухай олон янз тодорхойлолт
- ▲ Яагаад философийг судалдаг вэ?
- ▲ Философийн үүсэл
- ▲ Философийн бүрэлдэхүүн
- ▲ Философи мэдлэгийн бусад төрлүүдтэй ямар холбоотой вэ?
/Философи, шинжлэх ухаан, урлаг, шашин, шидэт домог/



Хэлэлцүүлгийн асуултууд

1. Яагаад философийн талаар нэг тогтсон тодорхойлолт байдаггүй вэ? Философи эргэцүүллийн объект болдог сэдвүүдийг тоочно уу?
2. Онолын ба практик философийн ялгааг тайлбарла
3. Философийг судалсны хэрэг танд яаж гарах бол?
4. Чухамхүү яагаад эртний грек, ромд философи үүссэн гэж үздэг вэ?
5. Философи гэдэг үгийн утга, ойлголтын утга хоёрын ялгааг гаргана уу?
6. Философи мэдлэгийн бүрэлдхүүн хэсгүүдийг нэрлэн үү?
7. Дээрх бүрэлдхүүн хэсгүүдийг онолын ба үнэлэмжийн /практик/ хэмээх
8. ангилалд хуваарилна уу?
9. "Хүн бүр өөрийн философитой" нь философи мэдлэгийн бүтцэд хамрагдах уу?



Ном зүй

1. Б.Батчулуун. Философи гэж юу вэ? УБ., 2003.
2. Р.Дамбийням. Гүн ухаан. УБ., 2000.1-р хэсэг.
3. Мэл Томпсон. Философи (өөрөө сурах бичиг) УБ., 2001. он. Англи хэлнээс орчуулсан Б.Батчулуун. Удиртгал хэсэг.
4. Б.Рассел. Өрнийн мэргэн ухаан. /англи хэлнээс орч/ УБ., Монсудар. 2007
5. Ричард Поупкин, Аврум Строл. Гүн ухаан. /орос хэлнээс орч/ УБ., 1998. Удиртгал.
6. Философи. Сурах бичиг. МУИС-ийн философийн тэнхим. УБ., 2002. Удиртгал. § 1, 2, 6, 7.
7. Философи эхлэн сурах бичиг. Нээлттэй философи нийгэмлэг. УБ., 2000. I бүлэг.
8. Философийн тухай./орос хэлнээс орч Ч.Ган-Өлзий/ УБ., 1989.
9. Ed L.Miller. Questions that matter. An invitation to philosophy. McGraw-Hill. 1996.
10. Robert Paul Wolff. About Philosophy. Prentice Hall, 1989.

Сэдэв 2. Мэдлэгийн тогтолцоонд философийн эзлэх байр суурь

Зорилго:

Философи гэж юу вэ? гэдэг асуултанд өгдөг олон янз хариултуудад анализ хийх, мэдлэгийн бусад төрлүүдтэй философи ямар харилцан холбоотой болохыг тухайлбал философи ба шинжлэх ухаан, философи ба шашны харилцан холбоо болон онцлог ялгааг ойлгуулахад энэ хичээлийн зорилго оршино.

Философийг мэдлэгийн бусад төрлүүдээс тухайлбал, шинжлэх ухаан,шашин, шидэт домог, урлаг зэргээс ялгах чадвартай болно. Философидох, асуудалд философийн үүднээс ханддаг болоход тусална.



Нэр томъёо

- ▲ Филео
- ▲ София
- ▲ Шидэт домог
- ▲ Шашин
- ▲ Парафилософи
- ▲ Натурфилософи
- ▲ Ертөнцийг үзэх үзэл
- ▲ Соёл
- ▲ Арга зүй
- ▲ Судлах зүйл
- ▲ Шинжлэх ухаан



Сэдвийн агуулга

- ▲ Философи мэдлэгийн үүсэл, нэр томъёоны утга
- ▲ Философи мэдлэг, түүний судлах зүйл
- ▲ "Философи" гэдэг ойлголтын тодорхойлолтын олон янз байдал
- ▲ Шинжлэх ухааны мэдлэгийн үүсэл
- ▲ Шинжлэх ухаан, философи хоёрын харилцан холбоо
- ▲ Шашин, түүний нийгмийн үүрэг
- ▲ Шашин, шинжлэх ухааны харилцан хамаарлын асуудал



Хэлэлцүүлгийн асуултууд

1. Философи хэзээ, хаана үүссэн бэ?
2. "Парафилософи", "натурфилософи" гэдэг ойлголтуудын утга
3. Сонгодог философийн онцлог шинжийг тодорхойлно уу?
4. Философи гэдэг ойлголтын олон янз байдлын учир шалтгааныг тайлбарлана уу?
5. Мэдлэгийн тогтолцоонд философийн эзлэх байр суурийг тодорхойлно уу?
6. Шинжлэх ухааны мэдлэг үүссэн шалтгааныг тайлбарлана уу?
7. Шинжлэх ухаан, философи хоёрын нийтлэг болон ялгаатай талуудыг нэрлэнэ үү?
8. Шашны үндсэн ойлголтуудын утга, мэдлэгийн тогтолцоонд түүний эзлэх байр суурийн талаар ярилцана уу?
9. Шашин, философи хоёрын нийтлэг болон ялгаатай талуудыг нэрлэнэ үү?



Ном зүй

1. Мэл Томпсон. Философи (өөрөө сурах бичиг) /Англи хэлнээс орчуулсан Б.Батчулуун/ УБ., 2001 он. Удиртгал хэсэг.
2. Ричард Поупкин, Аврум Строл. Гүн ухаан. УБ., 1998.
3. Б.Рассел, Өрнийн мэргэн ухаан. /англи хэлнээс орч/ УБ., Мон судар. 2007.
4. Философи. Сурах бичиг. МУИС-ийн философийн тэнхим. УБ., 2002. Удиртгал. §1, 2, 6, 7.
5. Философи эхлэн сурах бичиг. Нээлттэй философи нийгэмлэг. УБ., 2000 он. I бүлэг.
6. Б.Батчулуун. Философи гэж юу вэ? УБ., 2003.
7. Д.Баттөмөр. Логик, эпистемологи, шинжлэх ухааны философийн асуудлууд. УБ. 2005.
8. М.Отгонбаяр. Метафилософи зарим эргэцүүлэл. Дэлхийн философийн өдөрт зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын материал. УБ., 2005.
9. Философийн тухай. /орос хэлнээс орчуулсан Ч.Ган-Өлзий/ УБ., 1989.
10. Ed L.Miller. Questions that matter. An invitation to philosophy. McGraw-Hill., 1996.
11. G.Lee Bowie, Meredith W Michaels, Robert C. Solomon. Twenty Questions. An Introduction to Philosophy. 1996.
12. Robert Paul Wolff. About Philosophy. Prentice Hall. ,1989.
13. The Cambridge Dictionary of Philosophy. Cambridge UP., 1999.



II бүлэг ЁС ЗҮЙ

Сэдэв 1. Сонгодог философи дахь ёс зүйн үндсэн баримтлалууд

Зорилго: Ёс зүйн үндсэн ойлголт, зарчим, баримтлалуудын талаар философи онолын суурь мэдлэгтэй болно.
Олон төрлийн мэдээллээс зөв сонголт хийх, ёс зүйн тулгамдсан асуудлуудыг бүтээлчээр, шүүмжлэлтэй эргэцүүлэх суурь чадвартай болно.
Ёс суртахууны практик аливаа асуудалтай тулгарахад олон талаас нь авч үздэг, идэвхитэй, шүүмжлэлтэй, ухаалаг хандах хандлагатай болно.



Нэр томъёо

- ▲ Этик
- ▲ Мораль
- ▲ Ёс суртахууны алтан зарчим
- ▲ Амьдралын утга учир
- ▲ Аз жаргал
- ▲ Таашаал
- ▲ Сэтгэлийн тайван байдал
- ▲ Үүрэг
- ▲ Сайн санаа
- ▲ Ёс суртахууны сэдэл
- ▲ Зайлшгүй захирамж (императив)
- ▲ Утилитарист зарчим



Сэдвийн агуулга

- ▲ "Этик" гэдэг ойлголтын үүсэл
- ▲ Этикийн судлах зүйл
- ▲ Эвдемонизм: Демокрит, Аристотель
- ▲ Гедонизм: Эпикур
- ▲ Кинизм, стоицизм: Зенон, Диоген, Антисфен
- ▲ Перфекционизм: Кунз
- ▲ Христос шашны ёс зүй: Августин
- ▲ Үүргийн ёс зүй: Кант
- ▲ Ёс зүйн универсализм
- ▲ Утилитаризм: Бентам, Милль
- ▲ Ёс зүйн эгоизм ба альтруизм



Хэлэлцүүлгийн асуултууд

1. "Ес зүй" ба "ёс суртахуун" хэмээх ойлголтуудын харьцаа, эдгээр ойлголтуудын агуулга нь тэдгээрийн өдөр тутмын хэрэглээтэй тохирдог уу?
2. Ёс суртахууны "алтан зарчмын" агуулгыг тодорхойл
3. Эвдемонизм ба гедонизм хоёр ямар ялгаатай вэ?
4. Кантын зайлшгүй захирамжийн онцлог шинж юу вэ?
5. Утилитаристууд хүний зан үйлийн универсаль үндэс болгон юуг авч үздэг вэ?
6. Бүх нийтийн аз жаргалын тухай утилитарист зарчим гэж юу вэ?



Ном зүй

1. Философи эхлэн суралцах бичиг. УБ., 2000.
2. Д.Тунгалаг. Ёс зүй. УБ., 1998.
3. Поупкин Р., Стрел А. Гүн Ухаан. УБ., 1998.
4. Адорно Т. Проблемы философий морали. М., 2000.
5. Мур Дж.Э. Принципы этики. /пер с англ. М., 1990.
6. Б.Рассел, Өрнийн мэргэн ухаан. /англи хэлнээс орч/ УБ., Мон судар. 2007.
7. Luper Steven. A Guide to ethics. McGraw-Hill., 2002.
8. Ed. L.Miller. Questions that matter. McGraw-Hill., 1996.
9. Philosophical Entrees. Classical and Contemporary Reading in Philosophy. Ed by Dale Jacquette. McGraw-Hill Higher Education. 2001. Part 6.
10. Robert Paul Wolff. About Philosophy. Prentice Hall. 1989.
11. Samuel Enoch Stumpf. Elements of Philosophy. McGraw-Hill. 1993.

Сэдэв 2. Ес зүйн орчин үеийн үндсэн баримтлалууд

Зорилго:

Орчин үеийн ёс зүйн чиглэлүүдийн талаар суурь мэдлэгтэй болж, өнөөгийн нийгмийн ёс суртахууны харилцаа, төлөв байдалд үнэлэлт өгөх, мэдээллээс зөв сонголт хийх чадварыг эзэмшиж, ёс суртахууны аливаа асуудлыг ол он тал аас авч үзэж, ухаалаг, шүүмжлэлтэй, идэвхитэй хандлагатай болно.



Нэр томъёо

- ▲ Нигилизм
- ▲ Хүнлэг ёс
- ▲ Эзэрхэх хүсэл
- ▲ Үлэмж хүн
- ▲ Интуици
- ▲ Логик анализ
- ▲ Эмоци
- ▲ Верификаци



Сэдвийн агуулга

- ▲ Үнэлэмжийг шинэчлэх нь: Ницше
- ▲ Метаэтик: ёс зүйн онолд Мурын хийсэн эргэлт
- ▲ Хэрэглээний ёс зүйн нээлттэй асуудлууд



Хэлэлцүүлгийн асуултууд

- ▲ Орчин үеийн нийгмийг Ницше хэрхэн шүүмжилсэн вэ?
- ▲ Ницшегийн философи үзлийн гол гол ойлголтыг ёс зүйн үүднээс тодорхойлно уу?
- ▲ Ницшегийн ёс зүйн сургаалийг нигилизм гэж үзэж болох уу?
- ▲ Норматив болон метаэтикийн асуудлуудын ялгааг тодорхойлно уу?
- ▲ Мурын метаэтикийн судлах зүйлийг тодорхойлно уу?
- ▲ Ес суртахууны өгүүлбэрүүдийн утгыг логик анализад оруулж болох уу?
- ▲ Неопозитивист ёс зүйн үзлийн онцлог шинжийг хэлнэ үү?
- ▲ Ёс суртахууны өгүүлбэрүүдийг верификацид оруулж болох уу?



Ном зүй

1. Философи эхлэн суралцах бичиг. УБ., 2000.
2. Д.Тунгалаг. Ёс зүй. УБ., 1998.
3. Р.Поупкин, А.Стролл. Гүн ухаан. /орос хэлнээс орч/. УБ., 1998.
4. Поупкин Р., Строл А. Гүн Ухаан. УБ. 1998.
5. Адорно Т. Проблемы философий морали. М., 2000.
6. Мур Дж.Э. Принципы этики. /пер с англ/. М., 1990.
7. Б.Рассел. Өрнийн мэргэн ухаан. /англи хэлнээс орч/ УБ., Мон судар. 2007.
8. Ed. L.Miller. Questions that matter. McGraw-Hill., 1996.
9. Philosophical Entrees. Classical and Contemporary Reading in Philosophy. Ed by Dale Jacquette. McGraw-Hill Higher Education. 2001. Part 6.
10. Robert Paul Wolff. About Philosophy. Prentice Hall., 1989.
11. Samuel Enoch Stumpf. Elements of Philosophy. McGraw-Hill., 1993.

Сэдэв 3. Орчин үеийн хэрэглээний ёс зүйн зарим асуудал

Зорилго:

Ёс суртахууны үндсэн категори, зарчим, баримтлалуудын тухай мэдлэгээ баяжуулж, ёс зүйн онолын асуудал нийгмийн практиктай нягт уялдаж, харилцан сүлжилдсэн байдаг гэдгийг тодорхой жишээн дээр авч үзэх, шүүмжлэлт сэтгэлгээн дээр тулгуурлан орчин үеийн нийгмийн тулгамдсан асуудлуудад тал бүрээс нь хандан өөрийн дүгнэлт хийх, бусадтай хамтран ажиллах чадвараа хөгжүүлэх, үзэл бодлоо илэрхийлэх чадвартай болж, өөр үзэл бодлыг хүлцэх, хүндэтгэх хандлагатай болно.



Нэр томъёо

- ▲ Нээлттэй нийгэм
- ▲ Ес суртахууны нээлттэй асуудал
- ▲ Хэрэглээний ёс зүй



Сэдвийн агуулга

- ▲ Хэрэглээний ёс зүйн судлах зүйл
- ▲ Ес суртахууны нээлттэй асуудлууд, тэдгээрийн онцлог



Хэлэлцүүлгийн асуултууд

1. Цаазаар авах ял бол нийгмийн аюулгүй байдлыг хангах гол арга мөн эсэх
2. Үр хөндөлт бол зөвхөн эмэгтэй хүний хувийн шийдвэр байх ёстой эсэх
3. Хомосексуал үйлдлийг нийгмийн зүгээс цээрлэх ёстой эсэх
4. Эвтаназийг нийгэмд хэрэгжүүлэх ёстой эсэх
5. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хүчирхийлэл, садар самууныг нэвтрүүлэхийг хуулиар хориглох эсэх
6. Хэрэглээний ёс зүйн асуудлууд ямар онцлог шинжтэй вэ?
7. Эвтанази, түүний ёс суртахууны агуулга юунд орших вэ?
8. Үр хөндөлтийн нийгмийн үр дагавар гэж байх уу?
9. Цаазаар авах ял нийгмийн асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй арга мөн үү?
10. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хүчирхийлэл, садар самууныг нэвтрүүлэх нь хүний дотоод ертөнцөд нөлөөлөх үү?
11. Хомосексуаль хүмүүсийг нийгмийн зүгээс ялгаварлан, гадуурхах нь зөв үү?



Ном зүй

1. Адорно Т. Проблемы философий морали. М., 2000.
2. Философи эхлэн суралцах бичиг. УБ., 2000.
3. Философи сурах бичиг. УБ., 2002.
4. Мур Дж.Э. Принципы этики. /пер с англ/. М., 1990.
5. Поупкин Р., Строл А Философия. М., 1997.
6. Б.Рассел. Өрнийн мэргэн ухаан. /англи хэлнээс орч/ УБ., Монсудар. 2007.
7. Д.Тунгалаг. Ёс зүй. УБ., 1998.
8. G.Lee Bowie, Meredith W Michaels, Robert C. Solomon. Twenty Questions. An Introduction to Philosophy. 1996.
9. Luper Steven. A Guide to ethics. McGraw-Hill., 2002.
10. MacIntyre A. A short history of Ethics. 1967.
11. Ed. L.Miller. Questions that matter. McGraw-Hill., 1996.
12. Mortimer J Adler. How To Think About The Great Ideas. Open Court., 2000.
13. Robert Paul Wolff. About Philosophy. Prentice Hall., 1989.



III бүлэг . УЛС ТӨРИЙН ФИЛОСОФИ

Сэдэв 1. Улс төрийн философийн үндсэн баримтлалууд ба асуудлууд

Зорилго: Улс төрийн философийн суурь асуудлууд, нөлөө бүхий баримтлалуудын агуулга, тэдгээрийн эерэг, сөрөг талуудын тухай ерөнхий мэдлэгтэй болсноор нийгэм, улс төрийн аливаа үзэгдэл, үйл явцад онолын үндэслэлтэй үнэлэлт, дүгнэлт өгөх чадвар төлөвшиж, улс төрийн холбогдолтой асуудалд олон талаас нь бүтээлчээр ханддаг болно.



Нэр томъёо

- ▲ Элитизм
- ▲ Тимокраси
- ▲ Плутокраси
- ▲ Демокраси
- ▲ Төр улсын амьтан
- ▲ Байгалийн төлөв
- ▲ Нийтийн гэрээ
- ▲ Нийгмийн төлөв
- ▲ Иргэний нийгэм
- ▲ Төрөлх эрх
- ▲ Шөнийн харуулын төр
- ▲ Хүнийсгэл
- ▲ Зүй ёс
- ▲ Уг байдал
- ▲ Үл мэдэхийн хаалт
- ▲ Эзэмших эрх
- ▲ Сайн сайхан байдал



Сэдвийн агуулга

- ▲ Улс төрийн философийн асуудлууд ба суурь ойлголтууд /эрх чөлөө, эрх мэдэл, хуваарилалт, зүй ёс
- ▲ Платон: Элитизм
- ▲ Аристотель: Ардчилал, "Хүн бол төр улсын амьтан мөн болох нь"
- ▲ Либерализм (либертарианизм, халамжийн либерализм) ба марксизм хоёр эсрэг үзэл болох нь
- ▲ Индивидуализм ба коммунитарианизмын утга агуулга
- ▲ Утилитарианизм, шууд утилитарианизмын төсөөтэй ба ялгаатай тал
- ▲ Анархизм, фашизм, феминизмын улс төрийн утга агуулга
- ▲ Зүй ёсны онол
- ▲ Ж.Раулс: Зүй ёсны тухай хоёр зарчим
- ▲ Либерализм ба эгалитаризмыг Раулс нэгтгэсэн нь
- ▲ Нозик: Зүй ёс бол эрх болох нь
- ▲ "Шөнийн харуулын төр"
- ▲ Хуваарилалтын зүй ёсны тухай Нозикийн 3 зарчим
- ▲ Мак-Интайр: Зүй ёс бол сайн сайхан байдал болох нь



Хэлэлцүүлгийн асуултууд

1. Платон яагаад "философичид хаан байх ёстой" гэж үзсэн бэ?
2. Платоныхоор засаглалын хамгийн зохистой хэлбэр нь юу вэ?
3. Платоны үзлээр шилмэл хүмүүс гэж хэн бэ?
4. Шилмэл цөөн хүмүүс төрийг удирдах ёстой гэсэн Платоны үзэлд та эерэг болон сөрөг ямар үнэлгээ өгөх вэ?
5. Нийгэм, улс төрийн тухай Аристотелийн онол дахь "байгалийн хууль" гэсэн ойлголтыг тайлбарлана уу
6. Аристотель төрийн байгуулалтын ямар хэлбэрийг дэмжиж байсан бэ?
7. Нийгэм, улс төрийн тухай Аристотель болон Платоны үзлийн ялгаа нь юу вэ?
8. "Байгалийн төлөв", "нийгмийн гэрээ", "нийгмийн төлөв" гэсэн ойлголтуудын утгыг тайлбарлана уу?
9. Хүний "салшгүй эрх" гэсэн ойлголтын утга нь юу вэ?
10. Төрийн тухай Гоббс, Локк нарын үзлийн ялгаа юу вэ? Байгалийн төлөвийг тэд хэрхэн тайлбарлав?
11. "Гараа тат" хэмээх илэрхийллийн утгыг тайлбарлана уу?
12. Марксизм дахь "хүнийсгэл" хэмээх ойлголтын утга нь юу вэ?
13. Х.Маркузе капитализмыг хэрхэн шүүмжилсэн вэ?
14. Эрх чөлөө болон тэгш эрхийг ардчилал нэгэн зэрэг хангаж чадах уу?
15. Милль яагаад төлөөллийн ардчилалыг засаглалын хамгийн зохистой хэлбэр гэж үзсэн бэ?
16. Эрх чөлөөний тухай Миллийн үзлийн гол утга санаа юу вэ?
17. Либерализм, индивидуализм, либертарианизмын гол утгыг хэлнэ үү?
18. Зүй ёсны тухай Раулсын онол дахь "уг байдал", "үл мэдэхийн хаалт" хэмээх ойлголтуудыг тайлбарлана уу?
19. Зүй ёсны тухай Нозикийн онол дахь хуваарилалтын 3 зарчмыг нэрлэж, утгыг тайлбарлана уу?
20. Мак-Интайр "зүй ёс" гэдгийг хэрхэн тайлбарлав?



Ном зүй

1. Философи эхлэн сурах бичиг. Нээлттэй философи нийгэмлэг. УБ., 2000.
2. Жоннатон Вольф. Улс төрийн философийн удиртгал. /англи хэлнээс орч Б.Батчулуун/. УБ., 2002.
3. Б.Батчулуун. Орчин үеийн зүй ёсны онолууд хийгээд Монголын бодит байдал. УБ., 2000.
4. Д.Боаз. Либертарианизм. /англ хэлнээс орчуулсан Б.Батчулуун. УБ., 2005.
5. А.Жамбал. Улс төрийн сургаалийн түүх. УБ., 2001.
6. Платон. Төр улс. /грек хэлнээс орч Д.Отгонтуяа./ УБ., 2004.
7. Б.Рассел. Өрнийн мэргэн ухаан. /англи хэлнээс орч/ УБ., Монсудар. 2007.
8. Ed. L.Miller. Questions that matter. McGraw-Hill., 1996.
9. Mortimer J Adler. How To Think About The Great Ideas. Open Court., 2000.
10. Samuel Enoch Stumpf. Elements of Philosophy. McGraw-Hill., 1993.



Сэдэв 2. Зүй ёсны онол

Зорилго: Зүй ёсны онолын үндсэн асуудлууд болон баримтлалуудын тухай лекцээр эзэмшсэн мэдлэгээ бататгаж, түүнийг тодорхой тохиолдлууд дээр хэрэглэх замаар аливаа үзэгдэл, үйл явдалд тал бүрээс нь бүтээлчээр хандаж, үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай болно. Нийгэм дэх зүй ёсны болон зүй ёсны бус үзэгдэл, үйл явдлыг шүмжлэлтэйгээр, онолын үндэслэлтэйгээр авч үзэх хандлагатай болно.



Нэр томъёо

- ▲ Зүй ёс
- ▲ Тэгш эрх
- ▲ Уг байдал
- ▲ Үл мэдэхүйн хаалт
- ▲ Шударга ёс
- ▲ Хуваарилалтын зүй ёс
- ▲ Эзэмших эрх
- ▲ Өмчлөл
- ▲ Шилжүүлэхүй
- ▲ Сайн сайхан байдал



Сэдвийн агуулга

- ▲ Зүй ёсны онолын суурь асуудлууд
- ▲ Раулс: Зүй ёс бол шударга ёс болох нь
- ▲ Нозик: Зүй ёс бол эрх болох нь
- ▲ Мак-Интайр: Зүй ёс бол сайн сайхан байдал болох нь

Уг хичээлийн сэдэвтэй холбоотой дараах шийдлүүдийг санал болгож байна.

Шийдэл 1. Зарим хүмүүс, мөн зарим улс орон байгалийн давуу талуудтай (тухайлбал, баялаг, газар нутгийн байршил, уур амьсгал зэрэг) байдаг. Жишээлбэл, АНУ, Канад улс, ОХУ нь байгалийн нөөцөөр баян улсууд. Байгалийн эдгээр давуу талуудыг эзэмшдэг баян орнууд байгалийн тийм давуу талгүй улсуудад өөрсдийн баялагаа хуваалцах үүрэгтэй юу?

Шийдэл 2. 1990-ээд оны эхээр явагдсан орон сууцны хувьчлалаар орон сууцыг тухайн үед амьдарч байсан иргэдэд нь хувьчилсан. Тэрхүү орон сууцны хувьчлалд оролцоогүй хүмүүсийн хувьд энэ нь шударга уу?

Шийдэл 3. Зүй ёсны нийгэмд эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх үүргийг нийгэм хүлээх үү? Нийгэм энэ үүргийг хүлээх бол ямар хэмжээгээр тэрхүү үйлчилгээг үзүүлэх вэ? Яагаад?

Шийдэл 4. Монгол улсад төрийн албан хаагчийн нэг хүүхдийн их дээд сургуулийн сургалтын төлбөрийг нь төрөөс дааж байгаа нь зүй ёсонд нийцэх үү? Яагаад?

Шийдэл 5. Монгол улс гадаадын өндөр хөгжилтэй орнууд, олон улсын байгууллагуудаас их хэмжээний зээл авч байна. 50 жилийн дараах ирээдүй үеийнхэн энэ хариуцлагыг хүлээх нь зүй ёсонд нийцэх үү? Яагаад?



Хэлэлцүүлгийн асуултууд

- ▲ Зүй ёсны тухай Раулсын онол дахь "уг байдал", "үл мэдэхийн хаалт" хэмээх ойлголтуудыг тайлбарлана уу?
- ▲ Зүй ёсны тухай Нозикийн онол дахь хуваарилалтын 3 зарчмыг нэрлэж, утгыг тайлбарлана уу?
- ▲ Мак-Интайр "зүй ёс" гэдгийг хэрхэн тайлбарлав?



Ном зүй

1. Философи эхлэн сурах бичиг. Нээлттэй философи нийгэмлэг. УБ., 2000.
2. З. Жоннатон Вольф. Улс төрийн философийн удиртгал. /орч Б.Батчулуун/. УБ., 2002.
3. Платон. Төр улс. /грек хэлнээс орч Отгонтуяа/. УБ., 2004.
4. Б. Батчулуун. Орчин үеийн зүй ёсны онолууд хийгээд Монголын бодит байдал. УБ., 2000.
5. G.Lee Bowie, Meredith W Michaels, Robert C. Solomon. Twenty Questions. An Introduction to Philosophy. 1996.
6. Ed. L.Miller. Questions that matter. McGraw-Hill., 1996.
7. Mortimer J Adler. How To Think About The Great Ideas. Open Court., 2000.
8. Samuel Enoch Stumpf. Elements of Philosophy. McGraw-Hill., 1993.
9. Samuel Enoch Stumpf. Philosophical Problems. McGraw-Hill., 1994.

Сэдэв 3. Биологийн ялгааны нийгэм, улс төрийн үр дагаварын философи асуудал

Зорилго:

Хүйсийн болон жендерийн ялгаа, энэхүү ялгааны нийгэм, эдийн засаг, улс төрийн үр дагаврын талаархи философи баримтлал, үндэслэлүүдийн талаар тодорхой мэдлэг эзэмшинэ.

Нас, хүйс, арьсны өнгө, үндэс угсаа зэргээр нь ялгаварлах үзлийг зүй ёсны онолын үүднээс шүүмжлэн эргэцүүлэх чадвартай болно. Асуудалд жендерийн мэдрэмжтэй ханддаг болох, нийгмийн аливаа ялгаварлан гадуурхах байдалд ухаалаг, зүй ёсны үүднээс ханддаг болно.



Нэр томъёо

- ▲ Субъектив чанар
- ▲ Адилсал
- ▲ Ондоон
- ▲ Бэлгийн мэдрэмж
- ▲ Шоовдор байдал
- ▲ Эмэгтэй-субъект
- ▲ Бие
- ▲ Децентраци
- ▲ Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах
- ▲ Колоничлол
- ▲ "Колончлолын дараахи үе"



Сэдвийн агуулга

- ▲ Феминист философийн үндэслэлүүд
- ▲ Хүйсээр, насаар, арьс өнгөөр, нийгмийн гарлаар, бэлгийн хандлагаар гэх мэт аливаа төрлийн нийгмийн ялгаварлан гадуурхах үзлийг эрх зүйн үүднээс няцаах нь



Хэлэлцүүлгийн асуултууд

- ▲ Хүйс, жендер хэмээх ойлголтуудын ялгааг тайлбарла.
- ▲ Эмэгтэй субъект хэмээх ойлголтын агуулгыг тайлбарла
- ▲ "Ондоон хэмээх ойлголтын утга юунд орших вэ?
- ▲ Бие хэмээх ойлголт юуг илэрхийлж байна вэ?
- ▲ Шоовдор байдал, децентраци хэмээх хоёр ойлголтыг харьцуулан ярилц
- ▲ Биологийн ялгаа, нийгмийн ялгаа хоёр адил уу?
- ▲ Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн төлөө тэмцэл, сонгуульд квот тогтоох асуудлаар ярилц
- ▲ 1882 онд хятад гаралтай америкчуудын шүүхдэх эрхийг хориглосон хууль гарсан, Дэлхийн II дайны үед япон гаралтай америкчуудыг тусгаарлан хорьж байсан талаар өөрсдийн үзлээ илэрхийл



Ном зүй

1. Д.Боаз. Либертарианизм. /орч Б.Батчулуун. УБ., 2005.
2. Философи эхлэн сурах бичиг. Нээлттэй философи нийгэмлэг. УБ., 2000.
3. З.Жоннатон Вольф. Улстөрийн философийнудиртгал. /орч Б.Батчулуун/. УБ., 2002.
4. Платон. Төр улс. /грек хэлнээс орч Отгонтуяа. УБ., 2004.
5. С. Де Бовуар. Второй пол. /пер. с. Фр/. М., 1998.
6. Сумерки богов. М., 1989.
7. G.Lee Bowie, Meredith W Michaels, Robert C. Solomon. Twenty Questions. An Introduction to Philosophy. 1996.
8. Ed. L.Miller. Questions that matter. McGraw-Hill., 1996.
9. Mortimer J Adler. How To Think About The Great Ideas. Open Court., 2000.
10. Samuel Enoch Stumpf. Elements of Philosophy. McGraw-Hill., 1993.

IV бүлэг. МЕТАФИЗИК, ОНТОЛОГИ

Сэдэв 1. Метафизик, онтологи

Зорилго:

Философийн онолын мэдлэгийн цом хэсэг болох бодит байдлын уг чанарын тухай сургаал, ахуй ба түүний төрлүүд, тэдгээрийн мөн чанар, харилцаа, шалтгаал, орон, цаг зэргийн тухай философи онолын суурь мэдлэгтэй болно.

Ямар асуудлыг философийн асуудал гэж үзэх вэ? гэдэгт хариулт өгөх чадвартай болно.

Бодит байдлын тухай суурь асуудлууд, тэдгээрт нэгэн утгатай хариулт өгөх нь нэн бэрх болохыг ойлгосноор аливаа асуудлыг олон талаас нь авч үзэж, ул суурьтай, нухацтай эргэцүүлдэг болох, асуудалд философийн үүднээс ханддаг болох суурь тавигдана.



Нэр томъёо

- ▲ Ахуй, оршихуй
- ▲ Байгаль
- ▲ Матери
- ▲ Нийгэм
- ▲ Хүн
- ▲ Орон зай, цаг хугацаа
- ▲ Шалтгаан
- ▲ Универсали
- ▲ Хөдөлгөөн
- ▲ Оюун ухаан
- ▲ Мэдлэг
- ▲ Сэтгэц (психик)
- ▲ Ухамсар
- ▲ Эзэн-бурхан



Сэдвийн агуулга

- ▲ "Метафизик" хэмээх ойлголтын олон утга
- ▲ Бодит байдлын тухай асуудал: нэг ба олон, өөрчлөлт ба тогтвортой байдал, шалтгаан, зарчим, мөн чанар, бодит байдал, харагдахуй / санагдахуй
- ▲ Оюун ухаан-бие махбодь. Материализм, идеализм, шашны трансцендентализм, монизм, плюрализм (дуализм)
- ▲ Ахуй ба хоосон. Юу оршдог вэ?
- ▲ Матери, байгаль, нийгэм, хүн, сэтгэхүй, ухамсар, сэтгэц, сүнс
- ▲ Хөдөлгөөн, орон зай, цаг хугацааны асуудал
- ▲ Эзэн-Бурханы /God-ийн/ оршихуйн асуудал



Хэлэлцүүлгийн асуултууд

1. Юу оршин байдаг вэ?
2. Зөвхөн физик объектууд л оршдог уу?
3. "Ахуй", "хоосон" гэдэг ойлголтууд ямар харьцаатай вэ?
4. Монизм, плюрализмын ялгааг гаргана уу?
5. "Материализм", "идеализм" хэмээх ойлголтуудыг тодорхойлно уу?
6. Объектив идеализмын онтологи утгыг тайлбарлана уу?
7. Субъектив идеализмын гносеологи утгыг тайлбарлана уу?
8. Юмс тогтвортой байдлаа хадгалдаг уу? Эсвэл байнга өөрчлөгддөг үү?
9. Эзэн-Бурханы асуудал яагаад метафизик асуудал болдог вэ?
10. Мэдлэг, танин мэдэхүйн асуудал яагаад метафизикийн хүрээнд яригддаг вэ?



11. Метафизик хэмээх ойлголтын олон утгыг тайлбарла
12. Оюун ухаан, ухамсар, сэтгэл, сүнс, ухамсаргүй сэтгэл гэх мэт ойлголтуудын ялгааг гарга
13. Эзэн-Бурхан /God/ байдаг уу?
14. Аливаа үйл явдал бүхэн шалтгаантай юу?
15. Үйл явдлуудыг зайлшгүйгээр холбож өгдөг шалтгаант харилцаа байдаг уу?, чанар ба харилцаа нь тусгаар уу? эсвэл универсаль уу?
16. Хөдөлгөөн гэж юу вэ? юмсын өөрчлөлт ба тогтвортой байдлын харьцаа



Ном зүй

1. Философи эхлэн сурах бичиг. Нээлттэй философи нийгэмлэг. УБ., 2000.
2. Философи. Сурах бичиг. МУИС-ийн философийн тэнхим. УБ., 2002.
3. Мэл Томпсон. Философи (өөрөө сурах бичиг) /англи хэлнээс орчуулсан Б.Батчулуун/. УБ., 2001 он. 3. Оюун ухаан ба бие махбодь.
4. Ричард Поупкин, Аврум Стрел. Гүн ухаан. УБ., 1998.
5. Б.Рассел. Өрнийн мэргэн ухаан. /англи хэлнээс орч/ УБ., Монсудар. 2007.
6. Ed.L. Miller. Questions that matter. McGraw-Hill., 1996.
7. Robert Paul Wolff. About Philosophy. Prentice Hall., 1989.

V бүлэг. ЭПИСТЕМОЛОГИ

Сэдэв 1. Мэдлэгийн төрөл, хэлбэрүүд, тэдгээрийн харилцаа

Зорилго:

Мэдлэгийн төрөл хэлбэрүүд, хүрээ хязгаар, тэдгээрийн харилцааны талаар онолын суурь мэдлэг эзэмшинэ.

Мэдлэгийг ангилах, мэдлэгийн төрлүүдийг хооронд нь холбох, зааглан ялгах суурь чадвартай болно.

Онолын ба практик аливаа асуудал, түүнд холбогдох мэдээллүүдийг зөв ангилан ялгаж, үнэлэлт өгдөг хандлага төлөвшихөд тус болно.



Нэр томъёо

- ▲ Мэдлэг
- ▲ Ердийн мэдлэг
- ▲ Төрөлжсөн мэдлэг
- ▲ Шинжлэх ухааны мэдлэг
- ▲ Шинжлэх ухааны бус мэдлэг



Сэдвийн агуулга

- ▲ Мэдлэгийн ангиллын асуудал
- ▲ Мэдлэгийн төрлүүд: ердийн ба төрөлжсөн мэдлэг
- ▲ Төрөлжсөн мэдлэгийн төрлүүд: шинжлэх ухааны ба шинжлэх ухааны бус мэдлэг.

- ▲ Шинжлэх ухааны мэдлэгийн өвөрмөц онцлог
- ▲ Шинжлэх ухааны бус мэдлэгийн төрлүүд: философи, шашин, шидэт домог, уран сайхны танин мэдэхүй
- ▲ Философийн мэдлэгийн өвөрмөц онцлог
- ▲ Мэдлэгийн хүрээ хязгаарын тухай асуудал



Хэлэлцүүлгийн асуултууд

1. Мэдлэгийн ангиллын талаархи Аристотель, Бэкон нарын үзлийг харьцуул
2. Ердийн мэдлэгийн онцлог шинжүүдийг тоочно уу?
3. Төрөлжсөн мэдлэгийн онцлогийг ердийн мэдлэгтэй харьцуулан гаргана уу?
4. Шинжлэх ухааны ба шинжлэх ухааны бус мэдлэгийг харьцуулан ялгаатай шинжүүдийг тоочно уу?
5. Ямар нэгэн тодорхой асуулт дэвшүүлээд түүндээ шинжлэх ухааны, шашны, домгийн, философийн, уран сайхны хариултууд өгч, ялгааг нь харьцуул
6. Философийн мэдлэгийн онцлог шинжүүдийг тоочно уу?
7. Философийн ба шинжлэх ухааны мэдлэгийн нийтлэг болон ялгаатай шинжүүдийг тайлбарла
8. Философи ба шашны хоорондхи ялгаа болон төсөөг тайлбарла.
9. Урлаг-уран сайхны мэдлэг ба шидэт домгийн мэдлэгийг харьцуул.
10. П.Фейерабэнд: "шинжлэх ухаан бол шашнаас юугаараа ч давуу биш" гэсэн үгийн утгыг тайлбарлан ярилцана уу?



Ном зүй

1. Д.Баттөмөр. Логик, эпистемологи, шинжлэх ухааны философийн асуудлууд. УБ., 2005.
2. Философи эхлэн сурах бичиг. Нээлттэй философи нийгэмлэг. УБ., 2000.
3. Мэл Томпсон. Философи (өөрөө сурах бичиг). /Англи хэлнээс орчуулсан Б.Батчулуун/. УБ., 2001.
4. Ричард Поупкин, Аврум Стрел. Гүн ухаан. УБ., 1998.
5. Б.Рассел. Өрнийн мэргэн ухаан. /англи хэлнээс орч/ УБ., Монсудар. 2007.
6. Samuel Enoch Stumpf. Philosophical Problems. McGraw-Hill, 1994.

Сэдэв 2. Үнэний талаархи баримтлалууд, үнэний шалгуурын асуудал

Зорилго:

Эпистемологийн мөнхийн сэдэв болох үнэний асуудлаархи баримтлалуудын талаар онолын суурь мэдлэг эзэмшинэ.
Тохирох, зөвшилцөх, зөрчилгүй байх, шалгагдах зэрэг шалгууруудыг практик амьдрал дээр хэрэгжүүлэх чадвар бүхий болно.
Онолын ба практик аливаа асуудал, түүнд холбогдох мэдээллүүд дээр зөв ажиллаж, зөв үнэлэлт өгдөг хандлага төлөвшүүлэхэд тус болно.



Нэр томъёо

- ▲ Тохироо /корреспонд/
- ▲ Когерент чанар
- ▲ Объектын хэл
- ▲ Метахэл
- ▲ Үнэний логик шалгуур
- ▲ Верификаци
- ▲ Фальсификаци



Сэдвийн агуулга

- ▲ Үнэн гэж юу вэ?
- ▲ Үнэний корреспондент онол
- ▲ Үнэний когерент онол
- ▲ Үнэний семантик онол
- ▲ Үнэний шалгуурын тухай асуудал



Хэлэлцүүлгийн асуултууд

1. Үнэн бол мэдлэг бодит зүйлтэйгээ тохирох явдал биш гэж үздэг баримтлал байдаг уу?
2. Тохироо гэдэг ойлголтын утгыг тодруулна уу?
3. Зохицол гэдэг ойлголтын утгыг тодруулна уу?
4. Ашиг тус гэдэг ойлголтын утгыг тодруулна уу?
5. Үнэний шалгуурын асуудал яагаад философийн асуудал болдог вэ?
6. Үнэний шалгуурыг ангилсны суурь нь юу вэ?
7. Үнэний логик ба эмпирик шалгуурыг харьцуулан тайлбарла



Ном зүй

1. Д.Баттөмөр. Логик, эпистемологи, шинжлэх ухааны философийн асуудлууд. УБ., 2005.
2. Мэл Томпсон. Философи (өөрөө сурах бичиг) /Англи хэлнээс орчуулсан Б.Батчулуун/. УБ., 2001.
3. Б.Рассел. Өрнийн мэргэн ухаан. /англи хэлнээс орч/ УБ., Монсудар. 2007.
4. Ричард Поупкин, Аврум Строл. Гүн ухаан. УБ., 1998.
5. Философи. Сурах бичиг. МУИС-ийн философийн тэнхим. УБ., 2002.
6. Философи эхлэн сурах бичиг. Нээлттэй философи нийгэмлэг. УБ., 2000
7. Robert Paul Wolff. About Philosophy. Prentice Hall., 1989.

Сэдэв 3. Мэдлэгийн эх сурвалжийн тухай баримтлалууд

- Зорилго:** Мэдлэгийн эх сурвалжийн талаархи сонгодог фундаментализмын баримтлалууд ба И.Кантын эпистемологийн талаар онолын тодорхой мэдлэг олж авна.
- Олон төрлийн мэдээллээс зөв сонголт хийж, үнэлэх, тэдгээрийг ялгаж ангилах, зөв үнэлэх чадвартай болоход туслана.
- Онолын ба практик аливаа асуудал, түүнд холбогдох мэдээллүүд дээр зөв ажиллаж, зөв үнэлэлт өгдөг хандлага төлөвшүүлэхэд тус болно.



Нэр томъёо

- ▲ Сонгодог фундаментализм
- ▲ Эмпиризм
- ▲ Рационализм
- ▲ Tabula rasa
- ▲ Cogito ergo sum
- ▲ Априори ба апостериори мэдлэг
- ▲ Цэвэр ба туршлагын мэдлэг
- ▲ Аналитик ба синтетик хэллэг



Сэдвийн агуулга

- ▲ Эмпиризм: мэдрэхүйн туршлага бол мэдлэгийн эх сурвалж мөн
- ▲ Рационализм: оюун ухаан бол жинхэнэ мэдлэг олох эх сурвалж мөн
- ▲ Эпистемологид И.Кантын хийсэн Коперникийн эргэлт
- ▲ Априори ба апостериори мэдлэг
- ▲ Аналитик ба синтетик бодомж



Хэлэлцүүлгийн асуултууд

1. Мэдлэг юунаас үүсдэг вэ? Түүний үндэс суурь юу вэ?
2. Бид мэдлэгийнхээ үнэн эсэхэд хэрхэн итгэж, үнэмших вэ?
3. Tabula rasa хэмээх ойлголтын утгыг тайлбарла
4. Дж.Локкын мэдрэхүйн тухай үзлийн утгыг тайлбарла
5. Эмпирицизийн үзлийг өмгөөлөх үндэслэлүүд дэвшүүл
6. Р.Декарт ямар үндэслэлээр мэдрэхүйн өгөгдхүүнийг үгүйсгэсэн вэ?
7. Рационализмын үзлийг өмгөөлөх үндэслэлүүд дэвшүүл
8. "Хун цагаан", " $2 \times 2 = 4$ ", "Ертөнцийн эзэн байдаг" гэсэн бодомжийн ялгааг гаргана уу?
9. Яагаад И.Кантыг эпистемологид Коперникийн хувьсгал хийсэн гэдэг вэ?
10. Аналитик ба синтетик бодомжийн жишээ гарга
11. Априори синтетик бодомжийн жишээ гарга
12. Аналитик ба априори бодомжийн ялгааг тодруул
13. Репрезентаци хэмээх ойлголтын утгыг тодруулан тайлбарла.



Ном зүй

1. Д.Баттөмөр. Логик, эпистемологи, шинжлэх ухааны философийн асуудлууд УБ., 2005.
2. Мэл Томпсон. Философи (өөрөө сурах бичиг) /Англи хэлнээс орчуулсан Б.Батчулуун/. УБ., 2001.
3. Ричард Поупкин, Аврум Строл. Гүн ухаан. УБ., 1998.
4. Б.Рассел. Өрнийн мэргэн ухаан. /англи хэлнээс орч/ УБ., Монсудар. 2007.
5. Философи. Сурах бичиг. МУИС-ийн философийн тэнхим. УБ., 2002.
6. Философи эхлэн сурах бичиг. Нээлттэй философи нийгэмлэг. УБ., 2000.
7. G. Lee Bowie, Meredith W Michaels, Robert C. Solomon. Twenty Questions. An Introduction to Philosophy. 1996.
8. Ed. L.Miller. Questions that matter. McGraw-Hill., 1996.
9. Robert Paul Wolff. About Philosophy. Prentice Hall., 1989.

ҮІ бүлэг. ШАШНЫ ФИЛОСОФИ

Сэдэв 1. Шашны философи асуудлууд

Зорилго:

Шашны философийн зарим суурь асуудал, ойлголт, зарчимтай танилцсаны үндсэн дээр шашны мөн чанар, нийгэмд эзлэх байр суурийн талаар ерөнхий мэдлэгтэй болно.

Шашны үүрэг, ач холбогдлыг нийгмийн бол он ёс суртахууны үүднээс зөв, зүйтэй авч үзэх чадвар хөгжинө. Өөрийн итгэл үнэмшилд шүүмжлэлтэй, бүтээлчээр хандаж, бусдын үзэл бодлыг тэвчин хүндэтгэлтэй ханддаг болоход тусална.



Нэр томъёо

- ▲ God /Эзэн-Бурхан/
- ▲ Нирвана буюу гэгээрсэн хүмүүн
- ▲ Итгэл бишрэл
- ▲ Оюун ухаан
- ▲ Сүнс
- ▲ Хойд насны амьдрал
- ▲ Нүгэл
- ▲ Эзэн-Бурханы оршихуй
- ▲ Агностицизм



Сэдвийн агуулга

- ▲ Шашны тухай философийн болон шинжлэх ухааны тайлбарууд
- ▲ Шашны философи, теологи ба теософийн харьцаа.
- ▲ Теист бишрэлийн хэлбэрүүд: политеизм, битеизм, монотеизм, пантеизм, деизм
- ▲ Эзэн-Бурхан (God) гэж юу вэ? түүний оршихуйн нотолгоо /

онтологийн, космологийн, телеологийн, ёс зүйн ба прагматик нотолгоо/ ба тэдгээрийн няцаалтууд

- ▲ Сүсэг бишрэл ба танин мэдэхүй /2 үнэний тухай Фомагийн үзэл ба фидеизм/
- ▲ Шашныг шүүмжилдэг сургаалиуд (Ксенофон, П.Абельяр, Ж.Кальвин, Д.Юм, Л.Фейрбах, К.Маркс, Ф.Ницше, Ж.П.Сартр гэх мэт)
- ▲ Шашин ба ёс суртахуун



Хэлэлцүүлгийн асуултууд

1. Шашны философи, теологи хоёрын төсөөтэй хийгээд ялгаатай тал нь юу вэ?
2. Шашны тухай философи тайлбаруудын онцлог юу вэ?
3. Шашны философи нь метафизикийн бүрэлдэхүүнд орох уу? Яагаад?
4. Политеизм, битеизм, монотеизм, пантеизм, деизмийн утгыг тус бүрд нь тайлбарлана уу?
5. Дээд нээгдэл, агностицизм хэмээх ойлголтуудын утгыг тайлбарлана уу?
6. Сүсэг бишрэл ба танин мэдэхүй хоёр харилцан бие биетэйгээ зөрчилддөг үү?
7. Шашны талаарх Ксенофон, П.Абельяр, М.Лютер, Ж.Кальвин, Д.Юм, Л.Фейрбах, К.Маркс, Ф.Ницше, Ж.П.Сартр нарын шүүмжлэлийн гол утга санааг тус бүрд нь тайлбарлана уу?



Ном зүй

1. Философи эхлэн сурах бичиг. Нээлттэй философи нийгэмлэг. УБ., 2000.
2. Мэл Томпсон. Философи (өөрөө сурах бичиг) /Англи хэлнээс орчуулсан Б.Батчулуун/. УБ., 2001.
3. Ричард Поупкин, Аврум Стрел. Гүн ухаан. УБ., 1998.
4. Б.Рассел. Өрнийн мэргэн ухаан. /англи хэлнээс орч/ УБ., Монсудар. 2007.
5. И.Н.Яблоков. Религиоведение. М., 1998.
6. Ed. L.Miller. Questions that matter. McGraw-Hill., 1996.
7. Philosophical Entrees. Classical and Contemporary Reading in Philosophy. Ed by Dale Jacquette. McGraw-Hill., 2001. Part 6.
8. Samuel Enoch Stumpf. Elements of Philosophy. McGraw-Hill., 1993.
9. Robert Paul Wolff. About Philosophy. Prentice Hall., 1989.
10. Thomas D.Davis. Philosophy. An Introduction through original fiction, discussion and readings. McGraw-Hill., 1993.



Сэдэв 2. Монголын буддист философи

Зорилго:

Монголын уламжлалт нийгмийн философи сэтгэлгээний гол төлөөлөл болох монголын буддист философийн үндсэн баримтлал, ойлголтуудын талаар мэдлэгтэй болж, монголчуудын уламжлалт философи сэтгэлгээний асуудлуудаар эргэцүүлэх, өөрийгөө илэрхийлэх, бусдын үзэл бодлыг хүндэтгэх, чадвараа хөгжүүлнэ.



Нэр томъёо

- ▲ Оногдохуй
- ▲ Онохуй
- ▲ Махбодь
- ▲ Баригдахуй
- ▲ Тоос
- ▲ Бүдүүн тоос
- ▲ Нарийн тоос
- ▲ Маш нарийн тоос
- ▲ Бие
- ▲ Сэтгэл
- ▲ Оюун
- ▲ Бодгаль
- ▲ Төв үзэл
- ▲ Хоосон чанар



Сэдвийн агуулга

- ▲ Монголд буддист философи үүсэж дэлгэрсэн түүхэн нөхцөл
- ▲ Алшаа лхарамба Агваандандарын философи үзэл
- ▲ Хамбо номун хан Агваанхайдавын философи үзэл
- ▲ Тунгалаг цорж Агваанбалдангийн философи үзэл
- ▲ Заваа Дамдин гавжийн философи, логик үзэл



Хэлэлцүүлгийн асуултууд

1. Агваандандарын философи үзлийн уг сурвалж болсон зохиолуудыг нэрлэ.
2. Түүний "маш нарийн тоос" гэдэг философи ойлголтын агуулгыг тайлбарлана уу?
3. Агваандандарын "баригдахуй" гэдэг ойлголтын агуулгыг илэрхийлнэ үү?
4. Агваанхайдав бие, сэтгэл, бодгаль, оюун 4-ийн яриагаар ямар философи үзэл илэрхийлсэн вэ?
5. Махбодийн тухай Агваанбалдангийн үзлийн онцлог юу вэ?
6. Заваа гавж Дамдингийн "Дүра зациг" бүтээл дэх философи ойлголтуудын агуулгыг тайлбарлана уу?
7. Заваа гавж "Төв үзлийн шашдир нягтад сүлжсэн аргамжийн тайлбар" бүтээлдээ буддист философи, логикийн асуудлыг хэрхэн авч үзсэн вэ?



Ном зүй

1. Д.Дагвадорж. Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлиг. УБ., 1998.
2. Ч.Жүгдэр. Тунгалаг цорж Агваанбалдан. /Монголын философийн түүх (ХҮИ-ХИХ зуун. II хэсэг, 4-р дэвтэр. УБ., 2001. 293-328 дахь тал).
3. Т.Содномдаргиа. Алшаа лхарамба Агваандандар. - мөн тэнд, 184-207 дахь тал.
4. Т.Содномдаргиа. Хамбо номун хан Агваанхайдав. -мөн тэнд. 267-293 дахь тал.
5. С.Янжинсүрэн. Заваа Дамдин гавж. - мөн тэнд, 373-399 дэх тал.
6. Т.Содномдаргиа. Монголын гүн ухааны сэтгэлгээний түүх. Философи. Сурах бичиг. УБ., 2002. III бүлэг.
7. Монголын философийн түүх. /ШУА. ФСЭХ/. УБ., 2001. III, IV дэвтэр.

VII бүлэг. ҮНЭЛЭМЖИЙН ОНОЛ

Сэдэв 1. Үнэлэмжийн тухай философи баримтлалууд

Зорилго:

Үнэлэмжийн мөн чанар, бүтэц, олон янз байдал, ангилалын тухай онолын суурь мэдлэгтэй болно. Монголчуудын болон бусад ард түмний уламжлалт хийгээд өнөөгийн үнэлэмжийн тогтолцооны ялгаатай, төсөөтэй талуудыг эргэцүүлэх, үнэлж дүгнэх чадварыг эзэмшинэ.



Нэр томъёо

- ▲ Үнэлгээ
- ▲ Үнэлгээний объект
- ▲ Үнэлгээний субъект
- ▲ Үнэлэмж



Сэдвийн агуулга

- ▲ Танин мэдэхүй ба үнэлэмж
- ▲ Үнэн ба үнэлгээ
- ▲ Үнэлэмжийн төрлүүд
- ▲ "Үнэлэмж" гэдэг ойлголтын үүсэл, хөгжил, үнэлэмжийн тухай тодорхойлолт.
- ▲ Үнэлэмжийн логик бүтэц.
- ▲ Үнэлэмжийн тухай объектив ба субъектив үзэл.
- ▲ Үнэлэмж ба зорилго, чин эрмэлзлэл. Үнэлэмж ба ашиг тус
- ▲ Үнэлэмжийг ангилахуй



Хэлэлцүүлгийн асуултууд

1. "Үнэн", "үнэлгээ" гэдэг ойлголтууд ямар харьцаатай вэ?
2. Танин мэдэхүй", "үнэлэмж" гэдэг ойлголтууд ямар харьцаатай вэ?
3. Үнэлэмж гэж юу вэ?
4. Дараах ойлголтуудын ялгааг гарга:
 - Үнэлэмж ба үзэл бодол
 - Үнэлэмж ба таашаал
 - Үнэлэмж ба хүсэл
 - Үнэлэмж ба үнэ цэнэ
 - Үнэлэмж ба үнэлгээ
 - Үнэлэмж ба ашиг
 - Үнэлэмж ба хэрэгцээ
 - Үнэлэмж ба бишрэл
5. Үнэлэмж логик бүтцээрээ ямар ямар элементтэй вэ?
6. "Монголын нууц товчоонд буй гол гол үнэлэмжийг тоочно уу?
7. Монголын өнөөгийн нийгэмд бүрэлдэж буй үнэлэмжийн тогтолцоон дахь эерэг, сөрөг гол гол үнэлгээг тоочно уу?

Ном зүй

1. Ц.Баатартогтох. Монголчуудын үнэлэмжийн судалгааны философийн асуудал. Диссертаци. УБ., 2000.
2. Б.Рассел. Өрнийн мэргэн ухаан. /англи хэлнээс орч/ УБ., Монсудар. 2007.
3. Философи эхлэн сурах бичиг. Нээлттэй философи нийгэмлэг. УБ., 2000.
4. Философи. Сурах бичиг. МУИС-ийн философийн тэнхим. УБ., 2002.
5. Всемирная энциклопедия. Философия. М.,-АСТ.-Мн.-Харвест., 2001.
6. Ed. L.Miller. Questions that matter. McGraw-Hill., 1996.
7. The Cambridge Dictionary of Philosophy. Cambridge UP., 1999.

VIII бүлэг. УРЛАГИЙН ФИЛОСОФИ

Сэдэв 1. Урлагийн философи асуудлууд

Зорилго: Орчин үеийн урлагийн философийн үндсэн ойлголтууд, гоо сайхны үнэлэмж, урлан бүтээх үйл ажиллагааны мөн чанар зэргийн талаар суурь мэдлэгтэй болно.

Урлагийг хүний танин мэдэхүйн болон практикийн бусад төрлүүдээс ялгах, урлагийн хэл, урлагийн бүтээлийн илэрхийллийн үнэлгээний ердийн болон онолын түвшингүүдийг ялгах чадвартай болно.

Урлагийн бүтээлийн илэрхийллийн олон янз байдлыг хүлцэн ойлгодог болоход тус болно.



Нэр томъёо

- ▲ Урлаг ба урлан бүтээх үйл ажиллагаа
- ▲ Салалт
- ▲ Үл сонирхохуй
- ▲ Илэрхийлэл
- ▲ Формализм
- ▲ Тайлбарлахуй
- ▲ Дууриалт
- ▲ Халдварлал



Сэдвийн агуулга

- ▲ Урлаг гэж юу вэ?
- ▲ Урлагийн "хэл"
- ▲ Урлагийн бүтээлийн илэрхийллийн асуудал
- ▲ Урлагийн бүтээлийн үнэлэмж, шалгуур
- ▲ Урлагийн бүтээлийн интринсик хийгээд экстринсик тодорхойлолтууд
- ▲ Салалт, үл сонирхохуй
- ▲ Урлагийн бүтээлийн агуулга, хэлбэрийн асуудал
- ▲ Сюзан Сонтаг, А.Брадлэй нарын үзэл
- ▲ Уран бүтээл бол сэтгэлийн хөдөлгөөний илэрхийлэл (Толстой)
- ▲ Өөрөөр өөрийн төлөө орших зүйл буюу "цэвэр урлаг"
- ▲ Урлагийн бүтээлийг үгээр тайлбарлахуйн эсрэг



Хэлэлцүүлгийн асуултууд

1. Урлагийн философи гэж юу вэ? ямар асуудлуудыг авч үздэг вэ?
2. Урлагийн философийн үндсэн ойлголтууд, тэдгээрийн агуулга
3. Урлагийн бүтээлд объектив шалгуур байдаг уу?
4. Урлаг нь оюун санааны зүйл үү? Эсвэл материаллаг зүйл үү?
5. Урлаг гоо сайхны тухай уламжлалт ойлголтыг шүүмжилсэн Толстойн шүүмжлэлийн утгыг тайлбарла
6. Сонтаг тайлбарлахуйд ямар аюул байна гэж үзсэн вэ?
7. Брадлэйн эсэргүүцэийн утгыг тайлбарла
8. Бодитой оршин буй юмс үзэгдэл, урлагийн бүтээлийн агуулга хоёр ямар харьцаанд оршдог вэ?
9. Цэвэр урлаг, формализмын тухай ярилц



Ном зүй

1. Философи эхлэн сурах бичиг. Нээлттэй философи нийгэмлэг. УБ., 2000.
2. Мэл Томпсон. Философи (өөрөө сурах бичиг) /Англи хэлнээс орчуулсан Б.Батчулуун/ УБ., 2001.
3. Joseph Margolis, Art and Philosophy. Atlantic Highlands, NJ., 1980.
4. O.Hanfling (ed.), Philosophical Aesthetics: An Introduction. Oxford., 1992.
5. Thomas D.Davis. Philosophy. An Introduction through original fiction, discussion and readings. McGraw-Hill., 1993.
6. Robert Paul Wolff. About Philosophy Prentice Hall., 1989.



XI бүлэг. ӨНӨӨГИЙН ФИЛОСОФИ ЗАРИМ ЧИГЛЭЛҮҮД

Сэдэв 1. Орчин үеийн философи үндсэн баримтлалууд I

Зорилго:

Орчин үеийн философийн гол гол чиглэлийн талаар мэдлэгтэй болж, тэдгээр тус бүрийн арга зүйн үүднээс асуудлыг авч үзэх ерөнхий чадварыг эзэмшиж, аливаа асуудлыг олон талаас нь авч үзэх ерөнхий чадварыг эзэмшиж, аливаа асуудлыг олон талаас нь, ул суурьтай, нухацтай эргэцүүлдэг болох, асуудалд философийн үүднээс ханддаг болох хандлага төлөвшинө.



Нэр томъёо

- ▲ Үүргийн ач холбогдол
- ▲ Инструментализм
- ▲ Хэл
- ▲ Ойлгохуй
- ▲ Герменевтик тойрог
- ▲ Логик атомизм
- ▲ Логик позитивизм
- ▲ Верификаци
- ▲ Фальсификаци
- ▲ Молекулан өгүүлбэр
- ▲ Атоман өгүүлбэр
- ▲ Шинжлэх ухааны мэдлэгийн өсөлт
- ▲ Аргазүйн анархизм
- ▲ Шинжлэх ухааны хувьсгал



Сэдвийн агуулга

- ▲ Орчин үеийн философи
- ▲ Прагматизм: С.Пирс, У.Джеймс, Дж.Дьюи нарын философи үзэл
- ▲ Непозитивизм: М.Шлик, Р.Карнап, А.Тарский
- ▲ Постпозитивизм: К.Поппер, Т.Кун, П.Фейерабенд
- ▲ Герменевтик философи: Ф.Шлейермахер, Г.Гадамер



Хэлэлцүүлгийн асуултууд

1. Прагматизм гэж юу вэ?
2. Прагматизм дахь үнэний тухай асуудлыг тодорхойлно уу?
3. Плюралист ертөнцийн тухай прагматист онолын агуулга
4. Дьюигийн инструменталист онолын аргазүйн онцлог
5. Боловсролын философийн Дьюигийн үзлийн онцлог, нийгмийн ач холбогдол
6. Б.Рассел, Л.Витгенштейн нарын боловсруулсан логик атомизмын зарчмуудыг нэрлэ.
7. Ертөнц бол баримтуудаас тогтдог бөгөөд эдгээр баримтууд нь атоман бүтэцтэй гэдгийг тайлбарлана уу?

8. Логик позитивизмын зорилгыг тодорхойлно уу
9. Верификацийн зарчим гэж юу вэ, түүний дэвшилтэт болон дутагдалтай талууд
10. Постпозитивизмын гол гол төлөөлөгчдийн дэвшүүлсэн философи зорилгыг нь тодорхойлж өгнө үү?
11. Фальсификацийн зарчим гэж юуг хэлэх вэ, түүний арга зүйн ач холбогдлыг тодорхойлно уу?
12. Терменевтик тойрог" гэдэг ойлголтын утгыг хэрхэн тайлбарлаж болох вэ?



Ном зүй

1. Философи эхлэн сурах бичиг. Нээлттэй философи нийгэмлэг. УБ., 2000.
2. Философи. Сурах бичиг. МУИС-ийн философийн тэнхим. УБ., 2002.
3. Батын Ч.Ган-Өлзий. Эдүгээгийн философид эхлэн орохын хураангуй. УБ., 2001.
4. Поупкин Р., Строл А. Гүн ухаан./орос хэлнээс орч/ УБ.,1998.
5. Б.Рассел. Өрнийн мэргэн ухаан. /англи хэлнээс орч/ УБ., Монсудар. 2007.
6. Гуннар Скирбек, Нилс Гилье. История философий. /пер с англ. М., 2000.
7. Философы XX века. М.,1999.
8. Реале Д. Антисери Д. Западная философия от истоков до наших дней. С-П., 1997. Т4.
9. Ильин. От структурализма к постструктурализму. М., 2000.
10. Рассел Б. История западной философий. М., 1999.
11. Мельвиль, Зотов. Западная философия XX века. М., 1998.
12. Samuel Enoch Stumpf. Philosophical problems. Prentice Hall., 1994.
13. Ed. L.Miller. Questions that matter. McGraw-Hill., 1996.

Сэдэв 2. Орчин үеийн философи үндсэн баримтлалууд II

Зорилго:

Орчин үеийн философийн гол гол чиглэлийн талаар мэдлэгтэй болж, орчин үеийн философийн арга зүйн үүднээс асуудлыг авч үзэх ерөнхий чадварыг эзэмшиж, аливаа асуудлыг олон талаас нь авч үзэх, ул суурьтай, нухацтай эргэцүүлдэг болох, асуудалд философийн үүднээс ханддаг болох хандлагатай болно.



Нэр томъёо

- ▲ Амьдралын төлөөх хүсэл эрмэлзлэл
- ▲ Эзэрхэх хүсэл
- ▲ Хүний оршихуй
- ▲ Ирмэгийн нөхцөлүүд
- ▲ Дур хүслээ хангах зарчим
- ▲ Бодит байдлыг харгалзах зарчим
- ▲ Либи́до



- ▲ Сублимаци
- ▲ Архетип
- ▲ Хамтын үл ухамсарлахуй
- ▲ Нийгмийн шинж
- ▲ Бүтэц
- ▲ Деконструкци
- ▲ Холизм
- ▲ Бинар эсрэгцэл



Сэдвийн агуулга

- ▲ Амьдралын тухай философи ба экзистенциализм
- ▲ Фрейдизм ба неофрейдизмын философи агуулга
- ▲ Постструктурализм ба постмодернизмын онцлог



Хэлэлцүүлгийн асуултууд

1. "Амьдралын төлөөх хүсэл эрмэлзлэл", "эзэрхэх хүсэл" гэдэг ойлголтын философи утгыг тайлбарлаж, амьдралын философийн ач холбогдлыг тодорхойлно уу?
2. Экзистенциалист философи дахь эрх чөлөө, хариуцлагын харилцаа, хамаарлын асуудал
3. Фрейд хүний сэтгэцийн загварыг бүтээх болсны учир шалтгаан юу вэ?
4. "Либи́до", "сублимаци" гэдэг ойлголтуудын харилцаа хамаарлаар соёлын үзэгдлүүдийн үүслийн асуудлыг хэрхэн тайлбарлаж болох вэ?
5. Неофрейдист үзлийн онцлог, фрейдизмаас ялгарах шинжүүдийг нэрлэ.
6. Деконструктивизм гэж юу вэ?



Ном зүй

1. Философи эхлэн сурах бичиг. Нээлттэй философи нийгэмлэг. УБ., 2000.
2. Философи. Сурах бичиг. МУИС-ийн философийн тэнхим. УБ., 2002.
3. Б.Батчулуун. Философи дахь хүний асуудал. УБ., 2001.
4. Батын Ч.Ган-Өлзий. Эдүгээгийн философид эхлэн орохын хураангуй. УБ., 2001.
5. Поупкин Р., Строл А. Гүн ухаан. УБ., 1998.
6. Б.Рассел. Өрнийн мэргэн ухаан. /англи хэлнээс орч/ УБ., Монсудар. 2007.
7. Гуннар Скирбек, Нилс Гилье. История философий. /пер с англ/. М., 2000.
8. Философы XX века. М., 1999.
9. Болынов Отто. Философия экзистенциализма. М., 1990.
10. Сумерки богов. М., 1989.
11. Реале Д. Антисери Д. Западная философия от истоков до наших дней. С-П., 1997.
12. Ильин. От структурализма к постструктурализму. М., 2000.

13. Рассел Б. История западной философий. М., 1999.
14. Мельвиль, Зотов. Западная философия XX века. М., 1998.
15. Samuel Enoch Stumpf. Elements of Philosophy. Prentice Hall., 1993.
16. G.Lee Bowie, Meredith W. Michaels, Robert. C. Solomon. Twenty Questions. An Introduction to Philosophy. USA., 1996.

Сэдэв 3. Орчин үеийн хүний философийн зарим чиглэл

Зорилго:

Орчин үеийн философи чиглэлүүд дотроос хүн түүний оршихуйн асуудлыг онцлон үздэг философи баримтлалуудын тухай мэдлэгээ баяжуулж, хүний амьдралын хамгийн эрхэм зорилго болох эрх чөлөөний талаар зөв ойлголттой болох, сонголт хийх, хариуцлага хүлээх чадварыг хөгжүүлж, аливаа асуудалд хүлээцтэй, шүүмжлэлт сэтгэлгээний үүднээс ханддаг болно.



Нэр томъёо

- ▲ Дазайн (Dasein)
- ▲ Ман
- ▲ Экзистенци
- ▲ Эрх чөлөө
- ▲ Сонголт
- ▲ Хүний сэтгэцийн загвар
- ▲ Либи́до
- ▲ Сублимаци
- ▲ Хамтын ухамсаргүй сэтгэл
- ▲ Нийгмийн шинж



Сэдвийн агуулга

- ▲ Психоанатитик философи
- ▲ Экзистенциагаст философн



Хэлэлцүүлгийн асуултууд

1. Би-ийн ахуйн талаархи экзистенциалист философичдын үзлийн нийтлэг болон ялгаатай талуудыг гарган тайлбарла
2. Экзистенциалист философи дахь хүний эрх чөлөө, хариуцлагын харилцаа хамаарлын асуудлыг тодорхой жишээн дээр тодруулна уу.
3. Фрейд хүний сэтгэцийн загварыг бүтээх болсны учир шалтааныг тайлбарла
4. "Либи́до", "сублимаци гэдэг ойлголтын харилцаа хамаарлаар соёлын үзэгдлүүдийн үүсгийн асуудлыг хэрхэн тайлбарлаж болох вэ?
5. Юнгийн философи дахь "хамтын ухамсаргүй сэтгэл гэж юуг хэлэх вэ, тэр нь хувийн ухамсаргүй сэтгэлээс юугаар ялгаатай вэ?
6. Юнгийн томъёолсон хүний сэтгэцийн хэв маягуудын ангилал, онцлогийн талаар ярилцана уу.



7. Ямар учраас Фроммын философийг "эрх чөлөөний философи" гэж нэрлэдэг вэ?
8. Фроммын тодорхойлсноор яагаад хүн эрх чөлөөнөөс зугтахыг эрмэлздэг вэ?
9. Фроммын философи дахь "нийгмийн шинжүүдийн хэв маягууд" гэдэг ойлголтын агуулга юунд орших вэ?



Ном зүй

1. Философи эхлэн сурах бичиг. Нээлттэй философи нийгэмлэг. УБ., 2000.
2. Философи. Сурах бичиг. МУИС-ийн философийн тэнхим. УБ., 2002.
3. Б.Батчулуун. Философи дахь хүний асуудал. УБ., 2001.
4. Батын Ч.Ган-Өлзий. Эдүгээгийн философид эхлэн орохын хураангуй. УБ., 2001.
5. Поупкин Р., Стрел А. Гүн Ухаан. УБ., 1998.
6. Б.Рассел. Өрнийн мэргэн ухаан. /англи хэлнээс орч/ УБ., Монсудар. 2007.
7. Философы XX века. М., 1999.
8. Реале Д. Антисери Д. Западная философия от истоков до наших дней. С-П., 1997.
9. Философы XX века. М., 1999.
10. Болынов Отто. Философия экзистенциализма. М., 1990.
11. Сумерки богов. М., 1989.
12. Ильин. От структурализма к постструктурализму. М., 2000.
13. Рассел Б. История западной философий. М., 1999.
14. Мельвиль, Зотов. Западная философия XX века. М., 1998.
15. Samuel Enoch Stumpf. Philosophical problems. McGraw-Hill., 1994.
16. Ed.L. Miller. Questions that matter. McGraw-Hill., 1996.
17. G.Lee Bowie, Meredith W. Michaels, Robert. C. Solomon. Twenty Questions. An Introduction to Philosophy. USA, 1996.

Сэдэв 4. Герменевтик, Постструктурализм, Постмодернизм

Зорилго: Герменевтик, постструктурализм, постмодернизмын үндсэн баримтлалуудын тухай суурь мэдлэг эзэмшиж, утгыг тайлах арга, техник болон орчин үежсэний дараах үеийн нийгэм, соёлын төлөв байдлыг ойлгох чадвартай болж, асуудлыг постмодерн байдлаар авч үзэх хандлагатай болно.



Нэр томъёо

- ▲ Герменевтик эргэлэг (тойрог)
- ▲ Герменевтик гурвалжин
- ▲ Дивинаци
- ▲ Эдүгээчлэхүй

- ▲ Хэл, ойлгохуйн харилцаа
- ▲ Эрхзүйн герменевтик
- ▲ Текст
- ▲ Фаллогоцентризм ба бинар харшуулал
- ▲ Деконструкци
- ▲ Differance
- ▲ Мөр
- ▲ Гүйцээлт
- ▲ Төвийг эвдэхүй
- ▲ Хэрцгий үзэгдлийн театр
- ▲ Ялгаа ба давталт
- ▲ Сахилга ба шийтгэл: шоронгийн үүсэл
- ▲ Постмодерн ба постмодернизм
- ▲ Мета-өгүүлэлд үл итгэхүй
- ▲ Паралогиор хуульчлахуй
- ▲ Хожуу үеийн капитализмын соёлын логик
- ▲ Симуляцийн эрин
- ▲ Хэт бодит байдал



Сэдвийн агуулга

- ▲ Бүхэл, хэсгийн харилцаа
- ▲ Зохиогч, текст, тайлбарлагч гурвын харилцаа
- ▲ Цаг хугацаа, нөхцөл байдлын ялгааг даван туулж тайлбарлагч өөрийгөө зохиогчийн оронд тавих нь
- ▲ Текстийг ямар байснаар нь биш харин одоогийн нөхцөл байдлын үүднээс шинээр ойлгох
- ▲ Ойлгохуйг хэл бүрэн илэрхийлж чадах эсэх
- ▲ Хуулийн тайлбарлал
- ▲ Илэрхийлэгдэх бүхнийг текст хэмээн үзэж болох эсэх;
- ▲ Бүхнээс утга учир хайхыг үгүйсгэх үндэс
- ▲ Асуудлыг эсрэг тэсрэг байрлалд тавьж үзэхийн дутагдалтай тал
- ▲ Өмнөх бүхнийг хуучин суурин дээр нь шинээр ухаарах
- ▲ Утга гээгдэх/зөрөх, утгыг нөхөн гүйцээх
- ▲ Утгын үл шалтгаацил
- ▲ Уншигчид эрх чөлөө олгох
- ▲ Зохиогчийг утга бүтээхүйн төвөөс авч хаях
- ▲ Эрх мэдэл, эрдэм мэдлэг хоёрын холбоо шийтгэлийн тогтолцоонд хэрхэн өөрчлөгдөж ирсэн тухай
- ▲ Эрүү шүүлтээс дүрэм журамд шилжсэн шилжилтийн утга холбогдол
- ▲ Бүхнийг тохируулдаг, бүхнийг хуульчилдаг дээд өгүүлэл боломжгүй тухай
- ▲ Зөвшилцөлөөр асуудлыг шийдэх нөхцөл үгүй тухай
- ▲ Капитализмын хөгжлийн гурван үе, түүний техник технологи, соёлын хөгжлийн онцлог
- ▲ Жинхэнээсээ үл ялгарах байдал, хуулбар нь бодит байдлын тусгал байхаа больж өөрөө бодит байдал болсон тухай



Хэлэлцүүлгийн асуултууд

1. Герменевтик эргэлзгээс гарч болох уу? Яаж?
2. Хуулийн тайлбарлалд дивинацийн болон эдүгээчлэх зарчмын аль нь тохиромжтой вэ? Яагаад?
3. Ойлголт өөрчлөгдөх тохиол бий. Харин үндсэн хуулинд тусгагдсан ойлголт өөрчлөгдвөл яах бэ?
4. Хуулийг цоорхойгүйгээр боловсруулах боломж бий юу?
5. Хууль санаачлагч нь санамсаргүйгээр хуулинд цоорхой гаргачихаж. Тэрээр хариуцлага хүлээх ёстой юу? Үүнийг санаатайгаар хийсэн тохиолдолд яах бол?
6. Эрүүдэж шийтгэхийг хоригложээ. Ингэснээр хууль, хүчний байгууллагын тогтолцоо хөгжсөн өнөө үед гэм хийсэн хүний зэмийг бодитойгоор хүлээлгэж чадахгүй болчих юм биш биз?
7. Паралогиор хуульчлах зарчим хуулийн хувьд хэрэгжих үү?
8. Постструктурализм, постмодернизм хоёрын зарчмын ялгаа юу вэ?



Ном зүй

1. Философи. Сурах бичиг. МУИС-ийн философийн тэнхим. УБ., 2002.
2. Батын Ч.Ган-Өлзий. Эдүгээгийн философид эхлэн орохын хураангуй. УБ., 2001.
3. Поупкин Р., Строл А. Философия. М., 1997.
4. Философы XX века. М., 1999.
5. Реале Д. Антисери Д. Западная философия от истоков до наших дней. С-П., 1997.
6. Философы XX века. М., 1999.
7. Gregory Leyh (editor) Legal Hermeneutics: History, Theory, and Practice. Berkeley: University of California Press., 1992.
8. Derrida Jacques. Writing and Difference. Chicago: University of Chicago Press, 1978
9. Lyotard Jean-Francois. The Postmodern Condition. Minneapolis: University of Minnesota Press, 1984.

Философийн хичээлийн заах арга зүй

Философи хичээлийн арга зүйд тавигдах шаардлага

Философи хичээлийг судлах үндэслэл, хичээлийн зорилго, зорилттой уялдан уг хичээлийг заах арга зүйд дараахи шаардлага тавигдана. Үүнд:

1. Хичээлийн зорилгыг хангахуйц арга, хэлбэрийг сонгох, тэр нь хичээлийн агуулгад тохирсон байх
2. Философи хичээлээр эзэмшсэн мэдлэгээ хэрэглэх, асуудалд дүн шинжилгээ хийх чадвар суулгах нөхцөл боломжийг хангах
3. Оюутнууд хичээлд жигд, идэвхитэй оролцох боломж, нөхцөлийг бүрдүүлэх

Мэдээлэл түгээх аргууд

1. Лекцийн арга

Лекцийн арга нь мэдээлэл түгээхэд зонхилон хэрэглэгддэг аргуудын нэг юм. Энэхүү аргын гол зорилго нь хэвлэгдээгүй, нийтийн хүртээл болоогүй мэдээллийг дамжуулах, ол он эх сурвалжаас авсан мэдээллийг нэгтгэн дүгнэж оюутнуудад хүргэх явдал байдаг. Ялангуяа ном, сурах бичиг гэх мэт мэдээллийн эх сурвалж, тэдгээрийг ашиглах оюутны хэлний болон бусад чадвар хомс үед лекцийн аргаар оюутанд хүрч буй мэдээлэл нь маш чухал юм.

Лекцийн бүрэлдэхүүн

▲ Удиртгал (Эхний 5-10 минут)

Удиртгал хэсгийн гол зорилго нь хичээлийн сэдэв, зорилго, ерөнхий тоймыг оюутнуудад танилцуулах, тухайн хичээлийн сэдэвтэй холбоотой өмнөх мэдлэгийг нь сэргээн сануулах, тодорхой асуудал дэвшүүлэх замаар оюутнуудын анхаарлыг хичээлд төвлөрүүлж, сурах сэдлийг нь төрүүлэх явдал юм. Удиртгал хэсэг бол лекцийн хичээлийн цаашдын уур амьсгал, ерөнхий хандлагыг тодорхойлдог тул нэлээд чухал хэсэгт тооцогддог байна.

▲ Үндсэн хэсэг (55-60 минут)

Лекцийн үндсэн хэсэг нь бүхэлдээ тухайн хичээлийн гол агуулгыг хамардаг. Энэ хэсэг нь хичээлийн цагийн ихэнхийг эзэлдэг учраас удиртгал ба дүгнэлтийг бодвол илүү их цаг хугацаа, заах арга барицыг шаарддаг юм.

Лекцийн материал нь хичээлийн сэдэвтэй холбоотой ойлголт, зарчим, онол, баримт, үзүүлэнгээс тогтдог. Лекцийн явцад багш үндсэн ойлголтуудыг тодорхойлох замаар танилцуулж, дараа нь тэдгээртэй холбоотой тодорхой жишээ, баримт, тохиолдлуудыг дурдаж өгөх нь зүйтэй. Мөн лекцийн хичээлээр өгч байгаа ойлголт, үзэл санаануудыг хооронд нь дэс дараалсан /он дараалал болон шалтгаан, үр дагавраар нь/ байдлаар, харьцуулалт хийх замаар холбож өгөх хэрэгтэй юм.



▲ Дүгнэлт (15-20 минут)

Лекцийн хичээл дээр дүгнэлтийг анзаарахгүйгээр орхих нь бий. Дүгнэлт хэсэг багшийн өгсөн мэдээллээс оюутан суралцах, буруу ойлголтыг засах тодруулах боломжийг оюутанд олгодог. Лекцийнхээ дүгнэлт хэсэгт:

- Гол үзэл санаа, түлхүүр ойлголтуудыг давтан хэл,
- Оюутнуудаас хичээлийн сэдэвтэй холбоотой асуулт асуу. Асуулт асуусныхаа дараа тэдэнд тэмдэглэлээ эргэн харах, бодох хугацаа өгөх нь зохистой. Мөн оюутнуудад асуулт асуух боломж олго
- Хичээлийн агуулгыг өмнө үзсэн болон дараа үзэх сэдэвтэй холбон тайлбарла.

Лекцийн аргын давуу ба сул тал

Давуу тал	Сул тал
- Олон тооны оюутанд мэдээллийг нэгэн зэрэг түгээдэг. - Цаг хугацаа, эдийн засгийн хувьд хэмнэлттэй. - Ярилцлага, мэтгэлцээн, дүрд тоглуулах гэх мэт жижиг багаар хичээллэх цаашдын сургалтад шаардагдах хамгийн үндсэн мэдээллийг өгдөг. - Олон эх сурвалжаас авсан онолын болон практикийн мэдээллийг оновчтой, эмх цэгцтэйгээр санал болгодог.	- Оюутны бие даасан, идэвхитэй сурах үйл явцыг дэмждэггүй. - Тодорхой хувь хүмүүсийн суралцах чадварын ялгаатай байдлыг харгалзах боломжгүй. - Оюутны оролцоог үгүйсгэсэн нэг талт харилцаа зонхилно.

Лекцийн аргыг ашиглахдаа анхаарах зүйлс

- Ихэнхи оюутны хувьд анхаарлын төвлөрлийн үргэлжлэх хугацаа нь 15-20 минут байдаг бол их сургуулиудын хичээл голдуу 50-90 минут үргэлжилдэг. Иймээс лекцийг бусад аргатай хослуулах нь зүйтэй. Жишээлбэл оюутнуудад асуулт өгч, түүн дээр ажиллах боломж олгох, онолын сэдэвтэй холбоотой тодорхой жишээ авч ярилцах гэх мэт.
- Хүн нэг зэрэг долоогоос илүү мэдээллийг тогтоох боломжтой гэж судлаачид дүгнэсэн байдаг.
- Дэлгэрэнгүй үзүүлэн ашиглаагүй лекцийн хичээл дууссанаас 3 цагийн дараа сонсогч агуулгын 70, 3 хоногийн дараа сонсогч 10 хувийг л санадаг бол үзүүлэн ашиглан уншсан тохиолдолд дээрх үзүүлэлтүүд 95, 65 хувь болж өсдөг байна.
- Оюутны оролцоог дэмж. Багш оюутантай хэр их харилцаж холбоо тотооно сурах, сургах үйл явц тэр хэмжээгээр идэвхитэй болдог.
- Лекцээ бүрэлдэхүүн хэсэг бүрээр нь маш сайн бэлд.

6. Илтгэх ур чадвартаа анхаар. Лекцийг унших явцдаа сэдэвтэй хамаагүй зүйлийг дурдах, хэт их мэдээллээр дарах нэгэн хэвийн өнгө аясаар ярихаас зайлсхийж, оюутнуудтай идэвхитэй харьцаа үүсгэвэл зохилтой.
7. Оюутны зүгээс гарч буй саналыг хүндэтгэ. Ялангуяа поток лекцийн үед энэ нь маш чухал бөгөөд багшийн хариу үйлдлийг оюутан нэлээд хурцаар хүлээж авах хандлагатай байдаг.

2. Эвлүүлгийн арга

Энэ арга нь оролцогчдод богино хугацаанд их мэдээлэл олж авах боломж олгодог ба лекцийг орлуулахад ашигладаг. Эвлүүлгийн аргын зорилго нь оюутнууд бие биедээ заах, сургах боломж олгодог ба тухайн хичээлээр мэдээлэл олж авахад хүндрэлтэй хичээлийг тайлбарлах, асуулт тавих, бусадтай харилцах ба сонсох чадварыг амьдралд хэрэглэхэд илүү үр дүнтэй.

Философи хичээлийн зарим сэдвийг судлахад оюутнуудад дэлгэрэнгүй мэдээлэл шаардагддаг ба энэ тохиолдолд тухайн мэдээлэлийг жижиг багийн тоогоор хувааж бэлтгэсэн байна. Бэлтгэсэн материалаа нэг дугтуйд хийж багуудад тараан өгнө. Эвлүүлгийн аргыг хэрэглэхдээ баг тус бүрт нэг ижил даалгавар өгөх бөгөөд тодорхой асуудлын талаар мэдлэгтэй болгох зорилготой.

Багийн гишүүд өгөгдсөн сэдвийн дагуу өөр өөрсдийн санал бодлыг цаасан дээр бичнэ. Тэдэнд санат бодлоо бичих, илэрхийлэхэд хангалттай хугацаа өгөх хэрэгтэй бөгөөд багш баг бүрт очиж, материалаа ойлгож байгаа эсэх талаар асууж, арга зүйн туслалцаа үзүүлнэ.

Багууд дотроо тухайн асуудлаар ярилцан үзэл бодлоо илэрхийлэх, үндэслэгээгээ гаргаж, нэгдсэн тайлбараа хийхэд бэлтгэнэ.

Үүний дараа баг бүр өөрсдийн санал бодлоо бусад багуудад тайлбарлах, багуудаас гарсан асуултанд хариулах, харилцан мэтгэлцэх замаар мэдлэг олно. Оюутнуудаас гарсан асуултанд багш хариулах, маргаантай асуудлыг тайлбарлах, дүгнэлт хийх замаар оюутнуудын мэдлэгийг цэгцэлнэ. Хичээлийн эцэст багш багуудын хариултыг дүгнэж, идэвхитэй оролцсон оюутнуудад үнэлгээ өгнө.

3. Хүн бүр багш

Бүлэг сэдвийг танилцуулахад болон үзсэн сэдвийн агуулга, ойлголтуудыг дүнэхэд энэ аргыг гол төлөв хэрэглэнэ.

Энэ аргын зорилго нь суратцагчид бусадтай мэдээлэл солилцох, өөрт буй мэдээллээ бусдад тарааж, шинэ мэдэачэл бусдаас олж авахад орших бөгөөд оюутнууд сургалтын үйл явцад идэвхитэй оролцох болон бие биетэйгээ санаа бодлоо солилцоход ихээхэн ач холбогдолтой болно.

Хэрэгжүүлэх дараалал:

- ▲ Лекцийн агуулга мэдээллийг утгат хэсгээр нь хувааж, тарааж өгөх зорилгоор жижиг цаасан дээр бичиж бэлдэнэ. Энэ нь сургалтад оролцогчдын тоогоор байх ёстой.
- ▲ Оролцогчид мэдээллийн уншсаны дараа уншсан зүйлийнхээ агуулгыг ярих, зураглах, бүдүүвчээр илэрхийлэх зэргээр бусдад түгээх бэлтгэлээ хийнэ. Энэ үед багш тусламж шаардлагатай хүн дээр очиж зөвлөгөө өгч, тайлбарлаж болно.



▲ Бэлтгэх хугацаа дууссаны оролцогчид мэдээллээ бие биедээ танилцуулж, ангиа тойрон явна. Хүн бүр өөрт байгаа мэдээллээ танилцуулж, бусдаас мэдээлэл авч дуустал энэ ажил үргэлжилнэ.

Энэ ажлыг дууссаны дараа багш бие биенээсээ юу мэдсэн, ямар шинэ мэдээлэл авсан тухай, уг мэдээллийг юу гэж ойлгож байгаа тухай, энэ мэдсэн зүйл өөрт нь ямар хэрэг болох тухай ярилцуулна.

Оролцооны аргууд

1. Мэтгэлцээний арга

Зорилго: Сурагчдад асуудлыг олон талаас нь харж тодорхой сэдвээр уншиж, судалгаа хийж логиктой сэтгэж, өөрийн бодол санааг ойлгомжтой, цэгцтэй илэрхийлэх, бусдыг хүндэтгэж хамтран ажиллах арга барилд сургах

Мэтгэлцээний зарчмууд

1. Мэтгэлцэх гэж байгаа шийдэл нь нотлогч, няцаагч хоёр талд тэнцүү боломж олгосон байна
2. Суралцахын тулд маргах. Сурацах нь ялалт байгуулахаас илүү чухал
3. Шударга байх. Хүмүүс үнэнийг, зөвхөн үнэнийг л мэдэхийг хүсдэг
4. Өрсөлдөгчөө хүндэтгэх. Маргаанаар үзэл бодлын аль нь хүмүүст илүү хэрэгтэй вэ гэдгийг шийддэг учраас өрсөлдөгчдийг биш дэвшүүлсэн шийдлийг үндэслэгээ сайтай няцаах нь хамгийн зөв арга юм.

Мэтгэлцээний бүрэлдэхүүн

1. Шийдэл. Мэтгэлцэхийн тулд ямар нэг сэдэв хэрэгтэй. Үүнийг шийдлээр илэрхийлнэ
2. Нотлох тал. Дэвшүүлсэн шийдлийн зөв болохыг нотлох үүрэгтэй
3. Няцаах тал. Шийдэл болон нотлогч талын гаргаж буй нотолгоонууд нь ямар учраас буруу болохыг шүүгчдэд батлан харуулах үүрэгтэй
4. Нотолгоо. Ямарваа нэг асуудлаар өөрийн дэвшүүлж байгаа санал бодлыг зөв гэдгийг шүүгчдэд ойлгуулахын тулд нотолгоонууд гаргах ёстой
5. Дэмжлэг. Дэвшүүлж буй нотолгоонуудаа бодитой тоо баримт жишээгээр баяжуулж үнэмшилтэй болгох ёстой
6. Хайчин асуулт. Мэтгэлцээнд эсрэг багийн гишүүд бие биенээсээ асуулт асууж, хариулт авахыг хэлнэ
7. Шүүгчийн шийдэл. Шүүгч нь хоёр талын нотолгоонуудыг нэг бүрчлэн сонсож тэмдэглэл хөтөлсний үндсэн дээр аль баг шийдэлтэй илүү уялдаа холбоо бүхий үнэ зөв нотолгоо гаргасныг харгалзан ялсан багийг тодорхойлж шүүгчийн хуудсан дээр бичнэ.

Мэтгэлцээний дүрмүүд

1. Шийдлийг танилцуулсны дараа оролцогч өөрийн сонголтоор нотлох болон няцаах багийн аль нэгийг сонгох боломжтой бөгөөд мэтгэлцээний явцад сонголтоо өөрчлөхгүй.
2. Илтгэлээ бэлтгэж, танилцуулахдаа болон тодруулах асуулт асууж, хариулахдаа багууд тогтоосон хугацааг чанд баримтлана.
3. Баг бүр мэтгэлцээний явцад бэлтгэлийн 6 минутын эрхтэй.
4. Багууд бүх үндэслэл (аргумент)-ээ эхний илтгэлдээ дэвшүүлэх бөгөөд дараагийн илтгэлүүдээ шинэ үндэслэл гаргахгүй.
5. Багийн гишүүд мэтгэлцээний соёлтой байж бусдад хүндэтгэлтэй хандана.
6. Багууд нэртэй байна.

Үйл ажиллагааны дараалал

- Бүлэгт шийдэл танилцуулна	1 минут
- Шийдвэр гаргахын тулд бодох хугацаа	1 минут
- Оюутнуудын санал дээр үндэслэж бүлгийг 2 багт хуваана	1 минут
- Баг тус бүр илтгэлээ бэлтгэнэ	7 минут
- Нотлогч багийн үндсэн илтгэл	3 минут
- Тодруулах асуулт, хариулт	1 минут
- Няцаагч багийн үндсэн илтгэл	3 минут
- Тодруулах асуулт, хариулт	1 минут
- Нотлогч багийн няцаалт илтгэл	4 минут
- Тодруулах асуулт, хариулт	1 минут
- Няцаагч багийн няцаалт илтгэл	4 минут
- Тодруулах асуулт, хариулт	1 минут
- Нотлогч багийн дүгнэлт илтгэл	1.5 минут
- Няцаагч багийн дүгнэлт илтгэл	1.5 минут

Шүүгчийн шалгуур

1. Шийдлээ ойлгосон байдал
2. Онолын үүднээс хандаж байгаа байдал
3. Үндэслэгээтэй хандаж байгаа байдал
4. Үндэслэгээний дэмжлэг (жишээ, баримт, судалгаа зэрэг)
5. Цаг баримталж байгаа байдал
6. Багаар ажиллах чадвар
7. Мэтгэлцээний соёлтой байж бусдад хүндэтгэлтэй хандсан эсэх.

2. Булангийн арга

Энэ нь мэтгэлцэж хэсэг бүлгээрээ бүтээлч санал гаргаж хамтран судлах арга юм. Үүнийг хоёр ба түүнээс дээш байр сууринаас хандаж болохуйц маргаантай асуудлаар зохиох мэтгэлцээнийг удирдан явуулах идэвхтэй, бүтээлч хэрэглүүр болгон ашиглаж болно. Булангийн аргыг сэргээн сануулах, утгыг ойлгох бататгах үе шатны алинд нь ч хэрэглэж болно.



Зорилго

1. Тухайн асуудалд өөрийн гэсэн байр сууринаас хандаж үзэл бодлоо хамгаалах аргад сургах
2. Бусдын үзэл бодлыг хүндэтгэн үзэж анализ хийх чадвартай болох
3. Асуудалд баримт нотолгоотой хандах, зөв цэгцтэй ярих чадварыг хөгжүүлэх

Бэлтгэл

1. Хоёр ба түүнээс дээш байр сууринаас хандаж болохуйц маргаантай сэдвийг бэлтгэх
2. Булангийн аргын зааварчилгааг бэлтгэх

Үйл ажиллагааны үе шат

1. Оролцогчдод тухайн сэдвийн талаар бодох даалгавар өгнө. Сэдвийн талаар тодорхой мэдлэггүй байвал ярьж өгөх юм уу зориудаар бэлтгэсэн материалыг уншуулж болно
2. Оролцогчдоос тухайн асуудлаар ямар байр суурьтай байгааг асууна. Болж өгвөл оролцогчдод хоёр ба түүнээс дээш боломж гаргаж өгвөл зохимжтой
3. Оролцогчдод 3-5 мин. хугацаа өгч өөрсдийнх нь байр суурийн талаар бичүүлэхдээ нотолгоогоо оновчтой дэвшүүлэхийг сануулах
4. Бичүүлж дууссаны дараа тухайн асуудлыг дэмжиж буй оролцогчийг ангийн нэг буланд, дэмжихгүй байгааг нөгөө буланд зогсооно. Аль алиныг дэмжиж чадахгүй эргэлзэж байгаа хүмүүс байвал өөр нэг буланд, үүнээс өөр саналтай хүмүүс байвал бас нэг буланд гэх мэтээр ялгаж зогсооно.
5. Булан буланд цугларсан хүмүүс өөрсдийн бичсэн зүйлийн талаар 5 орчим минут санал бодлоо солилцож, байр сууриа хамгаалах нотолгоогоо сонгохын зэрэгцээ өөрсдийг нь төлөөлөх хүнийг сонгоно.
6. Багуудын төлөөлөгчид ээлжлэн гарч ирж өөрсдийн байр суурийг цэгцтэй илэрхийлнэ.
7. Хүмүүсийг ярьж дууссаны дараа багууд харилцан няцаалт хийх юм уу эргэлзэж байгаа багийнхан санал бодлоо илэрхийлж болно.
8. Ярилцлагын явцад зарим оролцогчид өөрийн үзэл бодлоос няцсан бол зөв гэж үзэж байгаа багт чөлөөтэй нийлнэ.
9. Ярилцлага мэтгэлцээн дуусаж оролцогчид эцсийн байр сууриа тодорхойлсны дараа багш талуудын ярьсан зүйлийг дүгнэнэ.

3. Тохиолдол шинжлэх

Энэ арга нь суралцагчдад философийн онолын зарим асуудлыг тодорхой жишээн дээр үндэслэн хэрэглэж сурахад чиглэсэн асуултын аргад тулгуурласан хэлбэр юм. Тодорхой жишээ гэдэг нь бодит болон зохиомол хэрэг, үйл явдал байж болох юм. Сургалтын энэ арга нь суралцагчийг амьдралд тохиолдсон тодорхой үйл явдлын нөхцөл байдлуудыг бүх талаас бүрэн бодитой шүүмжлэх, түүнд хувийн үнэлэлт дүгнэлт өгөх замаар философийн онолын мэдлэгийг гүнзгий эзэмшүүлэх зорилготой.

Тохиолдол шинжлэх аргын давуу талууд

- ▲ Тоймлосон дүгнэлт, тодорхой үзэл санааг дэвшүүлдэг.
- ▲ Харьцангуй өндөр түвшинд хийсвэрлэн сэтгэх боломж олгодог.
- ▲ Суралцагчдын сэтгэлгээг хөгжүүлэн анализ хийх, асуудалд олон талаас нь хандах, шийдвэр гаргах чадвартай болно.
- ▲ Лекцийн хичээлээр эзэмшсэн онолын мэдлэгийг бодит амьдралын жишээ, үйл явдалтай холбон тайлбарлах чадвартай болно.

Тохиолдол шинжлэх аргын дутагдалтай талууд

- ▲ Хэдийгээр авч үзэж байгаа тохиолдол нь бодит байдалтай салшгүй холбоотой ч, нэг ч жишээ жинхэнэ бодит байдлыг орлохгүйг санах хэрэгтэй.
- ▲ Сургалтад хэрэглэгдэж буй жшпээ бүр багшаар дамжиж суралцагчдад хүрдэгийг мартаж болохгүй. Энэ аргыг хэрэглэх нь үлэмж цаг хугацаа шаарддаг учир багшийн бусад хичээлдээ зарцуулах цагт сөргөөр нөлөөлдөг.
- ▲ Ердийн танхимын нөхцөлд багш энэ аргаар хичээл явуулахад лекторын биш, харин ярилцлагыг хөтлөгчийн дүрд тоглох болно. Гэтэл багш бүхэн энэ үүргийг биелүүлж чадах эсэх нь тодорхойгүй.
- ▲ Энэ аргыг хэрэглэхэд нэг багшид 20-иос илүүгүй оюутан оногдохоор тооцоолох хэрэгтэй. Илүү олон оюутантай багш нэгэн зэрэг ажиллах тохиолдолд хичээлийн зорилго, үр дүнд муугаар нөлөөлнө.
- ▲ Холбогдох гарын авлага тухайлбал бодлого, дасгалын хураамж, сурах бичиг, эх хэрэглэгдэхүүн зэрэг нь хангалттай хүрэлцээтэй үед л хичээл үр дүнтэй явагдана. Ийм боломж зарим тохиолдолд хомс байдаг.

Үйл ажиллагааны дараалал

1. Тухайн тохиолдлыг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг өгөх. Мэдээллийг олон янзын арга ашиглан өгөх боломжтой. Тухайлбал: сургалтын материал тараах, бага хэмжээний лекц сонсох, видео бичлэг үзэх,
2. Тохиолдлыг уншуулах. Энэ үед оролцогчдод тохиолдлын эцсийн үр дүн шийдвэрийг мэдээлэхгүй байх хэрэгтэй. Уг асуудлын бодит төгсгөлийг нэлээд хожим авч үзэх нь илүү тохиромжтой.
3. Оролцогчдын анхаарлыг бодит баримтын учрыг олоход чиглүүлнэ.
4. Тохиолдлын үйл явдлыг сайтар ойлгуул.
5. Үүний тулд багш асуулт тавьж хариулт авах замаар уг тохиолдлын талаарх оролцогчдын ойлголтыг гүнзгийрүүлж өгнө.
6. Оролцогчид тухайн тохиолдлын талаарх өөрсдийн тайлбарыг танилцуулж дүгнэлтээ гаргана.
7. Гаргасан дүгнэлтэд тулгуурлан багш хичээлийн төгсгөлд оюутнуудаа дүгнэнэ.



4. Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг явуулах арга

Энэ аргыг хэрэглэснээр оролцогчид эсрэг үзлүүдийг хамтран хэлэлцэх, өөрийн санал бодол байр суурийг илэрхийлэх, хамгаалах, мэдээлэл солилцох, соёлтой мэтгэлцэх, өрсөлдөгчдийн үзэл бодлыг хүлээн зөвшөөрөх, хүлцэх чадвартай болно. Оролцогчдоос уг баримтлалд тэдний үзэж байгаагаар хамгийн чухал маргаантай асуудлууд нь юу болохыг асууснаар багш сэдвийн хэлэлцүүлгийг эхэлж болно.

Маргаантай асуудлыг сонгох шалгуур

- ▲ Олон талаас нь авч үзэх боломжтой, үнэхээр маргаантай асуудал мөн эсэхийг тогтооно.
- ▲ Энэ асуудал нь тухайн ангид хэлэлцэхэд тохиромжтой болон суралцагчдын хувьд хүсэл сонирхол, мэргэшлийнх нь хувьд ач холбогдолтой эсэхийг тогтооно.

Маргаантай асуудлыг хэлэлцэхэд баримтлах дүрэм

- ▲ Нотолгоо болон баттай мэдээлэл дээр анхаарлаа төвлөрүүлнэ.
- ▲ Цаг барьж ганцаар ярихаас зайлсхийнэ.
- ▲ Уриа хэрэглэхээс зайлсхийнэ.
- ▲ Маргааныг хийсвэр түвшинд хүргэлгүй аль болох тодорхой асуулууд дээр ярилцахыг хичээнэ.
- ▲ Өөрийн байр сууринд эргэлзэх бололцоог бусдад олгоно.
- ▲ Бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандана.

5. Үндэслэл гаргасан эссэ бичих

Эссэ гэдэг бол аль нэгэн асуудлаар тухайн бичлэгийг бусад хэнийхтэй ч төсгүй, өөрийн үзэл бодлыг илэрхийлсэн, ихэнхдээ богино хэлбэрийн хүүрнэлт, бичлэгийн хэлбэр юм. Энэхүү үзэл бодол нь заавал үнэн зөв, уг асуултад өгөх эцсийн хариу байх албагүй. Эссэ аль нэг юм үзэгдлийн талаар гүн ухааны, намтар түүхийн, эсвэл цэвэр уран зохиолын зан төрхийг тодорхойлдог бөгөөд ингэхдээ уг зүйлийн талаар зохиолын хийсвэрлэсэн шинэ үзэл бодол тусгагдсан байдаг.

Зорилго:

1. Маргаантай асуудлыг шийдвэрлэхэд ямар нэгэн байр суурь баримтлах
2. Байр сууриа судалгаа шинжилгээний үндэслэлтэйгээр илэрхийлэх
3. Судлан шинжлэх аргад суралцах

Бэлтгэл:

1. Маргаантай асуудлуудыг тодорхойлно.
2. Маргаантай асуудлын талаархи олон янзын байр суурийг илэрхийлсэн судалгаа шинжилгээний материалыг багш, сурагчид хамтран бэлтгэнэ
3. Эссэний бүтэц зохион байгуулалтын танилцуулга бэлтгэнэ.

Үйл ажиллагааны заавар

1. Эссэний заавар өгнө
2. Маргаантай асуудлаа тодорхойлж байр сууриа сонгоно
3. Сонгосон байр суурьтай холбоотой материалуудаа уншин судална.
4. Судалсан материалаа үндэслэн эссэ бичнэ
5. Оролцогчид хос хосоороо бие биедээ бичсэн зүйлээ харилцан уншиж өгнө. Сонсогч зохиогчийн уншсан зүйлээс түүний байр суурийг лавлаж, өөрийг нь итгүүлэхийн тулд ямар ямар үндэслэл хэрэгтэй байгааг бие биедээ ээлжлэн хэлж өгнө. 10 мин хугацаа өгч дээрхи үндэслэлүүдийг гаргуулж бичүүлнэ. Ингэхдээ дүгнэлт хийж болохгүйг анхааруулаад, өмнөхийн нэгэн адил мөр алгасаж бичихийг сануулна
6. Хос хосоороо болсон оролцогчид бичсэн зүйлээ бие биедээ уншиж өгөөд, өөрсдийн байр суурийг хамгаалж гаргасан үндэслэл, нотолгооныхоо талаар болон итгүүлэхээр болж чадсан эсэх талаар нөгөө нөхрийнхөө санал бодлыг сонсоно. Ингэснээр бичсэн зүйлийн дүгнэлтийн хэсэг ямар байх нь тодорхой болно.
7. Сурагчдад хугацаа өгч дүгнэлтийн хэсгийг бичүүлнэ.
8. Бичсэн бүх зүйлээ нөгөөдөө уншиж өгнө. Тэр нь зохиогчийн баримтлаж буй байр суурь, үндэслэл, шалтгаан болон дүгнэлтийнх нь талаар ойлгосноо түүнд ярьж зөвлөнө.
9. Хугацаа өгч бэлдсэн эхийг нь хянуулж засварлуулна. Энэ нь байр суурийг тодруулах, сайжруулах, дүгнэлтээ илүү ойлгомжтой болгох боломж олгоно.
10. Сонсогчдын хэлж ярьсан зүйл, зохиогчийн илэрхийлсэн байр суурь түүний үндэслэлтэй хэрхэн нийцэж байгаа талаар ярилцаж, дүгнэлт ямар байж болохыг таамаглана. Дараа нь зохиогч дүгнэлт хэсгээ уншина. Эссэгээ бүтээлийн сандаа хадгална.

4. Философийн хичээлийн үнэлгээ

Үнэлгээний зорилго

Философийн хичээлээр олж авсан метафизик, эпистемологи, үнэлэмжийн онолын суурь мэдлэгээ аливаа асуудал, ялангуяа нийгмийн үзэгдлүүдэд хэрэглэн үнэлгээ өгөх, философидох, асуудлыг олон талаас нь авч үзэх, шүүмжлэлтэйгээр эргэцүүлэх чадвар, хандлагад гарсан өөрчлөлтийг бодитойгоор үнэлэхэд тус хичээлийн үнэлгээний гол оршино. Энэ үнэлгээ нь бүхэлдээ хичээл зорилгодоо хүрч чадсан эсэхийг илрүүлэхэд чиглэнэ.

Үнэлгээний дүнг дараах зорилгоор ашиглана. Үүнд:

- Оюутан давтан судлах шаардлагатай эсэхийг тогтоох
- Оюутны сурах эрмэлзлийг идэвхижүүлэх
- Оюутны мэдлэг чадварын түвшинг тогтоох
- Хичээл зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлэх



Үнэлгээний журам

Оюутны мэдлэгийг үнэлэхдээ дараах үсгэн дүнг хэрэглэнэ. Үүнд:

1. "А" үнэлгээ /90-100 оноо/: Дээд амжилтыг илтгэх үнэлгээ. Философийн хичээлээр үзсэн үндсэн сэдвүүд, үзэл баримтлалууд, ойлголтуудын агуулгыг бүрэн эзэмшсэн, тэдгээрийг зөв тайлбарлаж, нэр томъёог оновчтой хэрэглэх чадвар бүхий, хичээлд жигд идэвхи, санаачлагатай оролцсон, явцын шалгалтанд амжилттай дүн үзүүлсэн байна.
2. "В" үнэлгээ /80-90 оноо/: Амжилттай суралцсаныг илтгэнэ. Үндсэн сэдвүүд, ойлголтууд, үзэл баримтлалуудын агуулгыг сайн ойлгосон, тэдгээрийг зөв тайлбарлаж, нэр томъёог оновчтой хэрэглэх чадвар бүхий, хичээлд идэвхитэй оролцсон, явцын шалгалтанд амжилттай дүн үзүүлсэн байна.
3. "С" үнэлгээ /70-80 оноо/: Хичээлийн агуулгыг дунд түвшинд эзэмшсэнийг илтгэнэ. Философийн хичээлээр үзсэн үндсэн сэдвүүд, ойлголтууд, үзэл баримтлалуудын агуулгын ихэнхийг хангалттай эзэмшсэн, тэдгээрийг тайлбарлаж, нэр томъёог оновчтой хэрэглэх чадвар бүхий, хичээлд идэвхитэй оролцсон, явцын шалгалтанд хангалттай дүн үзүүлсэн байна.
4. "D" үнэлгээ /60-70 оноо/: Философийн хичээлээр үзсэн үндсэн сэдвүүд, ойлголтууд үзэл баримтлалуудын агуулгыг сайтар ойлгоогүй, хичээлд жигд бус оролцож явцын шалгалтанд хамрагдсан байна.
5. "F" үнэлгээ /00-59 оноо/: Хичээлийн агуулгыг эзэмшээгүй, мэдлэг, чадвар хангалтгүйг илтгэх дүн.

Үсгэн, процентон, тоон дүнгүүдийг дараах жишгээр харьцуулна.

Үсгэн дүн	Тоон дүн	Процентон дүн
A	4.0	90-100
B	3.0	80-90
C	2.0	70-80
D	1.0	60-70
F	0	0-59

Жишиг үнэлгээ:

Ирц	10 оноо
Идэвхи /семинарын оролцоо/	30 оноо
Явцын шалгалт	20 оноо
Улирлын шалгалт	40 оноо

Семинарын оролцооны 30 оноог нийт 8 удаагийн семинар тус бүрд 1-5 оноо авсан байхаар процентлон гаргана.

Үнэлгээний шалгуур

Юуг үнэлэх	Үнэлгээний жишиг шалгуур
мэдлэг	- Үндсэн ойлголтуудын агуулгыг эзэмшсэн байдал - Асуудлыг философийн онолын үүднээс авч үзэж байгаа байдал - Философи баримтлалуудыг харьцуулан анализ хийж байгаа эсэх - Өөрийн үзлээ үндэслэж байгаа байдал
чадвар	- Онолын мэдлэгээ ашиглан тодорхой асуудлыг тайлбарлаж, үндэслэх чадвар - Өөрийн мэдсэн зүйлээ бусдад тайлбарлаж, ойлгуулах чадвар - Унших, сонсох, ярих, бичихдээ асуудалд шүүмжлэлтэйгээр, олон талаас нь авч үзэх чадвар - Өөрийгөө зөв илэрхийлэх чадвар /өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, мэтгэлцэх, эсрэг үзлийг хүлцэх/ - Ялгаатай үзэл, байр суурь, баримтлалуудаас үнэ, цэнэтэй зүйлийг олж авах чадвар
хандлага	- Асуудалд шүүмжлэлтэй хандах байдал - Асуудалд эргэлзэх /скептик/ үүднээс хандах - Ялгаатай үзэл, байр суурийг хүлцэн, хүндэтгэлтэй хандах байдал - Нийгмийн амьдралын үзэгдлүүдэд философи янз бүрийн баримтлалуудын үүднээс хандан үнэлгээ өгөх байдал

Сэдвийн жишиг үнэлгээ

Бүлэг сэдвийн нэр:

Ёс зүй

Зорилго:

- ▲ Ёс зүйн үндсэн баримтлалуудын талаар онолын суурь мэдлэгтэй болох
- ▲ Өнөөгийн нийгмийн ёс суртахууны харилцаа, төлөв байдалд ёс зүйн үүднээс үнэлэлт өгөх
- ▲ Сайн, муу, үүрэг, хариуцлага, шударга ёс, нэр төр зэрэг ёс зүйн онолын ойлголтуудыг эзэмшсэнээр бусдын болон өөрийн үйлдэлд үнэлгээ өгөх,
- ▲ Ёс суртахууны аливаа асуудлыг олон талаас нь авч үзэж, ухаалаг, шүүмжлэлтэй, идэвхитэй хандахад тус болно.

Мэдлэгийг үнэлэх шалгуур

- Ёс зүйн үндсэн баримтлалууд: эвдеманизм, гедонизм, кинизм, утилитаризм, үүргийн ёс зүй, перфекционизм, метаэтик, эмотивизм, интуитивизм зэргийн үндсэн агуулгыг ойлгосон байдал
- Хэрэглээний ёс зүйн суурь асуудлуудыг ойлгосон байдал
- Сайн, муу, үүрэг, хариуцлага, шударга ёс, нэр төр зэрэг ёс зүйн онолын ойлголтуудыг эзэмшсэн байдал
- Асуудал дэвшүүлэх, хариулт өгөхдөө ёс зүйн үүднээс үндэслэх чадвар



Чадварыг үнэлэх шалгуур

- ▲ Ёс зүйн үндсэн баримтлалуудын агуулгыг тодорхой жишээн дээр хэрэглэн тайлбарлаж чадаж байгаа эсэх
- ▲ Тодорхой жишээн дээр ёс зүйн үндсэн ойлголтуудыг зөв тайлбарлаж байгаа эсэх
- ▲ Асуудалд зөвхөн нэг үзлийн үүднээс хандах нь өрөөсгөл болохыг үндэслэх чадвар

Хандлагыг үнэлэх шалгуур

- ▲ Өөрийн үзэл бодлыг илэрхийлэх, бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандаж байгаа эсэх
- ▲ Эсрэг байр суурь бүхий үзлийг хүлээн зөвшөөрч, хүлцэж чадаж байгаа эсэх
- ▲ Аливаа асуудалд шударга, хүнлэг ёсны зарчмын үүднээс хандаж байгаа эсэх
- ▲ Асуудлыг олон талаас нь авч үзэж байгаа эсэх
- ▲ Суралцах эрмэлзэл төлөвшсөн эсэх

ФИЛОСОФИЙН ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

I бүлэг. УДИРТГАЛ

1. Философийн тухай ерөнхий ойлголт


Үгийн утга



Философийн бүтэц бүрэлдэхүүн

- | | |
|------------------------------------|----------------------------|
| 1. Онтологи | 12. Шашны философи |
| 2. Танин мэдэхүйн онол | 13. Эдийн засгийн философи |
| 3. Нийгмийн философи | 14. Философийн антропологи |
| 4. Методологи (арга зүй) | 15. Улс төрийн философи |
| 5. Логик | 16. Эрх зүйн философи |
| 6. Философийн түүх | 17. Түүхийн философи |
| 7. Үнэлэмжийн философи (аксиологи) | 18. Ухамсрын философи |
| 8. Шинжлэх ухааны философи | 19. Технологийн философи |
| 9. Соёлын философи | 20. Семиотик |
| 10. Ёс зүй (этик) | 21. Үйлдлийн философи |
| 11. Урлагийн философи (гоо зүй) | 22. Боловсролын философи |

Философийн дотоод болон гаднах хүрээ





Философи гэж юу вэ? Философийн тухай олон янз тодорхойлолт

Сократ:

Философийн амин зүрх бол амьдралыг судлах явдал мөн.

Аристотель:

Философи бол "анхдагч эхлэлүүдийг болон шалтгаануудыг судалдаг".

Гадамер:

"Философи бол үгний эрэлд хатаж шаналсан оюун ухаан".

Б.Рассел:

Философи нь өөрөөсөө болон өөртөө үнэлэмжгүй зүйл мөн. Философийг судлах нь бидний оюуны дүр зургийг хангаж тэтгээж байдаг ойлголтуудын хүрээ, хязгаарын талаархи бидний үнэлгээнд хэт сүжирдэг асуудлуудад зөвхөн хэрэгслийн үр дүн өгдөг.

Платон:

Философийн зорилт бол мөнх, туйлын (абсолют) үнэнийг танин мэдэхүй мөн бөгөөд ийм үйл ажиллагааг гагцхүү философичид цэцэн сүнстэй төрдгийнхөө хувьд хэрэгжүүлж чаддаг.

Ж.Делёз, Ф.Гваттари:

"Философи бол янз бүрийн концепцийг бэлтгэж, бүтээж, төлөвшүүлэх урлаг мөн".

Р.Рорти:

Эртний грекийн үеэс эхлэн шинэ үеийн шинжлэх ухаанч философи, гэгээрүүлэгчдийн үзлээр дамжин өнөөг хүрсэн үнэн байх ёстой хэмээх албадлагаас философийг чөлөөлөх хэрэгтэй.

Н.Решер:

Философийн зориулалт бол танин мэдэхүүд зөвшөөрөгдсөн рациональ байдлаар асуулт тавьж, хариулах явдал, энэ ертөнц дээрх амьдралын тухай хамгийн том асуулт бол хүтүүс өөрсдийн сэтгэн бодохуйн тухай эргэцүүлдэг явдал мөн. Философи бол шинжлэх ухаан анхнаасаа бидэнд өгөхөөр амласан боловч тасралтгүй үргэлжлэх хөдөлмөрийн хуваарь, илүү нарийн зүйл рүү тэмүүлэх төгсгөлгүй тэмүүлээсээ болоод хэзээ ч өгч чадаагүй хүний мэдлэгийн системтэй нэгдлийг өгөхийг хичээдэг.

Философийн үүсэл

Анхны философи сургаалууд Энэтхэг, Хятад, Грек, Египет, Вавилон гэх мэт улсад одоогоос 3000 шахам жилийн тэртээ бараг зэрэг үүсчээ. Гэхдээ философи чухамхүү эртний Грект л сонгодог хэлбэртэй болж чадсан аж.

Философи сонгодог хэлбэрээрээ ямар учраас хаа нэгэн өөр газар биш чухамхүү Грект үүсэв?

Философи үүсэхэд нөлөөлсөн урьдчилсан нөхцөлүүд:

Нэгдүгээрт: Эртний Грект хөдөлмөрийн хуваарь үүсэн, боловсронгуй болсон (гар урлалын үйлдвэрлэл харьцангуй өндөр түвшинд хүрсэн байсан). Үйлдвэрлэлд боолын хөдөлмөрийг өргөн ашиглах болсноор нийгмийн гишүүдийн зарим хэсэг болох боол эзэмшигч-язгууртнууд, чөлөөт иргэд оюуны хөдөлмөр эрхлэх бололцоо бүрдэж улмаар оюуны хөдөлмөрийн хуваарь үүсэж утга зохиол, урлаг, спорт эрчимтэй хөгжиж, өндөр түвшинд хүрч байсан.

Хоёрдугаарт: Хөдөлмөрийн хуваарийн хөгжилтэй хамт нийгмийн анги давхрагуудын ялгарал гүнзгийрч, тэдгээрийн хоорондын харилцаа нарийсан ялгарсан.

Гуравдугаарт: Арилжаа худалдаа, хөрөнгө оруулалт, тээвэр, аялал жуулчлалын хөгжилд ашиг орлого, эрсдэлийн тооцоо хийх, оюуны эрэл хайгуул, хийсвэр сэтгэлгээний хөгжих тааламжтай орчныг бүрдүүлсэн.

Дөрөвдүгээрт: Нийгмийн удирдлага, төрийн ардчилсан тогтол цоо, политейст шашин шүтлэг нь нийгмийн дээд давхрааны төлөөлөгчдийн боловсролын хэрэгцээ иргэний чөлөөт байдлыг бий болгосон зэрэг юм.

Эртний грекийн философийг жинхэнэ утгаар философи шинжтэй болгохын эхлэлийг Сократ тавьсан гэж зарим судлаач үздэг. Натурфилософи байгалийг төв асуудлаа болгодог байсанд Сократ шүүмжлэлтэй хандаад, хүний амьдралын утга учир, зорилго болон авир үйлдлийнх нь ёс суртахуун ямар байх ёстой зэрэг асуудлыг философи асуудал болгон дэвшүүлсэн аж.

Зарим судлаач эртний Грекийн анхан үеийн болон эртний Дорно дахины философи мэдлэгийг адил хэв маягийн гэж үзээд тэдгээрийг хамтад нь "элэнц философи (парафилософи)", утгал философи гэж нэрлэсэн байдаг. Энэ нь хүн төрөлхтний анхан үеийн философи сургаалууд шидэт домгийн сэтгэлгээнээс төдийлөн хагацаагүй, хүмүүсийн өдөр тутмын амьдралын (хэдийгээр нэлээд гүнзгий боловч) бясалгалын хүрээнээс онцгой хальж гараагүй, мөн тэдгээр нь шинжлэх ухааны мэдлэгтэй холбогдох оюуны нөхцөл бүрдээгүй байсан зэргийг тус тус харгалзан илэрхийлдэг нэр томъёо юм. Ийм ойлгоцын үүднээс Сократаас өмнөх Грекийн философи бол элэнд философи бөгөөд тэр нь бүхэлдээ натурфилософи байжээ.



2. Мэдлэгийн системд философийн эзлэх байр суурь

Эртний грекчүүдийг эвдрэл, тэмцэл, дайн байлдааны үед эвлэрүүлдэг, бүх нийтээрээ баясан наадаж цэнгэдэг "Олимпийн наадам"-д алдар нэр хайсан тамирчид, ашиг хонжоо хөөсөн наймаачид, амралт цэнгэл хөөцөлдсөн үзэгч, хөгжсөөн дэмжигчид зэрэг өөр өөрийн хүсэл, дур сонирхолд хөтлөгдсөн хүмүүс цуглардаг байв. Тэнд алдар нэр, алт мөнгө, зугаа цэнгэл ялгар хэрэгтэй, яагаад тэд энэ бүхэнд дуртай байгаагийн учрыг олох, ухааран ойлгох гэж ирсэн цөөхөн хүн байдаг байв. Харин тэднийг философич гэж Пифагор нэрлэсэн гэдэг.

Философи хэзээ, хаана үүссэн бэ?

2500-3000 тэртээ эртний Энэтхэг, Хятад, Грек, Ром, Египет, Вавилон зэрэг улсуудад нэгэн зэрэг шахам үүссэн.

Философи бол
"ойлголтын үйлдвэрлэл"

"Мужаан хүн модны найз"
"Дархан хүн төмрийн найз"
"Философич хүн ойлголтын найз"

Яагаад?

Та "Жимсийг хэзээ ч идэж чадахгүй, учир нь ийм зүйл биетээр байдаггүй, тэр бол ойлголт. Ойлголтыг идэж болохгүй. Харин та нэг бол лийр, эсвэл алим, усан үзэм иднэ".

Тэгэхээр философи нь ойлголттой харьцдаг.

- ▲ "Философи бол гайхахаас эхэлдэг" Аристотель
- ▲ "Хамгийн сайн философи бүхнийг үгүйсгээд юуны ч талаар тодорхой санал хэлэхгүй байхад оршдог бөлгөө" Цицерон
- ▲ "Философи бол олон зууны туршид гоц гойд ухааны үр дүнд боловсорсоор ирсэн боловч тэр тусмаа маргаан үүсгэхгүй, ядахнаа эргэлзээтэй санагдахгүй нэг ч зүйл түүнд байдаггүй". Р.Декарт
- ▲ "Философи бол үгний эрэлд хатаж шаналсан оюун ухаан" Г.Г.Гадамер

Сэтгэгчид философийг янз бүрийн байр сууринаас тодорхойлсоор ирсэн байдаг.

- ▲ Зарим нь түүнийг шашны номлолтой адил зүйл, хүний амьдралын утга учрыг тайлбарлан таниулах үндсэн хэрэгсэл гэнэ.
- ▲ Зарим нь тэр бол физик, хими, математик гэх мэт тодорхой шинжлэх ухаануудтай адил зүйл, тэр нь байгалийн юмс, үзэгдлийн учрыг олдог, тэдгээрээс гадна орших философи байх аргагүй гэнэ.
- ▲ Зарим нь тэр бол урлагтай адил зүйл, урлагийн дүрээр хэлж чадаагүй санаа ухагдахууны түвшинд илэрхийлж буй хэрэг гэж үзнэ.
- ▲ Зарим нэлээд хувьсгалч төрхтэй хэсэг хүмүүс философи бол тэр чигээрээ үзэл суртал нийгмийг өөрчлөн хувьсгах номлол гэнэ.

- ▲ Зарим нь философи бол сэтгэхүйн мөн чанарыг илэрхийлэгч гэнэ гэх мэт...

Тэгвэл ингэж янз бүрээр тодорхойлоод байдгийн шалтгаан юу вэ?

Философи нь оюун санааны бусад үзэгдлүүдээс юугаараа ялгаатай вэ?

"Философийг шинжлэх ухаан" гэж ярихаа түр азнаарай!

Философи

- ▲ Асуудлыг дэвшүүлдэг.
- ▲ Асуудлыг хийсвэрлэх, бясалгах хандлагатай.
- ▲ "Софи" шинжтэй, Технэ" шинжгүй.
- ▲ Няцааж юмуу нотлох боломжгүй.
- ▲ Нэг нь нөгөөгөө үгүйсгэсэн олон онолууд зэрэгцэн орших боломжтой.
- ▲ Хатуу хэл байдаггүй ч ойлголтын аппараттай. Гол санаа+сэтгэлгээ хоёр л чухал.

Шинжлэх ухаан

- ▲ Асуудлыг шийдвэрлэдэг.
- ▲ Өөрийн судлагдахууныг "барьж үзэж" байдаг.
- ▲ Эмпирик шинжтэй, философийг бодвол "мета" бус шинжтэй.
- ▲ Нотолж юмуу няцааж болдог.
- ▲ Урьдах онол дээрээ тулгуурлаж байдаг залгамжлалт шинжтэй.
- ▲ Өөрийн гэсэн өвөрмөц хэлтэй. "физикийн хэл", "математикийн хэл", "химийн хэл" гэх мэт.

Ялгаа байгаа биз !!!

Философийн тухай тодорхойлолт яагаад тийм олон янз байдаг вэ?

- ▲ Философийн сургаал маш олон чиглэл, урсгал, сургуульд хуваагдаж, бас тэдгээр тус бүр нь олон тал, шинж, үүрэг бүхий байдаг нарийн нийлмэл үзэгдэл,
- ▲ Философи сэтгэлгээний хөгжлийн нэг үед зэрэгцэн оршиж байгаа түүний олон янзын урсгал чиглэлүүд философийн судлах зүйл, үүрэг, зорилгыг ойлгох өөр өөрийнхөө ойлголтын үүднээс философийн тухай тодорхойлолт өгдөг,
- ▲ Философи нь нийгэм, соёл, шинжлэх ухаан, техникийн дэвшил, ёс суртахуун, урлаг, уран зохиол, шашин, үлгэр домог зэрэг асар олон салбараар дамжин үзэл баримтлалаа илэрхийлдэг.

Дээрх шалтгааны улмаас философийг бүхэлд нь, түүний олон янзын сургаал, урсгал чиглэлүүдийг хамарсан цорын ганц, бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт өнөөг хүртэл бий болоогүй юм.



Философи

Ертөнц юунаас бүтсэн бэ?

Миф болон шашин

Ертөнцийг юу төрүүлж, бүтээж, бий болгосон бэ?

Философи

хүний практик хэрэгцээг хангах, шууд ашиг тусаа өгдөггүй, утилитар биш мэдлэг юм.

Ес суртахуун, сүшиг бишрэл нь

уламжлалт зан үйл, заншил хийгээд далдын ид шидэнд итгэх итгэл үнэмшилд үнэнч дуулгавартай байхыг шаарддаг.

Философи нь

Уг чанараараа гайхах, эргэлзэх явдал дээр үндэслэн бүх зүйлийг ухааран ойлгохыг эрмэлздэг шүүмжлэлт, бүтээлч сэтгэлгээний үр дүн юм.

Ердийн мэдлэг болон шинжлэх

ухааны мэдлэг нь юмсын шинж чанар, хэлбэр дүрсийг өөрчлөн амьдралын ердийн хэрэгцээг тооцоолох, хангахад чиглэсэн байдаг.

Философи

Зарим чиглэл нь үнэн рүү, зарим нь утга илэрхийлэх рүү тэмүүлдэг.

Урлагийн бүтээл нь

Үнэнийг ба утгыг өөртөө анхнаасаа агуулдаг гэж зарим судлаач бичдэг.

Философи бол "софи" мэдлэгт татагдана гэсэн үг.

Эртний Грект мэдлэгийг софи болон технэ гэж хоёр хуваадаг байжээ. Технэ мэдлэг нь материаллаг юмс, үзэгдлээс шууд гарсан ойлголт. Софи мэдлэг материаллаг ертөнцийн тусгал биш юм.

Философи бол "рефлекс"

Энэ нь оюун ухаан өөрөө өөрийгөө авч үзээд хариу үйлдэл үзүүлж буй хэрэг мөн.

Эргэлзэх сэтгэлгээ бол философийн үндэс

Энэ нь шүүмжлэлт, асуудалд бүтээлчээр ханддаг сэтгэлгээ мөн. Итгэхгүй байх гэсэн үг биш.

Философид асуулт тавих, маргах явдал гарцаагүй чухал.

Философид асуулт тавих нь хариулахаасаа хүнд байдаг. Ер нь ухаалаг асуулт хариултаа зөөж байдаг гэдэг үг байдаг биз дээ.

II бүлэг ЁС ЗҮЙ

1. Сонгодог философи дахь ёс зүйн үндсэн баримтлалууд

Үгийн утга

"ethos"- хүмүүсийн хамтран аж төрөх газар, байр орон сууц, шувууны үүр, амьтдын орогнох газар гэсэн грек үг

Ойлголтын утга

Хүмүүсийн амьдралын ямар нэгэн үзэгдэл, зан заншил тэдгээрийн дотоод мөн чанарыг илэрхийлсэн ойлголт

Аристотель хүний зан араншинд өвөрмөц шинжүүд байдгийг ажиглан тэдгээрийг цогц болгон илэрхийлэхийн тулд "этос" хэмээх ойлголтыг хэрэглэсэн, энэ үндсэн дээр ёс зүйн (этосын) сайн чанарууд хэмээх ойлголтыг бий болгожээ.

Ес суртахууны алтан зарчим

Алтан зарчим бол ёс суртахууны хамгийн ерөнхий бөгөөд суурь зарчим мөн.

«Чамд хандуулан бусдаас (битгий) хийгээсэй гэж горилох зүйлээ чи бусдад хандуулан (битгий) хийгтүн».

Ес суртахууны алтан зарчим нь нийтийн хэм хэмжээнд захирагдаж байхыг бүх хүмүүсээс шаардаж, бүгдэд хамаарах тэрхүү хэм хэмжээг илэрхийлэх механизмыг илэрхийлдэг.

Кант

Аливаа нэгэн хэм хэмжээний нийтэд хамаарах ишинжийг тогтоохын тулд юуны өмнө түүнийг өөртөө нийцэх эсэхийг шалган үзэх хэрэгтэй.



Ес суртахуун нь хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулдаг, аливаа нэгэн үзэгдэл, үйл явдалд үнэлгээ өгөх чадварыг хүмүүст буй болгодог.

Ёс зүйн релятивизм

байгалийн хуулиуд объектив шинжтэй бол нийгмийн хуулиудийг хүмүүс өөрсдийн ашиг сонирхолыг харгалзан зохиодог гэж үздэг.

Протагор:

"Хүн бол бүхний хэмжүүр"

Эвдемонизм

(грекийн eudamonia - аз жаргал гэсэн үг) сайн, аз жаргал хоёр уг үндсээрээ ижил гэж үзээд тэдгээрийг хослуулахын чухлыг тэмдэглэж байв.

**Сократ,
Аристотель,
Платон нар**

Гедонизм

(грекийн hedone-таашаал гэдэг үг) Хүний ёс суртахуунт амьдрал нь таашаал хүртэхүйтэй салшгүй холбоотой гээд таашаал хэмээх ойлголтыг хэмжээ, хязгаар гэдэг ойлголттой шууд холбон авч үзжээ.

Демокрит

"Хамгийн сайн юм ч хэмжээ хэтэрвэл хамгийн муухай зүйл болон хувирна".

Кинизм

Хүний ёс суртахуунлаг амьдралын гол зарчим таашаал цэнгэлээс татгалзах явдат гэж үздэг

**Антисфен,
Диоген нар**

Дундад зууны ёс зүй

Дундад зууны үеийн оюуны амьдралын гол сургаал болж байсан теоцентризмын үүднээс ёс суртахууны үүсэл гарал, түүний мөн чанарыг Эзэн-Бурхан хэмээх ойлголттой холбон тайлбарлаж, ёс суртахууны итгэл үнэмшлийг хүн хоёр арга замаар олж мэддэг гэж номлож байв. Үүнд:

1. Эзэн-Бурхан хүний сүнсийг бүтээх үедээ түүнд ёс суртахууны анхны зарчмуудын суурийг тавьж өгдөг, эдгээр зарчим бол жам ёсны зан суртахууны хууль мөн.
2. Эзэн-бурхны зан суртахууны хууль (Библи) буюу хүн ухамсарт амьдралдаа олж эзэмшдэг ёс суртахууны хэм хэмжээнүүд (норм)-ийг Эзэн-Бурханы хүсэл эрмэлзлэлийн илрэл мөн гэж тайлбарладаг.

Шинэ үе

Протестант шашин уламжлалт католик шашны зарим хуучирсан зан үйлийг өөрчилж, хүний өдөр тутмын амьдрал дахь суртахууны ач холбогдлыг өндөр үнэлсэн аж.

Мөн католик шашны нөлөө сулран шинэ үеийн чөлөөт сэтгэлгээг илэрхийлсэн атеизм, деизм, скептицизм, пантеизм зэрэг янз бүрийн сургаал үүсэж, ёс зүйн шинэ шинэ урсгал гарч ирэх болжээ. Эдгээр урсгал хүний ёс суртахууны онолын зарим асуудлыг өөрөөр тайлбарлах болсон байна.

Ухаалаг эгоизм

Болж буй бүхэн зайлшгүй шинжтэйг ойлгож, тэр бүхэнтэй тэмцэж хүчээ үл тарамдуулан, хязгаарлагдмал бололцоотойгоо ухаарах үндсэн дээр аз жаргалтай байх хэрэгтэй.

Спиноза:

Аливаа юм байгаагаараа бол сайн ч биш муу ч биш байдаг, харин түүнийг ямар нэгэн юмтай харьцуулбал сайн болон муу шинжүүд нь ялгарч гардаг. Тийм болохоор эд баялаг, алдар нэр, мэдрэхүйн таашаал нь байгаагаараа үнэ цэнэтэй бус, харин хүний амьдарлыг сайн сайхан болгож чадах хэрэгслийнхээ хувьд л үнэ цэнэтэй юм.

Утилитаризм

Зөв буруу, сайн мууг ялгаж үзэх объектив зарчим бол "ашиг тусын зарчим" мөн.

Милль

Бүх хүн аз жаргалтай байхыг хүсдэг болохоор аливаа үйлдэл хамгийн олон хүнд хамгийн их аз жаргал хайрлах эрмэлзлэлийнхээ хэмжээгээр зөв байдаг. Аз жаргал буюу ашиг тус гэдэг бол цэвэр ариун, тасралтгүй удаан үргэлжлэх таашаал авах явдал юм.

Френсис
Хатчесон, Жеремиа
Бентам, Жон
Стюарт Милль нар



Кантын ёс зүй

Үүрэг гэдэг ойлголт Кантын хувьд зан суртахууны цэвэр ариун сэдэл тэмүүлэл, эрс тууштай итгэл үнэмшлийн илэрхийлэл болдог аж.

Үүрэг гэдэг ойлголтоор дамжуулан ёс суртахуунт ба ёс суртахуунт бус үйлдлүүдийн хоорондох ялгааг тодорхойлохыг оролдсон.

"сонирхлоор" хийж буй үйлдэл

"хүлээсэн үүрэг" ёсоор хийж буй үйлдэл

Кант:

Ёс суртахууны гол зарчим

бүх нийтийн хууль болж чадах уу? үгүй юү?

Кант ёс зүйн императивын тухай

"Ердөө л цорын ганц эрс императив бий, тэр нь: чи өөрөө удирдлага болгодог, тэгэхийн хамт бас түүнээ бүх нийтийн хууль болгохсон гэж хүсдэг тийм л максимын (зарчмын) дагуу үйлдэл юугаан хийж байгтун гэсэн императив юм.

Таамаглалт императив	хэм хэмжээний /норматив/ шинжтэй бөгөөд хэрэв та тийм тийм юм хийхийг хүсвэл та ингэж үйлдэх хэрэгтэй гэдгийг заадаг
Зайлшгүй императив	"хэрэв" гэдэг болзол тавихгүйгээр, тухайн үйлдлийн үр дүнг харгалзаж үзэхгүйгээр заавар өгнө.

2. Ёс зүйн орчин үеийн үндсэн баримтлалууд




Утилитаризмын гол үндэслэлүүд:

- ▲ Бүх хүмүүс өөрийн хүслээ хангахыг эрмэлзэж байдаг.
- ▲ Аз жаргал, ашигт төлөв байдал бол ямар нэг зовлон шаналалгүйгээр урт удаан хугацаанд бие, сэтгэлээрээ амсаж эдлэх таашаалтай ханамж юм.
- ▲ Бүх хүмүүсийг аз жаргалтай болгох нь ёс суртахууны үйлдлүүдийн эрхэм зорилго мөн.
- ▲ Тодорхой нөхцөл байдал бүрд хүртэж буй бие, сэтгэлийн ханамж, үр ашигт төлөв байдлууд нь бүх нийтийн аз жаргалд хүрэхэд дөхөм үзүүлж байх ёстой.
- ▲ Зөвхөн хувийн ашиг сонирголоо хангахыг эрхэмлэдэг аминч үзэл бүх нийтийн аз жаргал авчрахгүй.



Хүн төрөлхтөн, аль нэг улс орон бүх нийтийн аз жаргалд хүрэхэд саад тотгор болдог зүйлс:

- ▲ Хүмүүсийн биеэ тоосон зан авир
- ▲ Оюун санааны эрэмдэг төлөв байдал
- ▲ Төрөөс батлан гаргаж буй амьдралд үл нийцэх хуулиуд



Ямар нэгэн үйлдлийг буянтай, сайн болгож байгаа ёс суртахууны үнэлгээ нь энэ юмс үзэгдлийн талаархи өөр үнэлгээтэй давхцах ёсгүй. Өөрөөр хэлбэл прагматик үзлийн ашигтай байх, гедонист үзлийн тааламжтай байх болон гоо зүйн гоё, сайхан гэсэн үнэлгээнүүдтэй тохирох ёсгүй. Түүгээр ч барахгүй ёс суртахууны үнэлгээ нь эдгээр үнэлгээтэй зөрчилдөж байх учиртай

Метаэтикийг үндэслэгч МУР

Буянт үйлийн олон утга санаан дотроос "дотоод буянт үйл" гэсэн агуулгыг ялгаж "түгээмэл буянт үйл" гэж нэрлэсэн. Ямар ч нөхцөл, төлөв байдлын үед хувиршгүй байдаг ёс суртахууны зарчим бий. Жишээ нь: Амьдыг бүү хороо.

Дж. Мур ёс зүйн сонгодог баримтлалуудыг шүүмжилсэн нь

Гедонизмыг шүүмжилсэн нь: Сэтгэл ханамж бол буянт үйлийн төдийгүй нүгэлт үйлийн үндэс болж ч болно. Зовлон шаналал сэтгэлээс арилж, сэтгэл ханах нь буянт үйл болох төдийгүй эсрэгээр сэтгэл гонсойж шаналах нь буянт үйл болох тохиолдол ч байна. Ийм учраас буянт үйлийг сэтгэл ханамж хэмээн ойлгож үл болно. Буянт үйлийн хэмжүүр нь эддэж буй аз жаргалаас үүдэлтэй сэтгэл ханамж бус. Харин буянт үйлийн төлөө сэтгэл ханамжаас татгалзах учиртай байдгаараа ёс суртахуун онцлогтой юм.

Ёс зүйн натуралист хандлагыг шүүмжилсэн нь: Натурализм нь буянт үйлийг амьдралаа үргэлжлүүлж хөгжүүлэх үйлдэлтэй адилтгаж үздэг. Буянт үйл энэ үзэгдлүүдтэй адилтгагдах учиргүй. Амьдралаа үргэлжлүүлж хөгжүүлэх эрмэлзлэл нь аминч үзэл, нүгэлт үйлд хялбархан шилжиж болно. Харин буянт үйлийг эрмэлзэх нь амьдралаа золиослохыг ч шаардаж болно.

Утилитарист ёс зүйн хандлагыг шүүмжилсэн нь: Аливаа ёс суртахуунлаг хэрэг явдал, буянт үйлийн бүх төрөл өөрийнхөө үр дагавраар олонхид заавал аз жаргал эдлүүлдэггүй. Ёс суртахууны зарчмуудыг хэлбэрэлтгүй мөрдсөн юмуу эсвэл буянт үйлээр амьдарсан хүн бүрт аз жаргал хүртдэггүй. Заримдаа ёс суртахуунгүй хэрэг явдлын шагнал болж аз жаргал ирдэг. Ийм учраас буянт үйл, аз жаргал хоёрыг адилтгах нь зүйд нийцэхгүй.

Эмотивизмийг шүүмжилсэн нь: Ёс зүйн эмотивист үзэл нь зөв, буруу, буянт ба нүгэлт үйл гэх мэт бүх л ойлголтуудын үндсийг мэдрэмж, итгэл үнэмшил бүрдүүлдэг гэж үздэг. Зөв ба буруу үзэл санаа, үйлдлийг олонх хүмүүсийн сэтгэл хөдлөл юмуу итгэл үнэмшилтэй адилтгаж болохгүй. Зөв байхыг нийтлэг ач холбогдолтой төлөв байдалтай дүйцүүлэн ойлгож үл болно. Өөрөө бие даан шийдвэр гаргаж, чөлөөтэй сонгосон үйлдэл, гадны шахалт дарамтын улмаас хийсэн үйлдэл хоёрыг ёс суртахууны хувьд адилтгаж болно гэж үү? Буянт үйл гэж юу вэ? гэсэн асуулт өөр утга санаа агуулж байж болох юм. Ямар юмс үзэгдэл буянтай, сайн бэ? гэсэн утгаар бус харин буянт үйлийн агуулгыг тодорхойлох талаас нь асуудалд хандах ёстой. Ёс суртахууны хувьд буянт сайн үйлийг ном, өдрийн хоол, ерийн зан үйлдэл, хүн, амьтан гэх мэтгэй адилган үзэх боломжгүй. Хэрэв бид энэ юмс үзэгдлийг өөрийг нь судлаад эдгээрт байгаа буянт үйлийг эрж хайвал ойлгомжгүй байх болно. Харин тухайн үйлийн шинж, үр дагаврыг нь судлах замаар буянтай, сайн байгаа учир холбогдлыг нь олж чадвал ямар үйлийг буянтай гэж үзэх вэ? гэдэг нь ойлгомжтой болно.



Мета ёс зүй - Дж Мур /1873-1958/

ёс суртахууны хэлний задлан шинжилгээ нь ёс суртахууны асуудлыг шийдвэрлэх хэрэгсэл болно гэж үздэг арга зүйл үндэслэнэ.

Утилитаризм- Джон Милль /1806-1873/ Карл Поппер /1902-1914/ Дж Гриффин

Амьдралын чанарын зорилгот үзэл санаагаар баяжиж хувирсан ашигт ажиллагааны зарчим дээр уламжлал ёсоор тулгуурлаж амьдралаас амжилт олох, нийгмийн өглөг тусламж авах, хүслээ хангах бололцоо байдаг гэж үзнэ.

Прагматик ёс зүй- Джон Дьюи /1859-1920/

Ухаалаг эвлэрэлийн үйлдлийн үнэлэмжинд тулгуурласан аливаа хэрэгслээр зорилгодоо хүрэх боломж бий гэж

Зан үйлдлийн технологийн ёс зүй-Скиннер

Ёс суртахууны зарчмуудад тулгуурлахаасаа илүү өөрийгөө хамгаалах зөн совин дээр үндэслэсэн хүн, орчны харилцааг нарийн төвөгтэй ээдрээтэй болгодог онол юм.

Хувьслын ёс зүй-М.Рьюз, К.С.Льюис

Ёс суртахуун бол бүхнийг хайрлах альтруист шинжтэй гэж үзэж түүний уг чанарыг судалдаг.

Экзистенциалист ёс зүй

Сартр, Камю нарын үндэслэж томъёолсон ахуйн асуудлыг авч үзнэ.

Психоанализ ёс зүй- З.Фрейд /1856-1939/ Э.Фромм /1900-1980/

Өөрийгөө хамгаалах ба бэлгийн дур хүслийн зөн совингоос, эсвэл амьдралд тэмүүлэх анхдагч, үхэлд дурлах хоёрдогч зөн совингоос үүдэлтэй хэмээн ёс суртахууныг уг чанарыг тайлбарлана.

Хүч үл хэрэглэхүйн ёс зүй

Бие биенээ энэрч хайрлах сэтгэл, шударга ёс, хүлээцтэй байх зарчим дээр үндэслэнэ.

Экологийн ёс зүй

Амьдралын бүх төрөл, дүрс, байгаль орчныг хайрлах ёс суртахууны үнэлэмжийг чиг баримжаа болгоно.

Био ёс зүй

Биологи, анагаах ухаан, экологийн шинжлэх ухаануудын байр сууринаас үхэл, амьдрал болон бие махбодь, сэтгэл зүй, оюун санааны орилхуйн ёс суртахууны асуудлыг авч үзнэ.

3. Орчин үеийн хэрэглээний ёс зүйн асуудал

- ▲ Үр хөндөлтийг хуульчлан батлах хэрэгтэй юу?
- ▲ Найдваргүй болсон өвчтөний зовлонт амьдралыг таслан зогсоох нь зүй ёсны хэрэг үү?
- ▲ Гэр бүл салалтыг нийгэм хориглох ёстой юу?
- ▲ Ёс суртахууны хэм хэмжээний үүднээс эгоизмыг буруутгах нь зөв үү?
- ▲ Цаазаар авах ял байх ёстой юу?

Эдгээр асуудал тус бүрийн талаар нийгмийн байр суурь эдүгээ хүртэл тодорхойгүй байгаа юм.

Ёс суртахууны нээлттэй асуудалд байдаг нийтлэг шинжүүд



- ▲ Эдгээр асуудлууд нь нийгмийн хяналт болон оюуны зохицуулалтанд өртдөг нийгмийн амьдралын ил тод хүрээтэй шууд холбоотой байдаг. Жишээлбэл цаазаар авах ял бол төрийн зүгээс гарч буй ухамсарлагдсан, тодорхой шийдвэр байдаг учир хүн болгоны анхаарлын төвд байдаг юм.
- ▲ Нээлттэй асуудлуудыг бүрэн ухамсарлахад нарийн мэргэжлийн тодорхой мэддэг чухал ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл энд ёс суртахууны зөв сонголт нь өө сэвгүй мэргэжлийн шийдвэртэй нийцэх ёстой юм. Жишээлбэл хүний дотоод эрхтнүүдийг дамжуулан суулгах (трансплантаци) асуудлын талаар зохистой шийдвэр гаргахын тулд анагаах ухааны нарийн мэдлэг зайлшгүй шаардагддаг.
- ▲ Ёс суртахууны нээлттэй асуудлууд ёс суртахууны ерөнхий заалтуудаас гажиж байдгийг нь тэдгээр асуудлууд ёс суртахуунлаг шинжтэйн илрэл гэж нотлохыг оролдох нь бий. Жишээ нь, эвтаназийг хүлээн зөвшөөрөгчдийн үзсэнээр найдваргүй болсон өвчтөнг энэхүү зовлонт амьдралаас хагацахад туслах явдал бол нүгэл биш, харин буянтай үйл мөн гэдгээс харагдана.

Эдгээр асуудал нь зөвхөн нээлттэй нийгэмд бүрэн утгаараа оршиж байдаг учраас «нээлттэй» хэмээх тодотголтой юм. Тоталитар дэглэм ноёрхож буй нийгэмд ёс суртахууны нээлттэй асуудал дэвшүүлэх бололцоо нэн хязгаарлагдмал байдаг.

Хэрэглээний ёс зүйд хэлэлцдэг хоёр тохиолдол

Ёс суртахууны үндэслэлтэйгээр сайнаас няцах тохиолдлууд байдаг. Үүний нэг тод жишээ бол үр хөндөлтийн тухай асуудал юм. Хэрэв үр хөндөлтийг ёс суртахууны үүднээс зөвтгөвөл тэр нь "хүний амьдрал бол эрхэм дээд нандин зүйл" гэдэг хүн төрөлхтний хүмүүнлэг үзлийн гол зарчмаас гадуур байх болно.

Мууг хэрэглэхийг зан суртахууны үүднээс зөвтгөн зөвшөөрсөн тохиолдлууд байдаг. Үүний нэгэн жишээ бол сайны төлөө худал ярих явдал юм. Нэгэнт эмчилгээ авахаа больсон хүнд худал хэлж, үнэнийг нуун дарагдуулах нь "бүү худал хэл" гэдэг ёс суртахууны нэг зарчмаас гажиж байгаа хэрэг болно.



Эвтанази

Энэ нь «амар үхэл» гэсэн утгатай үг юм. Орчин үеийн анагаах ухаанд, тухайлбал анагаах ухааны ёс зүйд дээрхи ойлголт нь найдваргүй болсон өвчтөнг үхэлд зовлонгүй хүргэх гэсэн утга санаа агуулах болжээ.

Найдваргүй болсон өвчтөний амьдралыг эм тарианы хүчээр сунгах хэрэгтэй юу?

Тэр хүнийг энэ зовлонт амьдралаас чөлөөлж өгөх нь зөв үү?

Эвтаназийг дэмждэг үндэслэлүүд

- ▲ Таашаал нь зовлон зүдгүүрээс, эерэг сэтгэл хөдлөл нь сөргөөсөө давамгайлсан тохиолдолд л хүний амьдралыг дээд нандин зүйл гэж үзэх хэрэгтэй.
- ▲ Үхлийн ирмэг дээр байгаа хэн нэгний амьдралыг хүчээр тэтгэн үргэлжлүүлэхэд эмнэлгийн үнэтэй бөгөөд нарийн технологи, их хүч хөдөлмөр шаардагддаг. Үүний оронд эмчилгээ авах боломжтой олон хүнийг эмчлэхэд дээрхи хөрөнгө хөдөлмөр зориулагдах ёстой.

Мөн эвтаназийг ёс зүй, эрх зүйн үүднээс зөвшөөрөх нь эмч болон өвчтөний төрөл садныхан түүнийг зүй бусаар ашиглах аюулыг нэмэгдүүлэх сөрөг үр дагавартай. Орчин үеийн анагаах ухаанд найдваргүй болсон өвчтөний амьдрах хугацааг нь сунгах маш олон төрлийн эм тариа, шинэ технологи буй болжээ.

Эвтаназийг хэрэгжүүлнэ гэдэг нь дараах хоёрын алиных нь сонголт вэ?

- зовлонт амьдрал
- жаргалтай амьдрал

- зовлонт амьдрал
- даруй үхэл

+++

Үхэл нь үнэхээр зовлонт амьдралаас дээр байж чадах уу?

Эвтаназийг тууштай дэмжигчид ч энэ асуултанд шууд хариу өгч чадахгүй болов уу?

Ийнхүү хэрэглээний ёс зүйн нэгэн чухал асуудал болсон эвтанази нь хэзээ нэгэн цагт шийдэгдэх эсэх нь тодорхойгүй байна.

Цаазаар авах ял

Төр улс үүссэн цагаас хойш өнөөг хүртэл цаазаар авах ялыг хэрэглэсээр иржээ. Үүнийг түүхэн хөгжлийн үүднээс авч үзвэл дараахи зүйлүүд ажиглагдаж байна:

- ▲ Цаазаар авах ял оноодог гэмт хэргүүдийн тоо цөөрсөөр ирсэн. Жишээлбэл XIX зууны Англид 200 төрлийн гэмт хэрэгт цаазаар авах ял оноодог байсан

бол орчин үед онц ноцтой гэмт хэргийг санаатайгаар үйлдсэн, хүний амь хөнөөсөн зэрэг хүнд хэрэгт л дээд ял оноох болжээ.

- ▲ Цаазаар авах ял оноох хүмүүсийн тоо хорогдож байна. Олонхи оронд хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настай эрэгтэйчүүдэд цаазаар авах ял оноодоггүй болжээ.
- ▲ Цаазаар авах ялыг хэрэглэдэг улс орнуудын тоо цөөрч байна. Жишээлбэл дэлхийн нэгдүгээр дайны дараа өрнөд европын зөвхөн 7 оронд цаазаар авах ялыг зогсоосон байхад 1988 онд 53 оронд түүнийг халж, 27 оронд зогсоосон байна.
- ▲ Орчин үед цаазаар авах ялд хандах хувь хүний субъектив хандлага өөрчлөгдөх болсон. XVIII зуунаас эхлээд цаазаар авах ялыг эсэргүүцэх хандлага ажиглагдаж эхэлсэн. Орчин үед хүмүүсийн үлэмж хэсэг түүнийг эсэргүүцэн шүүмжлэх болжээ.

Энэ асуудлын талаар өөр хоорондоо ялгаатай заримдаа эрс тэс шинж чанартай үзэл бодол, хандлагууд байдаг.

**дэмждэг
зарим үндэслэл**

1. Цаазаар авах ял нь муу үйлдэлд өгч буй зохих ёсны шударга хариу.
2. Гэмт хэрэг хийхээс бусдыг урьдчилан сэргийлж, сүрдүүлэх нэгэн арга хэрэгсэл.
3. Онц аюултай гэмт хэрэгтнүүдийг нийгмээс тусгаарлаж өгдөгөөрөө нийгэмд ашиг тустай, хэрэгтэй зүйл.
4. Ялтны хувьд бүхэл насаараа хүнд хэцүү нөхцөлтэй шорон гянданд хоригдоноос цаазаар авхуулсан нь дээр (хүмүүнлэгийн үүднээс хандах гэсэн оролдлого).
5. Цаазаар авах ял нь аюултай гэмт хэрэгтнээс ангижирах хамгийн энгийн бөгөөд хямд арга

**эсэргүүцдэг
зарим үндэслэл**

1. Цаазаар авах ял нь нийгмийн зан суртахууныг завхруулан доройтуулдаг.
2. Хэрэгтнийг цаазаар авах явдал нь хууль бус үйлдэл, өөрөөр хэлбэл төрд ч хүний амийг хороох эрх байхгүй гэсэн үг.
3. Хүний эрх мэдлийн хэмжээ, цар хүрээ, хязгаарыг эвддэгээрээ нийгмийн шударга ёсыг худал хуурмаг шинжтэй болгодог.
4. Цаазаар авах ял нь хүн бол дээд нандин зүйл гэдэг ёс суртахууны гол зарчимд халдаж түүнийг хөсөрдүүлдэг.



III бүлэг. УЛС ТӨРИЙН ФИЛОСОФИ

1. Улс төрийн философийн үндсэн асуудлууд ба баримтлалууд

Улс төрийн философи бол хүчний байгууллагын мөн чанар, үндэслэгээний тухай сургаал юм.

Аристотель

Хүн бол хамгийн төгс амьтан, гэхдээ хууль, зүй ёсноос салахаараа хамгийн муу нь болдог.

Жон Сьюарт Милль

Иргэншсэн нийгмийн ямар ч гишүүнийг хүсэл зоригийнх нь эсрэг хууль ёсны дагуу албадаж чадах эрх мэдлийн цор ганц зорилго нь бусдад хохирол учруулахаас сэргийлэх явдал мөн.

Платон

Төрийн засаглалын дутагдлууд

Тимократ (timocracy) засаглал бол хүсэл, нэр төрийг удирдлага болгодог хүмүүсийн засаглал.

Олигархи буюу плутократ нь баячуудын засаглал. Энэ нь нэр төрд дуртайчууд засаглахаас ч дор.

Ардчилсан (democracy) засаглал бол засаглалын урьдах бүх хэлбэрээс муу, бууран доройтсон хэлбэр мөн. Хүч чадалгүй, бүдүүлэг олон түмний засаглал мөн.

Диспотизм (ганц хүний хэмжээгүй эрхт засаглал) бол засаглалын хамгийн муу хэлбэр. Хувь хүний эрх чөлөө үгүй болж, зүй бус байдал ноёрхдог.

Харин язгууртны буюу аристократ засаглалыг хамгийн сайн засаглал "шилдгүүдийн засаг" Харин хэн шилдэг юм бэ? Хэн илүү их гэгээрсэн нь л шилдэг байх ёстой. Гэтэл хэн илүү гэгээрсэн юм бэ? Философичид л илүү гэгээрсэн.

Аристотель

Төрийн тухай Аристотелийн үзэл нь "Улс төр" зохиолд нь тод тусгалаа олсон. Аристотель хэдийгээр шилдэг хүмүүсийн засаглалд итгэж, туйлын хэлбэрээр орших

Төр гэдэг бол нийгмийн байгууллагуудыг өөртөө хураангуйлсан, зөвхөн "оюун ухаант" төдийгүй "улс төрийн амьтан" болох хүний сайн сайхны төлөөх байгууллага юм.

ардчиллыг шүүмжилж байсан боловч Платоныг бодвол хамтын туршлага, хамтын оюун ухаан дээр тулгуурласан иргэний засаглалд илүү итгэж байлаа.

Аристотель "Ёс зүй" зохиолдоо нийтийн хэлэлцээний үр дүн болдог **конвенциаль хууль**, байгалиас шууд урган гардаг **байгалийн хууль** хоёрыг зааглаад "нийгмийн зохион байгуулалт байгалийнхаас шууд урган гардаг гэж үзсэн төдийгүй хүний сайн сайхны төлөө зүйл болох төр нь шууд "байгалийн бүтээгдэхүүн" мөн" гэж үзсэн.

Аквины Фома

Аристотелийн санааг Аквины Фома христос шашны утга, агуулгаар баяжуулан хөгжүүлжээ. Тэрээр дөрвөн төрлийн хуулийн тухай санаа дэвшүүлэв.

- ▲ Мөнхийн хууль. Энэ бол бурханаас гаралтай, хэзээ ч үл өөрчлөгдөх, бүх зүйлд үйлчилж, тэднийг захирдаг хууль юм.
- ▲ Байгалийн хууль. Энэ нь мөнхийн хуулиудаас хамааралтай, тэднээс урган гарч, хүн-нийгэмтэй холбоотой асуудлыг зохицуулдаг хууль мөн.
- ▲ Хүний хууль. Энэ бол байгалийн хуулиудаас хараат, тэднийг тодотгон, тодорхой нөхцөлд асуудлыг зохицуулах зорилгоор хүмүүсийн бий болгосон хууль юм.
- ▲ Тэнгэрлэг хууль. Хүн төрөлхтөнд ер бусын төгсгөлдөө хүрэх замыг зааж өгдөг хууль мөн.

Либерализм

Энэ бол бодгаль хүний эрх чөлөөг дээдэлдэг үзэл юм. Английн нэрт философич **Жон Локк** (1632-1704) сонгодог либерализмын үндсийг тавьжээ. Түүний нийгэм-улс төрийн онолд хэд хэдэн гол санаа байдаг.

Нэгд, Локк өөрийн өмнөх олон сэтгэгчдийн адил хүний үндсэн эрх, эрх чөлөө байгалийн хуульд өөрт нь байдаг гэж үзсэн. Тэрээр байгалийн хууль бол оюун ухаан заяагдсан бүх амьтанд өгөгддөг, ойлгогддог гэж үзсэнээрээ өөрийн эмпирик зарчмаа зөрчөөгүй.

Хоёрт, Байгалийн уг байдлынх нь тухай санаа юм. Английн философич Томас Хоббс, Жан Жак Руссо нарын үзэж байснаар байгалийн уг байдал гэдэг бол нийгэм-улс төрийн системийн хөгжлийн анхны эхлэх цэгтэй адил зүйл мөн.

Тэгэхээр хүмүүсийн жинхэнэ байдал гэж юу вэ? Байгалийн уг байдлын тухай санаа нь нэлээд онолын шинжтэй. Энэ санаа нь эрх чөлөө, тэгш байдлын тухай санаагаараа давуу талтай боловч бид ийм нийгэмд амьдарч чадахгүй, амьдарсан ч удаан амьдарч чадахгүй гэсэн санааг цаанаа агуулдаг.



Локкийн сонгодог либерализмын дөрвөн тулгуур

Байгалийн хууль

Нийгмийн гэрээ

Байгалийн төлөв

Дуугуй зөвшөөрөл



Марксизм

Марксизм бол либерализмын эсрэг үзэл юм. Энэ философийг үндэслэгч нь Германы сэтгэгч, нийгмийн онолч Карл Маркс (1818-1883) юм. Тэрээр хувь хүний дотоод дахь сайн чанар, хүний төгс төгөлдөр байдал, өөрийгөө хэрэгжүүлэх хүчин чадалд нь итгэж, хүмүүнлэгийн үзлийг өргөмжилж байв. Гэвч энэ үзлийг нь "нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал" гэдэг баримтлал нь захирдаг. Марксизмд хүнийсэх гэдэг ойлголт маш чухал байр эзэлдэг. "Хүнийсэх" гэдэг нь хөндийрөл, салалт гэсэн утга илэрхийлнэ. Маркс хүнийсгэлээр ажилчдыг капиталист эздээс нь салгахыг санаархаж байжээ. Маркс "Эдийн засаг, философийн гар бичмэл"-дээ хүнийсгэлийн тухай дараах хэдэн санааг гаргажээ.

Ажилчид (1) өөрсдийнхөө үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнээс, (2) өөрсдөөсөө, (3) өөрсдийн хүмүүн чанараас, (4) өөрсдийнхөө нөхдөөс хүнийсдэг.

Либертарианизм

Өөр бусад үзэл суртлын адил либертарианизм нь янз бүрийн хувилбартай. Гэвч либертари үзэлтнүүд дараах гурван зүйл дээр санал нийлдэг.

- ▲ Хувь хүний эрх чөлөө нь бусдад харшлахгүй бол түүнд саад тавьж болохгүй.
- ▲ Төр нь нийтийн сайн сайхны бүх зүйлийн төлөө хариуцлага хүлээх ёсгүй.
- ▲ Төр засгийн тухай "шөнийн харуул" гэдэг ойлголт ёсоор төр нь гагцхүү гадны халдлагаас хамгаалах, хувь хүний эрх, гэрээ хэлэлцээр зөрчигдөх гэх мэтээс сэргийлэх үүрэгтэй.

Тэгэхээр либертарианизм нь "Гараа тат!" гэсэн энгийн капиталист зарчмаас хамаагүй хол явжээ. Гэхдээ түүний чөлөөт үйлдвэрлэлийн зарчимтай холбогдсон холбоо бат бөх юм.

Хосперс:

*"капитализм, эрх чөлөө,
элбэг баян байдал" нь
коммунист системийн
"эээрхэг ёс, зохицуулалт,
гуйланчлалтай" зөрчилддөг.*

Херберт Маркузе:

*Хосперсийн магтаад
байгаа элбэг баян байдал нь
чөтгөр дүрээ хувилгачихаад
байгаа хэрэг юм, орчин
үеийн капиталист нийгэм
өөрсдийнхөө иргэдийг хуурч,
хүнийсгэлийн нэг хэлбэрийг
үлэмж залъжын өөр хэлбэрээр
сольсон байна. Энэ нийгэмд
амьдралын түвшин өндөр
байгаа нь үнэн, гэхдээ энэхүү
амжилт нь хуурамч юм.
Өр төлөөс нь бүр хожим
хүмүүсийн бодож байгаагаас
ч илүү хүндээр тусах болно.*

Ийн капитализмыг шүүмжлэх нь өчнөөн ч гэлээ тэрээр эрх чөлөөтэй салшгүй холбогдож либерал нийгэм рүү хөтөлдөг. Эрх чөлөөг өмгөөлөн хамгаалдаг үзлийн үүднээс либерал нийгэм нь либерал бусаасаа илүү гэж хэлэх нь зүй ёсонд нийцнэ.

2. Зүй ёсны онол

Жон Раулсын хэлснээр
*"сэтгэлгээний системд
үнэн гэдэг ойлголт ямар
байр суурь, үүрэгтэй байдаг
шиг зүй ёс гэдэг ойлголт
нь нийгмийн системд тийм
байр суурь, үүрэгтэй"*

Нийгэм, улстөрийн философийн магадгүй хамгийн чухал санаа болох зүй ёсны тухай тогтож хэлэлдэхгүй бол болохгүй.

Хэрвээ зүй ёсны тухай тодорхой ойлголттой болчихвол асуудал нилээд цэгцрэхсэн. Гэвч энэ нь бодсон шиг тийм ч амар биш юм. Эрэгцүүлэх тусам зүй ёсны тухай санаа нь тэгш эрх, шударга ёстой холбоотой бүрхэг ойлголт болж ч мэднэ. Гэтэл тэгш эрх, шударга ёсыг юу бүрдүүлдэг вэ? Тэд барааны хуваарилтанд хамаарах уу? Гэхдээ хэр ихээр, ямар үндэслэлээр хамаарах вэ? Зүй ёс давуу талтай холбоотой юу? Гэтэл давуу талын үндэс нь авьяас уу, хүч чадал уу, бүтээмж үү? Нийгмийн хариуцлагатай тэрээр холбоотой юу? Гэтэл үүнийг яаж хэмжих вэ?

Ёсзүй, нийгэм, улстөрийн онолуудад зүй ёсны янз бүрийн санаа ил, далд байдлаар тавигдаж иржээ. Тухайлбал:

Платон:

*төр, бодгаль хүн хоёул
оюун ухаанд захирагдаж
байвал зүй ёс*

Мильт:

*хэдий л олон хүн аз
жаргалтай байна тэр
бол зүй ёс*

**Маркс:**

*Хүн чадварынхаа хэрээр авах
зарчмаас хэрэгцээнийхээ
хэрээр авах зарчим руу явж
байвал зүй ёс*

Хосперс:

*Чөлөөт үйлдвэрлэл бол
зүй ёсны хэрэгжилт*

Орчин үед зүй ёсны асуудал нь нийгэм дэх баялгийг хэрхэн хувиарлах вэ? гэдэг асуудалтай холбогдон гарч ирж байна. Баялгийг тэгш эрхийн зарчмын үүднээс хуваарилах уу, эрх чөлөөний зарчмын үүднээс хуваарилах уу гэдэг нь өөрөө том асуудлыг дэвшүүлдэг.

Раулс энд зүй ёсны либерал онолыг дэмжсэн. Тэрээр энэ онолдоо тэгш эрх, эрх чөлөө хоёрыг аль болохоор зохицуулах оролдлого хийсэн юм. Өнгөц харахад энэ хоёрт зохицож боломгүй зүйл байгаагүй. Харин бодит байдал дахь тодорхой бодгаль хүмүүс дээр авч үзэх юм бол огт өөр байдаг.

Жишээ нь А, Б гэдэг хоёр бодгаль хүний эрх чөлөөг хүлээн зөвшөөрвөл хэн илүү авъяас чадвар, оюун ухаантай нь (А-г нь гэж саная) илүү баялаг хуримтлуулна, тэгснээрээ ч хүссэн хүсээгүй А нь илүү эрх мэдэлтэй болно. Өөрөөр хэлбэл тэгш эрх нь зөрчигдөнө.

Тэгвэл тэгш эрхийг гол зарчмаа болгож тэр хоёрт баялгийг адил хэмжээгээр хуваарилсан гэж бодъё. Гэтэл энд А-гийн авъяас чадвар, бололцоогоо бүрэн ашиглах эрх чөлөө алдагдаж байна.

Асуудлыг гурав дахь талаас нь авч үзэх юм бол А-гийн авъяастай болсон нь түүний өөрийнх нь ач гэхээсээ илүү байгалийн "ач" байдаг. Б-гийнх үр дүн бага боловч зүтгэл нь их байсан байж болно шүү дээ.

Энэ асуудалд тэгш эрхийг хүндэтгэгч эгалитари үзэлтнүүд (улс төрийн зүүний хүч) Б-гийн эрх ашгийн үүднээс хандаж байхад, эрх чөлөөг эрхэмлэгч либертари үзэлтнүүд (улс төрийн барууны хүч) А-гийн эрх ашгийн үүднээс ханддаг. Раулс энэ хоёрыг зохицуулсан либерал онол гаргах оролдлого хийжээ.

Зүй ёсны гурван үзэл

▲ Либертари

Хувь хүний эрх чөлөө бол нийгмийн хамгийн дээд эрхэмнэл

▲ Социалист

Хүний тэгш эрх бол нийгмийн хамгийн дээд эрхэмнэл

▲ Либерал

Эрх чөлөө, тэгш эрхийн хослол бол нийгмийн хамгийн дээд эрхэмнэл

/а/ Хэлцлийн

Илүү их халамжтай тэгш эрхийг дүйцүүлнэ

/б/ Утилитари

Аз жаргалыг нэмэгдүүлж байвал ямар ч төрлийн тэгш бус байдлыг хүлээн зөвшөөрнө

Раулс өөрийнхөө онолын гол зүйл болгож уг төрөлх байдал буюу гипотетик нөхцөл гэсэн ойлголт гаргаж ирсэн. Энэ бол Локк зэрэг философичдын хэрэглэдэг байсан байгалийн уг байдал гэдэгтэй нэлээд төсөөтэй ойлголт. Раулс энэ ойлголтоороо сонгогч сонгуульд зөвхөн өөрийн эрх ашгийн үүднээс асуудалд хандах аргагүй тийм нөхцөл байдлыг бий болгохыг илэрхийлэхийг оролдсон. Үүний тулд үл мэдэхийн хөшиг гэдэг ойлголт гаргаж ирсэн. Үүнийгээ шударга байх гол нөхцөл гэж үзсэн юм. Энэ ойлголт ёсоор сонгуульд сонгогчийн өгсөн санал өөрт нь (өөрийнх нь нийгмийн байр суурьд) ашигтай байх уу, үгүй юу гэдэг нь мэдэх аргагүй байх ёстой байна.

Раулс орчин үеийн капитализмын мөн чанар, нийгмийн чин эрмэлзлэлд зохицуулан хоёр зарчим гаргаж ирсэн. Энэ нь дээр хэлж байснаар либертарианизм, эгалитарианизм хоёрыг харгалзсан зарчмууд юм.

Зүй ёсны талаарх Раулсын хоёр зарчим

- ▲ Бүх хүн угаасаа тэнцүү эрхтэй байх зарчим: хүн бүр бусад хүнд байдаг тэр эрх чөлөөгөөр хангагдах эрхтэй.
- ▲ Ялгаатай байх зарчим: нийгэм дэх хүмүүс ялгаатай байдалд байдаг бөгөөд энэ нь а/ хувь хүмүүсийн авъяас чадвар, оюун ухаантай холбоотой, б/ зарчмын хувьд бүгдэд нээлттэй байдаг боловч бүх хүн зэрэг хийж болдоггүй ажил алба, албан тушаалтай холбоотой

Зүй ёсны тухай Раулсын ерөнхий баримтлал

Раулсынхаар зүй ёсны талаарх хоёр зарчим нь ерөнхий нэг баримтлалын жич илэрхийлэл юм:

- ▲ Нийгмийн бүх баялаг хүн нэг бүрийн давуу талаас бүрдсэн тулд түүнийг тэгш хуваарилна.

Нозикийн үзлээр зүй ёс бол эрх мөн. Энд нэгэн тайлбар хийхэд Нозикийн яриад байгаа эрх бол хуулийн эрх биш өөрийн хүч авъяас, хөдөлмөрөөр бий болгосон зүйлийнхээ тухайд ярьдаг эрхийн асуудал юм. Жирийн амьдрал дээр ч хүмүүс "бингэх эрхтэй" гэж ярьдаг тэр эрх мөн.

Бидний татсан жишээн дээр А, Б хэмээх хоёр хүний тухайд бол Нозик шууд А-гийн талд зогсдог. Тэрээр хэрэгцээг харгалзсан тэгш байдлын төлөө бус, харин эрхийг харгалзсан тэгш байдлын талд байдаг. Нозикийн онолд байдаг хоёр үндсэн зарчим бол а/ хамгийн бага засаглал; б/ зүй ёс гэдэг бол эрх. Энэ санаануудаа "Анархи ёс, төр, утопи" зохиолдоо гаргажээ.

1-р зарчмаас эхэлье. Нозик "шөнийн харуулын төрийн тухай ярьсан. Ес төдий харуул гэдэг шиг ёс тэдий төр байх ёстой байна. Ийм төр нь зөвхөн иргэдийн эрх, өмчийг л хамгаалж байх ёстой. Төр бодгаль хүний эрхийг зөрчиж огтхон ч болохгүй. Эндээс Нозик Локкын уламжэалыг баримтладаг нь тод харагддаг.

Хүний төрөлх эрхийн нэг бол өмчтэй байх эрх юм. Бодгаль хүний өмчтэй байх эрхийг хүлээн зөвшөөрнө гэдэг бол өмчтэй хүмүүсийн эрхийг зөрчихгүй байх үүргийг бий болгож байгаа хэрэг. Нозикийн хувьд хувиарлалтанд эрх гол зарчим болох ёстой. Төрд хэн нэгэн хүн өөрийнхөө хүч хөдөлмөр, авъяас чадвараар бий батгосон зүйлийг хүчээр авч өөр хүнд өгөх эрх байх ёсгүй. Тэгэхээр татварын тухай асуудлаар Нозик сайн дурын өглөгт найдвар тавьдаг.

Нозикийн эсрэг зогсогчид дараах баримтлалуудыг гаргаж ирж байна. Нэгд, татвар ч бай, өглөг ч бай эцсийн эцэст нөгөө яриад байдаг эрх нь зөрчигдөж байна. Хоёрт, түүний онол нь "ёс суртахуунгүй", өөрөөр хэлбэл бусдад туслахаас татгалзахыг зөвтгөдөг.



Эзэмшил дэх зүй ёсны талаарх Нозикийн гурван зарчим

▲ **Өмчлөл дэх зүй ёсны зарчим**

Урьд нь хэн ч өмчилж байгаагүй тэр зүйлийг өмчлөх эрхтэй. Ингээж өмчлөгдөн, үнэлэгдсэн зүйлс бол хууль ёсны зүйл юм

▲ **Шилжүүлэхүй дэх зүй ёсны зарчим**

Өмчилсөн зүйл нь хэн нэгнээс хууль ёсоор шилжиж ирсэн байж болно.

▲ **Эзэмшихүй дэх зүй бус байдлыг залруулах зарчим**

Хууль бус эзэмшлийн эх булгийг тогтоож, хохирогчид буцаан олгохын тулд шударга зүтгэл гаргах хэрэгтэй

Майк-Интайр зүй ёс бол сайн сайхан байдал мөн гэж үзсэн. Тэрээр Нозик, Раулс хоёроос хоёулангаас нь өөр үзэл баримталдаг.

Раулс, Нозик хоёрт Майк-Интайр дургүйцэх болсон бас нэгэн шалтгаан бол индивидуализмыг нийтийнхээс дээгүүр төдийгүй түүнд сөргүүлэн тавьсанд оршино. Тэр хоёрын онолын хамгийн сул тал нь нийтийн үзэл санаа байдаггүйтэй холбоотой. Майк-Интайрын үзэж буйгаар бодгаль хувь хүн сайн, сайхан гэж үзэж буй зүйлээ нийтийнхтэй холбоотой авч үздэг байх ёстой.

Майк-Интайр өнгөрсөн, одоо хоёрын холбооны асуудал дээр нэлээд анхаарал тавьсан. Түүнийхээр Раулс, Нозик хоёр өнгөрснийг үл тоомсорлодог. Майк-Интайр: өмчлөх эрхийн асуудлыг авч үзэхдээ түүний өнгөрснийг заавал харгалзан үзэх шаардлагатай гэж байв. Энд зүй ёсны ёс суртахуунлаг байдал харагддаг. Ёс суртахуунлаг-буянлаг байдал гэдэг бол сайн сайхан байдлын төлөө үйлдэх боломжтой байрлал юм.

Үүнийг нийгмийн түвшинд хэрхэн ойлгох вэ? Майк-Интайр хүн бол нийгмийн амьтан гэсэн Аристотельч уламжлалаас энэ асуудалд хандсан юм. Энэ ёс суртахуун гэдгийг нийтийн сайн сайханд хүрэхэд тусалж байгаа тэр зүйл гэж ойлгосон.

Майк-Интайрийн үзэлд Жоил Фейнберг гэдэг хүн нэлээд эргэлзэж доорхи хэдэн асуулт тавьсан байдаг.

- Хүн хийснээсээ илүү зүйлээр шагнагдах ёстой юу?
- Бодгаль хүн дэх ёс суртахууны дутагдлуудыг "цагдах-хянах" боломжтой юу?
- Ёс суртахууны идэвхийг эдийн засгийн шагналаар шагнах нь зүйтэй юу?
- Ёс суртахууны идэвхийн төлөө өөр шагнал байж болох уу?

Түүнээс гадна тэрээр "шударга боломж"-ийн шаардлага гэдгээр боломжит 5 шалгуурыг нэрлэсэн.

- Тэгш байдал
- Хэрэгцээ
- Давуу байдал
- Оролцоо
- Зүтгэл

Мэтгэлцээний сэдлүүд:

Тохиолдол 1.

Нийгмийн бүх баялагийг тэгш хуваарилах нь зүй ёсонд нийцэх үү? Нийцэх бол яагаад? Нийцэхгүй бол яагаад?

Тохиолдол 2.

Нийтийн эрх ашгийн үүднээс хувь хүний халдашгүй, дархан эрхийг хязгаарлаж болох уу?

Тохиолдол 3.

Эрх чөлөө болон тэгш ёс нь бие биетэйгээ зохицож болох уу? Яагаад?

Тохиолдол 4.

Монгол улсад төрийн албан хаагчийн нэг хүүхдийн их дээд сургуулийн сургалтын төлбөрийг нь төрөөс дааж байгаа нь зүй ёсонд нийцэх үү? Яагаад?

3. Биологийн ялгааны улс төрийн үр дагаварын философи асуудал

Хүний бүхий л эрх, эрх чөлөөг яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа байдлын ялгааг эс харгалзан ямарч гадуурхалгүйгээр эдлэх ёстой.

Тухайн хүний харьяалдаг улс буюу нутаг дэвсгэрийн улс төр, эрх зүйн болон олон улсын статус ямар ч байлаа гэсэн, тухайлбаё тусгаар тогтносон, буюу асрамжинд байгаа, өөрөө эс удирдах зэрэг бүрэн эрхэт байдал нь өөр ямар ч байдлаар хязгаарлагдмал байсан, тэр нь ялгаварлах үндэс болохгүй.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын хоёрдугаар зүйл

Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 2-р бүлгийн 14 дүгээр зүйл

Феминист онолчид шоовдор байдлыг /маргиналь/ зөвхөн эмэгтэйчүүдтэй холбоотой төдий биш, нийгмийн шударга бус байдал, тэгш бус байдал, дарлал мөлжлөгийн золиос болж байгаа аливаа хүний оршихуйн үндсэнд байдаг зүйл гэсэн өргөн утгаар авч үзэж, янз бүрийн шалтгаанаар тухайлбал *арьсны өнгөний ялгаа, хүйсийн тэгш бус байдал, ангийн хамаарал, нас үндэстний ялгаа, хөгжлийн бэрхшээл, бэлгийн хандлага* зэргээсээ болж шоовдорлогдсон хүмүүсийн нийгмийн эрс ялгаралыг арилгах, хүч үл хэрэглэх хамтрах зэрэг зорилтыг улс төрийн зөвлөмж болгодог.



Гэвч энэхүү биологийн ялгаатай байдлаар гадуурхах хандлага нь нийгмийн олон салбар, амьдралын хүрээнд амь бөх оршсоор байна.

1.Арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах

Эдүгээ ч арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл нь зөвхөн хар арьстан төдийгүй өнгөт арьстан, шар арьстан ази иргэд, цагаач иргэдийн нийгмийн статус нь европын ихэнх орнуудад нийгмийн олон салбар хүрээнд илэрсээр байдаг. 1950- оны сүүл, 1960-аад оны эхнээс Ж.Кроугийн систем төгсгөл болсоны дараа Америкт хар арьстан хүн сая бусадтайгаа адил нэр төр, эрх эдлэх болсон.

2.Хүйсээр нь ялгаварлан гадуурхах

"Хүйс" гэдэг үгийн үндсэн агуулга нь биологийн шинж юм. Хүйс гэдэг **үг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн биологи ялгааг** илэрхийлдэг ба эндээс "хүйсийн" гэдэг үг анатомийн болон физиологийн утгатай хэрэглэгдэнэ. Үгийн энэхүү утга нь хүйсэнд хамаатай боловч биологийн бус олон хүрээ болох зан үйл мэдрэхүй, сэтгэлгээ, хийсвэрлэлийн олон талыг огтхон ч хамаарахгүй байгаа юм. Харин психологийн тэрхүү үзэгдлүүдийн хувьд бид "жендер" гэдэг ойлголтыг хэрэглэдэг. **Жендер нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгмийн ялгаатай байдлыг илэрхийлдэг.**

3.Бэлгийн хандлагаар ялгаварлах нь

Бэлгийн өөр хандлагаар нь хүнийг ялгаварлан нийгмээс тусгаарлах үзэгдэл байсаар байна. Гомосексуалистуудын хувьд энэ нь бие махбодийн хүчирхийлэл, ажилд ороход шоовдорлогдох, хувийн харилцаагаа таслах, гутаан доромжилсон нэр хоч хүртэх, доог тохуу болох хэлбэрүүдээр илэрдэг. Тэд энэхүү хавчигдмал байдлаасаа болж сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой асуудал үүсэн, ихэнх тохиолдолд "нуугдмал" байдалд орох гарцаагүй шаардлага гардаг.


Бодгаль хүний зайлшгүй шинж бол түүний гетеросексуаль чанар мөн гэдэг тодорхойлолт XX зууны 80-90-ээд онуудаас хойш нийгэм улс төрийн хүрээнд ихээхэн маргаан дэгдээж байгаа юм.

Кэйт Миллет, Кэрол Пэйтмон:

Гетеросекс үзэл суртал нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн хоорондын биологийн ялгааг хэтрүүлэн үзэх хандлагатай бөгөөд эрэгтэйчүүд үргэлж давамгай үүрэг гүйцэтгэдэг, харин эмэгтэйчүүд захирдмал үүрэг хүлээдэг гэдгийг илэрхий болгох зорилготой юм.

Хүний бэлгийн мэдрэмжийг нийгмээс ямар нэгэн шахалт дарамт учруулснаар тодорхойлох боломжгүй, гетеросексуаль чанараас өөр бэлгийн мэдрэмжийг нийгэм хүлээн зөвшөөрөхөөс зайлсхийдэг учир гетеросексуаль чанар хүний зайлшгүй шинж болж хувирдаг.

Дараахь тоон үзүүлэлтэд анализ хийн, ярилцаарай.



Source .U.S. Census Bureau, Poverty in the United states: 1999. CRP P60-210

Арьс өнгөний ялгаатай байдал ядууралтай холбогдох нь:

Өнөөгийн барууны нийгэмд хамгийн нэр хүндтэй, өндөр байр суурьтай мэргэжлийн ажлын байрны дийлэнхийг эрэгтэйчүүд эзэмшсэн байдаг. Тухайлбал:

Эрдэм шинжилгээний ажилтан	80%
эмч	84%
их сургуулийн профессор	61%
өндөр статус бүхий байнгын профессор эмэгтэйчүүд	10%
шүүгч, өмгөөлөгчид	78%
зохион бүтээгч болон инженер	94%

"Америкийн Нэгдсэн Улсын статистик судалгаа". 1991 он.

Өндөр хөгжилтэй зарим улс оронд эрэгтэй, эмэгтэйчүүдийн хөлс төлөлт ялгаатай байх хууль бус ч гэлээ эмэгтэйчүүд бага цалин авдаг хэвээр байна. Тэгш төлөх тухай хууль гарахаас өмнө 1970 онд Англид эмэгтэй хүн эрэгтэйчүүдийн хөдөлмөрийн хөлсийн 63 хувьтай тэмцэх хөлс авч байв. 1993 он гэхэд байдал өөрчлөгдсөн ч 79 хувьд л хүрэх болжээ. АНУ-ын Хөдөлмөрийн яамнаас гаргасан статистикийн цагаан арьс эрэгтэйн дундаж орлого 6704 ам. доллар, өнгөт арьст эрэгтэйнх 4277 ам.доллар байгаа бол цагаан арьст эмэгтэйнх 3991 ам. доллар, өнгөт арьс эмэгтэйнх 2816 ам.доллар байна. Ийнхүү эмэгтэйчүүд эрчүүдийг бодвол нийгмийн статусаараа доогуур байдал өнөө хэр хэвээр байна.



Эмэгтэйчүүдийн ажил, мэргэжлийн эзлэх хувь

Мэргэжил	1983	1998
Нарийн бичгийн дарга	99.0	98.4
Шүдний эрүүл ахуйч	98.6	99.1
Сургуулийн өмнөх болон хүүхдийн цэцэрлэгийн багш нар	98.2	97.8
Бүртгэл хөтлөгч	95.8	92.5
Мэдээ хөтлөгч	93.6	81.8
Банкны мөнгөний нярав	91.0	89.5
Телефон ажиллуулагч	90.4	85.8
Үсчин болон гоо сайханч	88.7	90.8
Үйлчлэгч болон хоол зөөгч	87.8	78.3
Анхан шатны сургуулийн багш	83.3	84.0
Нийгмийн ажилтан	64.3	68.4
Дээд сургуулийн багш	51.8	56.9
Үнэ хямдарсан барааны төлөөлөгч	48.9	53.0
Редактор, сурвалжлагч	48.4	51.0
Коллеж, их сургуулийн багш	36.3	42.3
Өмгөөлөгч, шүүгч	15.8	28.6
Физикчид	15.8	26.6
Цагдаа, тагнуулч	9.4	16.3
Инженерүүд	5.8	11.1
Лам хуврагууд	5.6	12.0
Ачааны машин жолоодогч	3.1	5.3
Нисэх онгоны нисгэгч	2.1	3.4
Мужаан	1.4	1.2
Гал сөнөөгч	1.0	2.3
Суудлын автомашины механикч	0.5	0.8


*Source U.S. Census Bureau, Statistical Abstract of
the United States 1999, Table 675.*

IV бүлэг. МЕТАФИЗИК БА ОНТОЛОГИ



Үгийн утга:

Энэ нэр томъёог анх Грекийн философич Андроник /Хр.Т.III зууны үед амьдарч байсан/ Аристотелийн бүтээлүүдийг эмхэлж цэгцлэн хэвлэлд бэлтгэж байхдаа тухайн үеийг хүртэл тодорхой нэргүй байсан бөгөөд физик нэртэй зохиолынх нь дараагаар хэвлэх бүтээлүүдийг хамтатган "Метафизик" гэж анх хэрэглэжээ.





Метафизик асуудлууд ба категориуд

Ахуй

Объектив оршиж байгаа бодит байдлыг тэмдэглэх философийн үндсэн ойлголт, категори юм.

Янз бүрийн материаллаг болон санаалаг юмс үзэгдлүүдэх "оршин байгаа" нийтлэг шинжийг ахуй хэмээх категориор илэрхийлдэг.

Субстанци латин хэлний substantia -мөн чанар, үндэс суурь, эхлэл болж байдаг зүйл гэсэн утгатай үг.

Философийн сургаалд энэ ойлголтоор байнга харьцангуй тогтвортой, гаднын өөр зүйлээс шалтгаалахгүй, өөрөө өөртөө шалтгаан болон бие даан оршиж байгаа ямар нэг юмыг тэмдэглэдэг.

Философид цорын ганц субстанци байгааг зөвшөөрдөг^монист, хоёр субстанцийн оршин байгааг зөвшөөрдөг - **дуалист**, олон субстанцийн оршин байгааг зөвшөөрдөг - **плюралист** чиглэлүүд байдаг.

Субстрат - латин хэлний substratum- үндэс гэсэн үгнээс гаралтай.

Аливаа үзэгдэл үйл явцын үндэс болдог, юмс үзэгдэл, ойлголтоос салгаж болохгүй гол шинж агуулгыг тэмдэглэдэг ойлголт

Матери- латин хэлний materia -биет зүйл гэсэн үгнээс гаралтай.

Мэдрэхүйн эрхтэнд өгөгддөг биет юмсын үндэс, субстрат.

Аристотель

Матери бол цэвэр бололцоо, хэлбэржих чадвар.

П.А.Гольбах

Матери бол бидний сэрэлд өгөгдөж буй бүхэн мөн.

Р.Декарт

Матери бол орон зайн дотор үргэлжлэх, хуваагдах чанар бүхий биет (материаллаг) субстанци.

В.И.Ленин

Матери бол бидний сэрлийн гадна оршиж, сэрлээр дамжин хуулбарлан буулгагдаж, тусгагдаж байдаг объектив бодит байдлыг тэмдэглэсэн философийн категори мөн.

Эзэн-Бурхан (God) оршдог уу?

Философийн, түүний дотор метафизикийн бүх асуудлыг теологийн сургаалд багтаан түүний гол цөм нь эзэн-бурхны оршин байхуйн буюу ахуйн нотолгоо гэж христос шашны ариун хутагт Аквины Томас (Фома) үзжээ. (энэ асуудлыг шашны философи сэдэвт хичээлээс дэлгэрэнгүй үзнэ үү) ухаан уу? эсвэл матери уу?

Оюун ухаан уу? эсвэл матери уу?

Юу оршдог вэ? Зөвхөн физик объектууд л оршдог уу? Оршин байх гэдгийн дор бид юуг ойлгох ёстой вэ? Аливаа үйл явдал бүхэн шалтгаантай юу?



Энд "оршихуй" нь бодитой бүхэн гэсэн маш өргөн утгатай.

Идеализм

Оюун ухаан бол эцсийн шатггаан бөгөөд бүх юмс оюун ухаан ба санааны ачаар л тогтож байдаг хэмээдэг метафизик үзэл мөн.

Объектив идеализм

Оюун ухаан бол тусгаар хүмүүсийн мэдрэхүйгээс гадна бие даан оршдог.

Субъектив идеализм

Оюун ухаан болон санаа нь бидний мэдрэхүйгээр нөхцөлддөг.


Материализм

Матери, түүний хөдөлгөөн, чанарууд нь бодитой оршин байгаа бүх юмны эцсийн зүйл мөн.




Орон зай ба цаг хугацаа

Орон зай, цаг хугацаа бол жирийн тусгаар юмс хадгалж байдаг онцгой давуу зүйл юм үү? Эсвэл цаг хугацаанаас өмнө, орон зайгаас дээгүүр байдаг тусгаар юмсын харилцааны систем төдий юм уу?




V бүлэг. ЭПИСТЕМОЛОГИ

1. Мэдлэгийн төрөл, хэлбэрүүд, тэдгээрийн харилцаа






Философичид мэдлэгийн янз бүрийн төрлүүдийг ангилан үздэг. Тухайлбал:¹



Мэдлэг бол маш баялаг бөгөөд олон тал, олон хэлбэр бүхий үзэгдэл юм. Түүхэн тодорхой нийгэм соёлын нөхцөлд мэдлэгийн дүр төрх маш олон янз байдаг.




¹The Cambridge Dictionary of Philosophy. Cambridge University Press. 1999.

**Ердийн мэдлэгийн
онцлог шинжүүд**

- ▲ хүн бүр олж авч чаддаг
- ▲ төрөлжиж, мэргэшээгүй
- ▲ бичгийн биш шинжтэй
- ▲ харьцангуй тогтвортой, шүүмжлэлд төдийлөн өртдөггүй
- ▲ хүн бүхэн ердийн мэдлэгийн санг ямар нэгэн илүү хүч чармайлт гаргахгүйгээр, тусгайлан зориуд суралцахгүйгээр амьдралынхаа явцад аяндаа олж авдаг

Мэдлэгийн төрөл, хэлбэрүүд бие биедээ харилцан нөлөөлөх, зэрэгцэн орших байдал нь түүхэн тодорхой үе шат бүхэнд ялгаатай байжээ. Орчин үеийн эпистемологид мэдлэгийн олон янз байдлыг тэдгээрийн статус, функци, үнэлэмжийнх нь хувьд нэгэн зиндаанд авч үзэх болжээ.



Шинжлэх ухааны бус мэдлэгийн хэлбэр тус бүр өөрийн өвөрмөц онцлог бүхий бөгөөд тэдгээр нь шинжлэх ухааны мэдлэгт зуршмал байдаг шинжүүдээс ангид байдгаараа нийтлэг юм. Мэдлэгийн шинжлэх ухааны бус төрлүүд нь эх сурвалж, буй болох арга, үндэслэгдэх байдал, дамжуулах арга зэргээрээ бие биенээсээ ялгаатай.

**Шинжлэх ухааны
мэдлэгийн онцлог**

- ▲ объектив агуулгатай
- ▲ эмхэрч цэгцэрсэн, төрөлжиж мэргэшсэн, системлэг шинжтэй
- ▲ бүтцийн хувьд эмпирик ба онолын гэсэн түвшинтэй, тэдгээр тус бүр нь нарийн бүтэц бүхий систем
- ▲ төлөгчлөх/урьдчилан хэлэх/ шинжтэй
- ▲ шинжлэх ухааны судалгааны тусгай хэл, арга, хэрэгслийг шаарддаг.
- ▲ институтжсэн зохион байгуулалттай



2. Үнэний талаархи баримтлалууд, үнэний шалгуурын асуудал

Танин мэдэхүйн зорилго бол үнэн мэдлэг олж авах явдал билээ. Танин мэдэхүйн онолд үнэн бол танин мэдэхүйн зорилго төдийгүй, мөн түүний судлах зүйл нь болдог. Танин мэдэхүйн онолд үнэний тухай ойлголт нь ямар нэгэн юмыг тэмдэглэсэн мэдлэг төдий биш, харин тэр мэдлэгийг тодорхойлоход хэрэглэдэг ойлголт юм.

Корреспондент баримтлал /correspond - тохирох, дүйх гэсэн утгатай үг/

Бидний мэдлэг бодит байдалтайгаа тохирохыг үнэн гэнэ. Бодомж (өгүүлбэр, хэллэг) нь оршихуйн баримттай тохирч дүйж байгаа тэр тохиолдолд л үнэн байна

Платон

"Юмсын тухай түүнтэй адилаар ярьж буй хүн бол үнэнийг хэлж буй хэрэг, харин өөрөөр ярьж байгаа хуун бол худал хэлж байна"

Аристотель

"Юм оршдоггүй буюу юм биш оршдог нь худал, харин юм оршдог, юм биш эс оршдог нь үнэн мөн".

Корреспондент онолын асуудлууд

- ▲ Сэтгэхүй бодит байдалтай тохирох тухай асуудал
- ▲ Бодит байдлын тухай ойлголт
- ▲ Үнэн мэдлэгийн илэрхийлэгдэх хэлбэрийн тухай асуудал

Когерент баримтлал /coherence - харилцан холбоо, уялдаа гэсэн үг/

Когерент онол нь сонгодог онолын мэдлэг бодит байдалд тохирох гэдэг ойлголтын оронд мэдлэгийн когерент чанар гэсэн ойлголтыг тавьж, үнэний шалгуур бол мэдлэгийн когерент чанар мөн гэж үздэг.

Брэдли

"Үнэн - бол санаалаг зүйл болгосон бодит байдал бөгөөд бодит байдал бол оюун ухаанаар танигдан мэдэгдсэн систем мөн гэдгийг харуулах ёстой. Иймд аливаа бодомж, оюун дүгнэлтийг энэхүү бодит байдал руу ханддаг гэж ойлгох хэрэгтэй"

Блэншард

"Дотоод харилцан холбоо бол бидний үзэл бодол асуудалтай болох тэр үед эцсийн, жинхэнэ, үл өөрчлөгдөх шалгуур болдог"

О.Нейрат

"Шинжлэх ухааны гарааны цэг болох цэвэр протоколь өгүүлбэрийг шууд байгуулах ямар ч арга байхгүй. ... Хуурай эргийн засварын газар онгоцоо аваачиж засуулах ямар ч боломжгүй задгай далайд онгоцоо сэргээн засварлах ёстой далайчдад бид хайртай билээ"

Оршин буй бүх зүйл болон бүх бодит категориуд нь дотоод харилцан холбоотой. Категориудын дотоод харилцан холбоо нь үнэний шалгуур болон үнэний мөн чанарыг тодорхойлдог. Бодит байдал бол түүний хэсэг бүр нь бусадтайгаа холбоо бүхий когерент систем байдаг. Үнэний шалгуур бол мэдлэгийн дотоод холбоо, зохицол мөн.

Үнэний когерент онолд үнэний шалгуур болгож буй мэдлэгийн "дотоод зөрчилгүй систем" байх гэдэг нь сэтгэхүй зөрчилгүй, дэс дараалалтай байх ёстой гэдэг логикийн алтан дүрмийн шаардлагатай нийцдэг.

Прагматик баримтлал

"Бидний эзэмшиж, үндэслэж, бэхжүүлж, баталж чадах тэр бүх санааг үнэн гэнэ. Харин ингэж болохгүй байгаа бүх санаанууд бол худал мөн" "Бидний туршлагын бусад хэсгүүдтэй боломжийн харилцаатай байгаа болохыг тогтооход тус болдог сэтгэхүй л (бидний туршлагын нэг л хэсэг болох) үнэн болно" У.Джемс

Прагматистуудын хувьд үзэл бодлын үнэн болох нь биднийг туршлагын хүрээнд ямар нэгэн саадгүйгээр чиглүүлж өгдөгт орших бөгөөд үнэн бол туршлагаас туршлагад дэвшин шилжихэд удирдлага, чиглүүр болдог.



Ашигтай байх нь мэдлэг бодит байдалтайгаа тохирсны шалгуур биш, харин ашигтай шинжийг агуулсан мэдээг нь бодит байдалтай тохирч байх ёстой ажээ. Гадаад ертөнцийн бодит шинж бол хүнд төдийлөн хамаатай зүйл биш, хүн зөвхөн өөрийнхөө үйл ажиллагаатай шууд харьцдаг тул бидний олж тогтоож чадах зүйл бол "мэдлэг бодит байдалд тохирох"-ыг биш, харин практик үр ашигтай байх явдал мөн.

Үнэний эцсийн шалгуур гэдэг нь тухайн баталгааны үйлийн талд ашигтай үр өгөөжтэй байх явдал юм. Итгэл үнэмшил, мэддэг нь бидний практик үйл ажиллагаанаас хамааралгүй байж чаддаггүй. Итгэл үнэмшил нь бидний үйлдэлд нөлөөлж, тавьсан зорилгодоо хүрэх арга хэрэгслийг зааж чиглүүлдэг. Хэрвээ энэхүү нөлөөлөл нь бидний зорилгодоо хүрэхэд үр ашигтайгаар нөлөөлж чадвал бидний итгэл үнэмшил нь үнэн болно.

Үнэний шалгуурын асуудал

Үнэний шалгуурын асуудал нь танин мэдэх үйл ажиллагаа ялангуяа шинжлэх ухааны танин мэдэхүйд онцгой чухал үүрэгтэй. Шинжлэх ухааны үнэн нь зарчмын хуьд шалгагдах бололцоотой байх ёстой. Иймээс эпистемологийн ном зохиолуудад үнэний шалгуурын асуудлыг голчлон шинжлэх ухааны танин мэдэхүйтэй холбоотой ярьдаг.

Математикт удаан хугацааны туршид үнэнийг тогтоох гол арга нь баталгаа (нотолгоо) мөн гэж үзэж байлаа. Гэтэл манай зууны 30-аад оны үед австрийн математикч Гёдель нотлогдсон математик баталгаануудын олонлог нь үнэн баталгааны олонлогтой тэнцүү биш болохыг тогтоожээ. Өөрөөр хэлбэл үнэн байх, нотлогдох хоёр нь ялгаатай болохыг тогтоожээ. Жишээ нь: формаль арифметикт үнэн боловч аксиомын мөрдлөгөө байдлаар гаргаж нотолж болдоггүй тийм баталгаануудыг бүтээж болдог байна. Энэ нөхцөл байдал нь үнэн ба нотолгооны харилцааны философийн асуудлыг төрүүлжээ.

А.Тарский

"Энэхүү баримтын философийн үр дагавар нь сөрөг боловч түүний ач холбогдлыг бууруулахгүй юм. Математик дахь нотолгооны тухай ойлголт нь үнэний тухай ойлголтыг бүрэн орлож чадахгүй гэдгийг харууллаа. Ингэхлээр бүх математик баталгаануудын үнэнийг тогтоох хэрэгсэл бол формаль нотолгоо мөн гэдэгт итгэх нь үндэслэлгүй боллоо".

Байгалийн шинжлэлд тухайлбал физикт бодомжийн үнэнийг тогтоох гол хэрэгсэл бол туршилт байдаг. Физикийн онолын үнэнийг тухайн онолын хүрээнээс гарахгүйгээр тогтоож болохгүй гэдэг нь өнөөдөр нэгэнт тодорхой болсон билээ. Онол гэдэг нь логикийн хувьд зөрчилгүй байгууламжуудын бүхэл эгнээ бөгөөд эдгээр байгууламж нь физик ертөнцийн бүтцийн тухай таамаглал юм. Энэ таамаглалуудаас аль нь бодит байдалтай тохирч буйг мэдэхийн тулд туршлагад хандах болдог. Энэ нь физик дэх онол ба туршлагын харилцааны философийн асуудалын гол зүйл юм. Онолыг туршлагын өгөгдхүүнд оруулж шалгах тодорхой логик хэлбэр байх ёстой. Энэхүү логик хэл бэрийн тухай асуудал нь шинжлэх ухаан болон фил ософийн салбарт томхон маргааны сэдэв болж иржээ.

Шинжлэх ухааны мэдлэгийг туршлагын өгөгдхүүнтэй холбох логик хэлбэр нь индукци гэж Ф.Бэкон үзсэн. Индукци бол Бэконыхоор сэрэл болон төсөөллөөс үүсэн нэгтгэн дүгнэлтийн гинжин холбоо болж, эцэстээ хамгийн ерөнхий зарчимд хүргэдэг шинжлэх ухааны мэдлэгийг төлөвшүүлэх арга мөн.

Эмпирик шалгуур: верификаци, фальсификаци

Верификаци

Шинжлэх ухааны хэллэгийн үнэн эсэхийг эмпирик туршилагаар нотолж тогтооно.

К.Поппер

"Нотолгооны баримт ямар олон байлаа ч эндээс онолыг үнэн гэж хэлж болохгүй. Туршлагын замаар онолын үнэн эсэхийг нотлох нь индукцийн аргыг зөв хэлгээн гарцаагүй тогтоосон үед л боломжтой. Онолыг эмпирик баримтаар нотолдог юм бол эмпирик туршилагаар нотлогдохгүй байгаа онол худал байх ёстой. Гэтэл онолыг шалгадаг эмпирик баримт нь өөрөө хэд хэдэн онолд хамаарагддаг учир тэдгээрийн үнэн эсэх нь түүнийг тайлбарлаж байгаа онолоос хамаардаг"

Фальсификаци

*Шинжлэх ухааны онол, таамаглалын худал болохыг сонгодог логикийн *modus Miens* /үгүйсгэх модус/-ын дүрмээр няцааж тогтоох арга.*

А.Эйнштейн

"Эмпирик баримт ямар их хэмжээгээр хуримтлагдлаа ч таталцлын онолын математик тэгшитгэл ишг тийм нарийн нийлмэл тэгшитгэлийг төрүүлдэггүй. Туршилага дээр онолыг шалгаж болно, харин туршилагаас онолыг гаргах зам байхгүй"



Эмпирик биш шалгуур

М.Бунге

Онол эмпирик баримттай тохирох нь онолын үнэнийг шалгах зайлшгүй бөгөөд хүрэлцээтэй нөхцөл биш юм, учир нь:

1. тогтоогдсон онолтой зөрчилдөж буй баримтуудыг физикийн практикт ихэвчлэн хэрэгсдэггүй,
 2. баримт нь зөвхөн тухайн өгөгдсөн онолд төдийгүй тохирох бусад онолд хэрэглэгдэж болдог,
 3. ихэнх онол нь юмс хүртэхүйн тухай буюу ажиглалт хэмжилттэй холбоотой биш, харин санаачлагдсан хийсвэр загварт ханддаг,
 4. шалгагдаж буй таамаглал нь зөвхөн нэг л тодорхой онолын мөрдлөгөө биш, харин онолуудын конъюнкци болон нэмэлт таамаглалууд, мөн өөр төрлийн мэдээлэлд хадгалагддаг.
- Ингэхлээр аливаа онолыг бүрэн гүйцэд шалгаж болохгүй.

Бунге тухайн физикийн онолын үнэнийг шалгахад эмпирик биш шалгуур зайлшгүй гээд онолын эмпирик биш шалгуур нь мета-онолын, интер-онолын, философийн гэсэн төрлүүдтэй гэжээ.

Эмпирик биш шалгуур

Мета-онолын шалгуур

Онол дотооддоо зөрчилгүй байх, баримтын хоёрдмол утга холбогдолгүй байх, үл ажиглагдам шалтгаант зүйлсийг ажиглагдагч шинжүүдтэй холбогч нэмэлт таамаглал, конструкцын тусламжтайгаар эмпирик шалгуурт орж буй эсэх зэрэг юм.

Интер-онолын шалгуур

Тухайн онол хүлээн зөвшөөрөгдсөн бусад онолтой зохицолтой эсэхийг харуулдаг.

Философийн шалгуур

Онолын түлхүүр ойлголт, таамаглалуудын метафизик ба эпистемологийн чансааны судалгаа.

3. Мэдлэгийн эх сурвалжийн тухай баримтлалууд

Би өөрийн оршин буйгаа мэднэ.

Эзэн-Бурхан оршин байдаг гэдгийг би мэднэ.

Хун бол цагаан гэдгийг би мэднэ.

Аливаа үйл явдал шалтгаантай гэдгийг би мэднэ.

Маргааш нартай сайхан өдөр болно гэдгийг би мэднэ.

Чиний шаналж байгааг би мэднэ.

1206 онд Их Монгол улс байгуулагдсаныг би мэднэ.

Эдгээр бодомжийг би хэрхэн мэдсэн бэ?

Хариулт:

Рационалист

Оюун ухаан болон интеллектийн үүргийг онцолдог байр суурийг рационализм, ийм байр суурийг баримталдаг хүмүүс

Рационализм нь бодит байдлын тухай мэдлэгийг (ядаж заримыг нь) бид мэдрэхүйн туршлагаас үл хамаарах оюун ухаанаар дамжуулан олж авдаг гэж үздэг үзэл мөн. Зарим рационалистууд мэдлэг олж авахад мэдрэхүйн туршлага нь үнэхээр ямар ч үүрэг гүйцэтгэдэггүй гэж үздэг. Гэтэл зарим рационалистууд оюун ухаан бол бодит байдлын тухай бидний мэдлэгийн ядаж заримынх нь эх сурвалж мөн гэж үздэг.

Эмпирицист

Туршлагын үүргийг онцолдог үзлийг эмпирицизм (empiricism), ийм байр суурийг баримталдаг хүмүүс

Эмпирицизм нь мэдлэгийн эх сурвалж бол туршлага мөн гэж үздэг. /Энд бид зөвхөн мэдрэхүйн туршлагын тухай л ярьж байгаа гэдгийг онцлох хэрэгтэй/

Мэдрэхүйн туршлага (perception) бол: харах, сонсох, хүрэлцэх, амтлах, үнэрлэх мэдрэхүйгээс тогтдог. Эмпирицизм нь рационализмын адилаар олон янз байдалтай боловч ерөнхийд нь эмпирицизм бол бодит байдлын тухай бидний бүх мэдлэг бол мэдрэхүйн туршлагаас гаралтай гэж үздэг тийм үзэл мөн.

**Tabula rasa -
blank tablet**

Хүний оюун ухаан нь төрөлх байдлаараа бичиггүй цаастай адил, аливаа санаа болон оюун ухааны бүтэц нь энэ цаасан дээр бичсэн бичиг мөн, энэ бичиг нь 5 мэдрэхүйгээр хийгддэг.

Cogito ergo sum

*Би сэтгэж, эргэлзэж буй учраас
оршин байна. Р.Декарт*



Эпистемологид Кантын хийсэн "Коперникч" эргэлт

Априори ба апостериори (a priori, a posteriori) мэдлэгийн ялгаа

Априори мэдлэг

Мэдрэхүйн туршлагаас өмнөх зүйл буюу түүнээс үл хамаарах мэдлэг мөн.

Апостериори мэдлэг

Мэдрэхүйн туршлагын дараа, түүнээс хамааралтайгаар бий болдог мэдлэг юм.

Аналитик ба синтетик мэдлэгийн ялгаа

Аналитик мэдлэг гэдэг нь мэдлэг илэрч буй бодомжийн предикат нь түүний субъект дотроос олддог мэдлэг мөн. $S \supset P$ хэлбэр бүхий бодомж юм.

Жишээ нь: хэмжээстэй" "Аливаа бие нь хэмжээстэй" гэсэн энэ бодомжийн предикат болох хэмжээс гэдэг ойлголт нь субъект болох "бие" хэмээх ойлголтоос л гарч байгаа, түүнтэй харьцуулахад ямар ч шинэ зүйл биш юм, энд предикатын шинж нь субъектээс өөрөөс нь логик ёсоор урган гарч буй юм.

Синтетик мэдлэг гэдэг нь түүний предикат нь субъектдээ ямар нэгэн зүйлийг нэмж байдаг, өөрөөр хэлбэл предикат нь субъект дотроос олддоггүй бодомж мөн. $S \not\subset P$ гэсэн хэлбэр бүхий бодомж юм.

Жишээлбэл: "Ус бол Fahrenheit-ийн 32 хэмд хөлддөг" гэх буюу "А бол В мөн" гэсэн хэлбэр бүхий В предикат нь А субъектийг өргөжүүлж буй бодомжууд нь синтетик мэдлэг юм. Эсвэл "Зарим биет нь хүндтэй байдаг" гэсэн эл бодомжийн субъект болох биетийн тухай ойлголт нь предикат болох хүндийн тухай ойлголтыг өөртөө заавал агуулах албагүй юм.

Кант синтетик мэдлэгийг 2 хуваажээ. Үүнд:

1. **Субъект, предикатын холбоо нь туршлагаар илэрдэг бодомж.** Жишээ нь: "Зарим хун бол хар өнгөтэй". Ийм синтетик бодомжийг Кант апостериори бодомж гэж нэрлэсэн.
2. **Субъект, предикатын холбоо нь туршлагад илэрч үндэслэдэггүй, тэр холбоо нь туршлагаас өмнөх, туршлагаас үл хамаарах шинжтэй байдаг тийм бодомж.** Жишээ нь: "Аливаа үйл явдал нь шалтгаантай байдаг". Ийм хэлбэрийн бодомжийг Кант априори бодомж хэмээн нэрлэжээ.

Априори синтетик бодомж байдаг уу?

"Аливаа үйл явдал бол шалтгаантай" гэсэн энэ бодомж нь синтетик үнэн бөгөөд үүний хамтаар априори, универсаль, зайлшгүй шинжтэй.


VI бүлэг. ШАШНЫ ФИЛОСОФИ

1. Шашны философи асуудлууд

Шашны философи нь шашны үзэгдлийг судлахад чиглэсэн философийн салбар юм. Хэдийгээр шашин нь ид шид, мөргөл залбирал зэргийг багтаасан онол, практикийн нарийн тогтолцоо боловч философичид шашны үнэний баталгааг үнэлэхэд анхаарлаа голлон хандуулдаг билээ.


Жүүд, Христ, Ислам зэрэг шашны гол уламжлалд хамгийн чухал баталгаа нь Эзэн-Бурханы оршин байхуй, мөн чанар, үйл ажиллагааны тухай байдаг. Эдгээр уламжлал Эзэн-Бурханыг биегүй, хүнэрхүү, мөнх, бүрэн чөлөөтэй, бүхнийг чадагч, бүхнийг мэдэгч, орчлон ертөнц, хүнийг бүтээгч, ивээгч, гэсгээгч гэж ойлгоно.

Шашинд сүсэг бишрэл үнэхээр тэргүүлэх байр эзэлдэг бөгөөд "босч зогсчихоод Эзэн-Бурханы оршихуйг батлах нь сөхөрч суугаад түүнд талархахаас тэс өөр зүйл"



гэсэн үг ч бий. Энэ нь шашны хүрээнд оюун ухаан, сүсэг бишрэл хоёрын ялгаатай байр суурийг илтгэж өгнө.

Жирийн теологи (Theos- грекийн Эзэн-Бурхан гэсэн үг) нь жирийн ухаанаар Эзэн-Бурханыг судлана. Иймээс тэрээр Эзэн-Бурханыг ариун сүнс, ариун судар гэх мэт онцгой илчлэлээр танин мэддэг илчлэлт теологиос ялгаатай. Жирийн теологийн хүрээнд хүмүүс өөрсдийн жирийн чадвараар Эзэн-Бурханд хүрэхийг оролддог бол илчлэлт теологид Эзэн-Бурхан өөрийн онцгой аргаар хүмүүст хүрч очдог.



Жирийн теологийн түүх Эзэн-Бурханы оршихуйн олон янзын үндэслэлийг бий болгосон. Эдгээрээс онтологийн, космологийн, телеологийн, ёс суртахууны үндэслэл гол юм.



Жирийн теологи

Апостериори үндэслэгээ:

Космологийн,
Телеологийн

Априори үндэслэгээ:

Онтологийн,
Ёс суртахууны

Космологи үндэслэл

- ▲ Ертөнц, орон зай, цаг хугацаа оршин байгаа.
- ▲ Тэд өөрсдийнхөө шалтгаан байж чадахгүй.
- ▲ Тэд оргүйгээс үүсээгүй.
- ▲ Тэд шалтгаацлын төгсгөлгүй хэлхээнд нөлөөлөхгүй.
- ▲ Иймд тэд орон зай цаг хугацаанаас ангид, шалтгаацдаггүй зүйлээр тодорхойлогдох ёстой.

Телеологи үндэслэл

- ▲ Цаг, байшин, завь зэрэг нь загвар шийдэл илтгэдэг бөгөөд ухаалаг нэгэн л үүнийг төлөвлөн бүтээнэ.
- ▲ Орчлон ертөнц загвар шийдэлтэй.
- ▲ Иймд орчлон ертөнцийг ухаалаг нэгэн төлөвлөн бүтээсэн.

Онтологи үндэслэл

- ▲ Эзэн-Бурхан бол хамгийн агуу, хамгийн төгс.
- ▲ Оршин байгаа нь оршин байхгүйгээс илүү агуу, илүү төгс.
- ▲ Иймд Эзэн-Бурхан оршин байх ёстой.

Ёс суртахууны үндэслэл

- ▲ Хэрэв ёс суртахууны абсолют хууль байдаг бол түүний үндэс болсон абсолют оюун ухаан байх ёстой.
- ▲ Ёс суртахууны абсолют хууль байдаг.
- ▲ Иймд түүний үндэс болсон абсолют оюун ухаан байх ёстой

Эзэн-Бурханы тэнгэрлэг шинжүүд

- ▲ Дээд хүч (omnipotent)
- ▲ Дээд мэдлэг (omniscient)
- ▲ Дээд сайн, ариун зүйл (omnibenevolent)
- ▲ Дээд эрх мэдэл (sovereignty)
- ▲ Бүрэн бие даасан байдал (aseity)
- ▲ Дээд оршихуй (transcendent)

Аквины Гэгээнтэн Фома Эзэн-Бурхан байгааг онтологийн үндэслэгээнийх шиг баталж болохгүй гээд Эзэн-Бурхан байгааг батлах аргуудыг дэвшүүлжээ.

Эхний арга: Байгаль дээрх юмс хөдөлгөөнд байдаг гэсэн баримтыг авч үзэх явдал юм. Хөдөлж буй зүйлс өөрсдийгөө хөдөлгөөнд оруулаагүй нь тодорхой. Хөдөлж буй бүхнийг хөдөлж буй өөр нэгэн хөдөлгөсөн, гэхдээ өөр бусдаар хөдөлгөгдөөгүй анхны хөдөлгөгч байж таарна. Анхны хөдөлгөгч байхгүй бол өөр хөдөлгөгч гэж байхгүй, иймд юу ч хөдлөхгүй. Юмс нэгэнт хөдөлж байгаа болохоор анхны хөдөлгөгч байх ёстой энэ бол Эзэн-Бурхан.


Хоёр дахь арга: Байгальд өөрийнхөө шалтгаан болдог нэг ч зүйл үгүй. Юм бүхэн бусдаар шалтгаацдаг юм бол анхны шалтгаан гэж байх учиртай. Анхны шалтгаан байхгүй байсан бол үр дагавар байхгүй байхсан. Тэгэхээр бид анхны шалтгаан Эзэн-Бурханыг хүлээн зөвшөөрөх ёстой.

Гурав дахь арга: Байгаль дээр оршин буй бүхэн зайлшгүй эрхээр байгаа гэдэгт түшиглэдэг. Оршин байх нь зайлшгүй биш бол тэд оршин байх шаардлагагүй байсан. Иймд энэхүү зайлшгүйг эрхшээгч нэгэн буюу Эзэн-Бурхан байх ёстой.

Дөрөв дэх арга: Байгаль дээрх зүйлст зохих хэмжээний сайн, сайхан, үнэн, төгөлдөр шинж байдаг. Иймд эдгээр төгөлдөр шинжийн эх хэмжүүр буюу жинхэнэ, цэвэр сайн, сайхан, үнэн гэх мэт орших ёстой, үүнийг Эзэн-Бурхан гэнэ.


Тав дахь арга: Байгалийн юмс үзэгдэл зорилготой байдаг. Энэ бүхнийг зорилго чиглэлтэй болгосон ухаант нэгэн байх ёстой энэ бол Эзэн-Бурхан юм.

Эзэн-Бурханы оршихуйн талаарх Фомагийн эхний гурван баталгааг өнөө бид космологийн үндэслэгээ гэж нэрлэдэг. Сайн, сайхан зүйл оршин байхыг илтгэдэг дөрөв дэх нотолгоог ёс суртахууны үндэслэгээ гэнэ. Энэ төрлийн хамгийн алдартай үндэслэлийг И.Кант дэвшүүлсэн болтой. Фомагийн тав дахь нотолгоо шиг үндэслэгээг загварын буюу телеологийн үндэслэгээ гэдэг.






Эзэн-Бурхан байгаа гэх теист үзэл, байхгүй гэх атеист үзлээс эхлээд түүний оролцоог хязгаарлах деист үзэл, байгальтай ижилтгэх пантеист үзлээр дамжин Эзэн-Бурханы тухай үзэл сургаал өөрчлөгдсөөр ирсэн. Үүнчлэн шашин ч эртнээс нааш түүхэн байдлаар өөрчлөгдөн хөгжжээ.



2. Монголын буддист философи



Буддын философийн зарим гол ойлголтууд

- ▲ **Махбод** - шороо, ус, гал, хий зэргийн язгуур чанар
- ▲ **Шуньята** - хоосон чанар
- ▲ **Билиг барамид** - хоосон чанарыг ухаарч, дээд мэдлэг буюу билгийн чинадад хүрэх
- ▲ **Нирван** - бие, сэтгэл, оюун ухаанаа төгөлдөржүүлснээр сэтгэлийн бүрэн амарлингуй төлөвд хүрэх
- ▲ **Нисванис** - сэтгэлийн гэм
- ▲ **Сансар** - төрөх, үхэх, дахин төрөхийн гинжин холбоонд орших ертөнц

Монголын буддист лам нараас Агваандандар, Агваанхайдав, Агваанбалдан нарын үзэл санаагаар Буддын философийн асуудлыг төлөөлүүлж авч үзлээ.

Агваандандар¹ -ын гүн ухааны үзэл

Тэрээр "маш нарийн тоос" хэмээх өчүүхэн жижиг нүдэнд үл үзэгдэх, цааш задлан хуваагдашгүй, тоосонцор хэсгүүдийн нийлбэр цогцос болж бодот юмс бүрэлддэг гэсэн материалист дүгнэлт хийжээ.

Агваандандар мэдэрч танин мэдэхүйг бодит үнэнийг нээн харуулах мэдлэгийн хэрэгсэл, анхны шат мөн гэж үзээд, мэдрэхүйн эрхтнүүдийн гүйцэтгэх үүргийг өндөрт тавьж, тэдгээрийн тусган авах бүтээлч чадвар, харилцан холбоог нарийсган харуулахыг оролджээ.

¹ Тэрээр 1759 оны шарагчин туулай жил Алшаа хошоод хошуу зүүн сумын Баяннуруу багийн нутагт их Хойд овогт зайсан гэгчийн гэр бүлд мэндэлжээ. Тэрээр бага наснаасаа Алшаа хошууны яаман сүмд /Буян арвитгагч сүм/ шавилан сууж бурхны шашин, гүн ухааны анхан шатны боловсролыг эзэмшиж, улмаар Төвдийн Лхас хотноо буддын чойрын таван ботид гүнзгийрэн мэргэжснээр "лхарамба хэмээх эрдмийн өндөр зэрэг цолыг хүртсэн ажээ. Дараа нь эх нутагтаа буцаж ирээд бурхны шашин, гүн ухааны ном заах, бичих зэрэг ажлыг хийж, хожим нь хошууныхаа баруун хийдийг байгуулахад оролцож явжээ. Тэрбээр "Дандар лхарамба" гэдэг нэрээр алдаршжээ.



Түүний логик-танин мэдэхүйн сургаалаас товч дурдахад:

Шалтгааны үгүйсгэл гаргалгааны жишээ - "Шөнийн далайд утаа байхгүй, яагаад гэвэл гал байхгүй тул

Түгэхүйн үгүйсгэл гаргалгааны жишээ - "...арын уулын энгэрт агар байхгүй, учир нь мод байхгүй.

Тайлбар: Эл гаргалгаанд гал бол утааны шалтгаан, харин утаа бол галын үр дагавар болон илэрнэ хэмээн үзэж нэгэнт утааны шалтгаан болох гал тэрхүү далайд байхгүй учир галын үр дагавар болох утаа хаанаас байх вэ гэсэн оюуны дүгнэлтийг үгүйсгэл хэлбэрээр гаргасан болно.

Тайлбар: Буддын логикийн дүрэм ёсоор "уулын ард агар мод байгаа, байхгүй алин болохыг мэдэхийн тулд агар нь модны тусгай болдог, эсхүл мод нь агарын ерөнхий гэж үзэн эл санаагаа мод гэдэг ойлголт агар хэмээхдээ түгнэ гэж нотлодог.

Агваанхайдав² -ын гүн ухааны үзэл

Тэрээр "Сэтгэлээр бусдын хэрэгямагтыг үйлдэхийн намтар өлөг, мэдэл, төгөлдөр бус хуран үйлдэгч гурвын хүүрнэлдээнээс гарсан галзуу жүжгийг толилуулагч толь оршвой" хэмээх зохиолдоо: хүнийг бие, сэтгэл, бодгаль гэсэн гурван ойлголтын харилцаанд оруулан шинжилжээ. Тэрээр

- ▲ өлөг-бие, бодит зүйл түүний бие, эрхтний сэрэн мэдрэх чадварыг
- ▲ мэдэл-сэтгэл,
- ▲ төгөлдөр бус хуран үйлдэгч-бодгалийг тус тус тэмдэглэжээ.

² Тэрээр 1759 оны шарагчин туулай жил Алшаа хошоод хошуу зүүн сумын Баяннуруу багийн нутагт их Хойд овогт зайсан гэгчийн гэр бүлд мэндэлжээ. Тэрээр бага наснаасаа Алшаа хошууны яаман сүмд /Буян арвитгагч сүм/ шавилан сууж бурхны шашин, гүн ухааны анхан шатны боловсролыг эзэмшиж, улмаар Төвдийн Лхас хотноо буддын чойрын таван ботид гүнзгийрэн мэргэжснээр "лхарамба" хэмээх эрдмийн өндөр зэрэг цолыг хүртсэн ажээ. Дараа нь эх нутагтаа буцаж ирээд бурхны шашин, гүн ухааны ном заах, бичих зэрэг ажлыг хийж, хожим нь хошууныхаа баруун хийдийг байгуулахад оролцож явжээ. Тэрбээр "Дандар лхарамба" гэдэг нэрээр алдаршжээ.




Тэрээр бие гэдгээ "Өөрийн зүгээс тус хорлол юуг ч үйлдэн үл чадах өөрийн хань нөхөр сэтгэлээс хандвал өмхийрөн ялзарч нохой, шувууны хоол болон одно. Хэдийгээр мунхаг харанхуйд бүхэл мэт үзэгдэвч сайтар ажиглаваас шим нь тоосны төдий ч үгүй зүйл" хэмээн тайлбарлажээ.

Агваанхайдав сэтгэл гэдгээ оюун хэмээх ойлголттой холбон авч үзжээ. Оюун гэдгийг бие, сэтгэл, бодгаль гурвыг дагнан барьж байдаг оюуны мэдрэмж хүнд байдаг зүйл болгосон ажээ. Тэгвэл хүнд орон гарч байдаг хийсвэр тогтворгүй байдал бүхий сэтгэл хэмээх нь биед шүтсэн зовлонг үүсгэгч ба ер өвчний зовлонгоос их, зуу мянган хувь илүү эдэлдэг тул биеэс холдуулах хэрэгтэй. Ингэхийн тулд дан ганц сэтгэлээ баримтлан хатуужин дияан хийж өөрийгөө боловсруулснаар амгалан тайван буюу нирваан байдалд хүрнэ гэж үзсэн юм.

Агваанбалдан³ -гийн гүн ухааны үзэл.

Хүний мэдрэхүйн эрхтэнд тусан буух мэдэгдэхүүнийг Вишай /орон/ гэнэ.



¹ Тэрээр 1797 оны намар Халхын Цэцэн хан аймгийн Хардал жанжин бэйсийн хошуу, одоогийн Хэнтий аймгийн Галшар сумын нутагт малчин ард Заны хүү болон төржээ. Агваанбалдан тэр үеийн Монгол орны буддын уламжлалт сургалт ёсоор 6 настайгаасаа бичиг заалган, буддын боловсролыг шат дараалан туулж эзэмшээд, Энэтхэг, Төвдийн буддын гарамгай сэтгэгчдийн бүтээлүүдийг шамдан судлан гүн ухааны сайн боловсролыг олж, Төвд, Хятад, Хөхнуур, Өвөрмонголоор удаа дараа явж, мэдлэгээ байнга гүнзгийрүүлэн баяжуулж байжээ. Тэрбээр 1831 онд Төвдийн Лхас хотноо буддын философийн линсрай гавжийн зэргийг амжилттай хамгаалсан ажээ. 1836 - 1847 онд Их хүрэннээ тэрээр цоржийн өндөр албыг хашиж байв.



- ▲ Төгөлдөр бус хуран үйлдэхүй- Өлөг, мэдэл хоёрын нийлбэр нэгдэл болж бүтсэн буюу эсхүл цаг, зүг гэх мэт биегүй хийсвэр зүйлүүд
- ▲ Өлөг-Хумхийн тоосны бөөгнөрлөөр биелсэн бүхэн
- ▲ Хумхийн тоос нь бүдүүн, нарийн, маш нарийн гэж байна.
- ▲ Хумхийн тоос нь өөртөө дөрвөн махбод буюу шороо, гал, ус, хийн язгуур чанарыг (махбодыг) хадгалсан байдаг.
- ▲ Дөрвөн махбодын чанар бүхий 7 тооны маш нарийн тоосноос 1 нарийн тоос буй болох суурь тавигдаж, тэрхүү нарийн тоос нь 49 болж бөөгнөрөхөд бүдүүн юмсын анхны бие буй болох үндэс тавигддаг.
- ▲ Тав дахь махбод огторгуй махбод хэмээх байна
- ▲ Мэдрэхүйн эрхтнүүдийн тусламжтайгаар гадаад ертөнцийн юмс, үзэгдлийг мэдэрч мэдэхээс эхлэх бөгөөд сэрэхүй нь танин мэдэхүйн эхлэл мөн.
- ▲ Мэдлэгийн бүх бодит үндсийг ил байгаа, далд байгаа гэж хоёр хуваажээ.
- ▲ Танин мэдэхүйн онолдоо хоёр үнэний тухай асуудлыг мөн тавьжээ. Хүрээлэн буй юмс, үзэгдлийг танин мэдэхэд юмын төрөлх мөн чанар, шүтэн барилдахуйн ёсны халхавч бүрхүүл болж байдаг янагуухи үнэн буюу өнгөцхөн үнэн, юмын уг мөн чанар, дотоод бүтэц, харилцаа холбоон илэрхийлж байдаг үнэмлэхүй үнэн буюу гүн үнэн гэж хоёр үнэн байдаг.
- ▲ Мэдлэгийг нэгд, шүтэн барилдахуйн хуультай нийцэж буй эсэхээр, хоёрт, туршин үзэж, жишээлбэл, алт ба төмрийг улайсгах, давтах, огтлох, билүүдэх зэргээр турших лугаа адилаар, гуравт, илт болон шалгадгийн мэдээ баримт, мэдлэг нь уг юмын жам ёстой тохирч буй эсэхээр, дөрөвт, орон оногдохууныг бүрдүүлэгч махбодуудын жам ёсны үүднээс нягтлан үзэх, тухайлбал, галын халуун, усны нойтон зэрэг нь уг юмсыг таньсан жам ёстой тохирч буй эсэхээр тус тус нягтлан шалгана. Энэ дөрвөн зүйлээр нягтлан шалгаж үзээд зөв байвал үнэнийг олов гэж үзэж болно хэмээн бичжээ.


VII бүлэг. ҮНЭЛЭМЖИЙН ОНОЛ

Энэ салбар нь XIX зууны сүүлчээс Аксиологи (Value theory) нэрээр бие даасан судалгааны салбар болон хөгжиж эхэлсэн.

Үндэслэгч нь: Германы философич Рудольф Херман Лотце (1817-1881).

Хөгжүүлэгчид нь: германы философич В. Винделбанд (1848-1915),

Г. Риккерт (1863- 1936) Ф. Brentano (1838- 1917) А. Мейнонг (1853- 1920), К. Эренфельс нар юм.



Жишээ 1.

Үнэлэмжийг объектын шинж гэж үзэхдээ алтыг жишээ болгож авах нь элбэг байдаг. Үүнд, алт бол эдийн засгийн үнэтэй, ховор, физик- химийн хосгүй шинжтэй (маш нягт, хурц өнгөтэй) зэрэг шинжийг агуулдагийн хувьд эрхэм гэж үздэг. Гэтэл алт нь зөвхөн нийгмийн тодорхой нөхцөл байдалд, бас тодорхой хүмүүсийн (бүх нийтийн биш) хүрээнд эрхэмлэгддэгийг тэр бүр анзаардаггүй талтай. Нөгөө талаас алтыг үнэлэмж болгож байсан хүн түүнийгээ үнэлэмж биш болгож ч чаддаг. Үүнд л хамаг учир нь байгаа юм. Объектын шинж чанар өөрчлөгдөөгүй байхад түүний үнэлэмж нь өөрчлөгдөж байна. Тэгвэл үнэлэмж нь объектийн шинж мөн гэж үзэх боломжгүй байна.

Жишээ 2.

Хамгийн дээд үнэлэмж бүхий буюу бидний энгийн ярианы хэлээр хамгийн их үнэт зүйл маань объектын, эд юмны талаасаа хамгийн үнэ цэнэгүй зүйлээр хийгдэж бүтсэн байдаг. Жишээ нь онгон шүтээн байна. Зарим хүмүүст онгон шүтээн бол ариун нандин зүйл, эрхэм дээд үнэлэмж юм. Гэтэл энэ маань жирийн нэг, ямар ч үнэ цэнэгүй чулуу, шавар, шаазангаар хийгдсэн байдаг.



Буддын шашинтны шүтлэгийн онгон буюу бидний бурхан гэж нэрлэж дээш нь залж, мөргөн биширч байдаг баримал дүрсүүдийг хамгийн хямд чулуу шавраас эхлээд мөнгө, алтаар хүртэл хийсэн байдаг. Гэтэл бишрэлийн үнэлэмжийн үүднээс алтан бурхнаа илүү шүтээд шавар юмуу чулуугаар ур муутай хийсэн бурхнаа түүнээс муу бурхан гэдэггүй шүү дээ. Энэ тохиолдолд алт, шавар хоёрын үнэ цэнэ өөр боловч үнэлэмж нь адил байна. Алтыг хоолоор сольж байсан түүхийг хаанаас ч олж болох бол онгон, бурхан шүтээнээ, өөрийн хэзээ ч үл зөрчих ёс суртахууны зарчмаа өлссөнөөс болоод хоолоор сольж байсан баримтыг нийтлэг гэж батлах нь хэцүү юм.

Өлсгөлөн болон гамшиг аюул тохиолдсон нөхцөлд алт ямар ч үнэлэмжгүй төдийгүй үнэ цэнэгүй, хэрэгцээгүй зүйл болон хувирч байхад жинхэнэ үнэлэмжүүд, тухайлбал ёс суртахууны, гоо сайхны болон шашин шүтлэгийн үнэлэмжүүд тогтвортой байсаар хүмүүс тэднийг амь насаа алдахдаа ч эрхэмлэсээр иржээ.

"Субъектив" хандлагын үүднээс үнэлэмж бол субъектэд хамаарах үзэгдэл бөгөөд иймээс үнэлэмжийг "хүслийн проекц", "үзэл бодол", итгэл үнэмшил", "хүсэл", "таашаал" гэх мэтээр тодорхойлдог. Үнэн хэрэгтээ итгэл үнэмшил, үзэл

Үнэлэмж субъектын шинжтэй юу?

бодол зэрэг нь үнэлэмжийн адил биеэ даасан оюун санааны үзэгдэл юм. Тухайлбал, үзэл бодол бол тухайн үзэгдэл, үйл явдлын талаархи дүгнэлтийн

чанартай үндэслэл, томъёолол байдаг. Тэр нь гол төлөв онолын төвшинд илэрдэг. Итгэл үнэмшлийн хувьд ч мөн адил, тэр нь ихэвчлэн Онолын төвшний үр дүн болж байдаг. Итгэл үнэмшил, үзэл бодол зэрэг нь олон тохиолдолд тодорхой үнэлэмжтэй холбоогүй, шинжлэх ухааны мэдлэгт суурилсан байдаг. Гэхдээ энэ нь таашаал өгч байгаа зарим юм үнэлэмжтэй болж болдгийг үгүйсгэж байгаа хэрэг биш. Таашаал нь хүний оюун санааны үзэгдэлд хамаарахаасаа илүү физиологийн шинжид илүү ойр үзэгдэл юм. Үнэлэмжийг оновчтой тодорхойлж чадахгүй байгаагийн бас нэг шалтгаан нь түүнийг өөр бусад түүнтэй адил төстэй болон төсгүй боловч түүнтэй нягт холбоотой оюун санааны үзэгдлүүдтэй болон объекттой нь андуурах, хольж хутгах төөрөгдөл нийтлэг байдаг явдал юм. Тиймээс түүнийг нэгд үнэлэмж бишээс, хоёрт объектоос нь ялгах хэрэгтэй.

Үнэлэмж бол "хүсэл", "таашаал" гэж үзэх нь субъектив иррационализмд хүргэдэг. Хүний хүссэн бүхэн үнэлэмж болдоггүй. Хүсэл гэдэг ойлголт нь хэт субъектив, тодорхойгүй ойлголт бөгөөд олон ааш (каприз), сэтгэл хөдлөлийн олон үзэгдлийг өөртөө агуулдаг. Үүний зэрэгцээ хүсдэггүй үнэлэмж байдаг. Муу, муухай, нүгэл зэрэг нь хүсэгддэггүй боловч үнэлэмж мөн.

Жишээ 3.

Хоол нь хүний биологийн хэрэгцээг хангаж байгаа талаасаа үнэлэмж болохгүй, жирийн л хэрэгцээт, ашигт чанар юм. Харин түүнд субъект ямар нэг нэмэлт утга өгсөн байвал үнэлэмж болно. Жишээлбэл дал, дөрвөн өндрийг хүндэт зочинд барих ёстой, богино хавирга, богт чөмгийг хүндэтгэлийн зоогт тавьж болохгүй гэсэн утга агуулж байгаа үед эдгээр мах нь үнэлэмжийн объект болно. Иймэрхүү ялгааг И. Кант олж хараад эдийн засгийн үнэт зүйлсийг үнэлэмжид хамааруулахгүйгээр үнэлэмжийг зөвхөн ёс цадигийн хүрээнд авч үзэх ёстой, эдийн засгийн үзэгдлүүд нь зөвхөн "үнэтэй", "зах зээлийн үнэтэй" байдаг, харин тэдгээр нь дотоод үнэлэмжтэй байдаггүй гэж үзэж байсан ажээ.


Бодит байдалд үнэлэмж, ашигт чанар хоёр нь хоорондоо нилээд төсөөтэй боловч ялгаатай юм

Жишээ 4.

Маш сайхан уран зураг бол эд юмны талаас нь авч үзвэл хямд будаг, цаас эсвэл зотонгийн хэсэг юм. Түүнийг сайхан гэж үзээгүй хүнд энэ зураг эдийн засгийн ямар ч үнэгүй төдийгүй хэрэгцээгүй зүйл болно. Гэтэл түүнийг ойлгодог хүнд уг зураг нь эдийн маш өндөр үнэтэй байх билээ. Эндээс үнийн шалтгаан нь юм, үзэгдэл биш үнэлэмж болж байгааг харлаа.

Үнэтэй зүйл үнэлэмжтэй байх уу? Үнэлэмжтэй зүйл үнэтэй байх уу?


Үнэлэмжийн бүтэц:






Үнэлэмжийн ангилал

1. Нийгмийн шинжлэх ухааны салбарт өргөн дэлгэрсэн нэг ангилал бол



2. Тухайн тодорхой субъект хуулийн юм уу, ёс суртахууны үүднээс сайшааж эсвэл буруушааж байгаагийнх нь үүднээс:



3. Үнэлэмжүүдийг юунд чиглэж байгаагийнх нь үүднээс өөр лүүгээ, гэр бүлдээ, бусад хүнд, бүлэг хүнд, төрд, хүн төрөлхтөнд, байгалийн аль нэг үзэгдэлд, Эзэн-Бурханд гэх мэтээр үнэлэмжийг хандуулах олон тохиолдол үүсэж болдог.

VIII бүлэг. УРЛАГИЙН ФИЛОСОФИ

Гоо зүй нь сайхны тухай сургаал буюу гоо сайхан ба түүний хэм хэмжээ, төрөл, хэлбэрүүдийг авч үздэг философийн бие даасан нэг салбар мөн.

Урлаг нь нэн түрүүнд ёс суртахуун, философи, шашинтай салшгүй холбоотой хөгжиж ирсэн.

Урлаг ба ёс суртахуун

Ёс зүйн үүднээс негатив (эсрэг) шинжтэй гэж үнэлэгдэх боловч урлагт томоохон байр суурь эзэлдэг догдлолт мэдрэмжүүд нь ахуйн олон өнгө төрхийг нээхийн сацуу хүний нийгэмших үйл явцад багагүй нөлөө үзүүлдэг. Өөрөөр хэлбэл өдөр тутмын эгэл амьдралд нэрвэгдсэн хүний ахуйн чухал талуудыг (тэдгээр нь зөвхөн сайн буюу зөв байх албагүй) урлаг илэрхийлж өгдөг юм.

Урлаг бол хүний сэтгэлийн догдлолт талуудыг илүү их сонирхон судалж байдгийн учрыг ухаарах явдал юм. **Жишээ нь: Яагаад Макбет, Кармен, Мефистофель Хоролмаа** зэрэг зөрчил ихтэй дүрүүд уран сайхны бүтээлд чухал ач холбогдолтой байдаг вэ? Эдгээр дүрийн сэтгэл татах хүч юунд оршдог вэ?

Урлаг ба шашин

Ялгаатай тал

Шашин, сүсэг бишрэл нь гоо сайхны догдлон мэдрэхүйтэй харьцуулбал шашны дэг жаяг, дүрэм журамд их захирагдсан байдаг юм.

Төсөөтэй тал

Урлаг, шашин хоёр ертөнцийн төгс бус, муу туухай бүхнийг даван туулахад, мөн амьдралын бэрхшээл ихтэй, хэцүү, дарамттай нөхцөлүүдээс гарахад хүмүүст дэм тус болж чаддаг ажээ.

Вольфганг Гёте

Урлаг өөрийнхөө төсөөллүүдийн бодитой оршихуйг батлахыг шаарддаггүйгээрээ шашнаас ялгаатай юм.

Урлаг ба философи

Философи нь орчин үед хүнийг түүний сэтгэл хөдлөлийн, оюун санааны ба үл ухамсарлахуйн илрэлүүдийн нэгдэлд, цогц байдлаар судлахыг эрмэлзэж эхэлсэн билээ. Философийн энэхүү чиг хандлагын содон төлөөлөгчид бол Х.Ортега-и-Гассет, Ж.-П.Сартр, А.Камю, У.Эко нар юм.



Ялгаатай тал

Философи чиглэлүүдийн зарим нь үнэн рүү, зарим нь утга илэрхийлэх рүү тэмүүлдэг байхад урлагийн бүтээл нь үнэнийг ба утгыг өөртөө анхнаасаа агуулдаг гэж зарим судлаач бичдэг.

Төсөөтэй тал

Урлаг, философи хоёр нь ахуйн туйлын мөн чанарыг ойлгож ухамсарлахыг эрмэлздэгээрээ нэг нийтлэг зорилготой гэж үзэж болно.

Урлагийн бүтээлүүд утга - агуулгатай байдаг уу?

Урлагийн бүтээл ба түүнд дүрслэгдэж буй зүйл хоёрын хооронд их ялгаа байдаг. Бодит байдал дээр байгаа зүйл, уран бүтээл хоёрыг хольж хутгаж болохгүй. Урлагийн бүтээлийн агуулгын тухайд бие биенээ үгүйсгэсэн, зөв буруугийн элемент агуулсан эсрэг тэсрэг үзлүүд их байдаг.

Урлагийн бүтээлд ил байгаа зүйл түүний агуулга биш юм.

Жишээ 1. Бид "Моби Дик"-ийг зүгээр л нэг халимны тухай тууж гэж боддоггүй. Мелвиллийн энэ туужид илүү гүнзгий утга агуулга байгаа хэмээн түүний талаар эрэлхийлж байдаг. Моби Дик-чөтгөр, Моби Дик-Эзэн-Бурхан гэх мэтээр илүү гүнзгий утга агуулга хайсаар байдаг.

Жишээ 2. Бид Пикассогийн "Гуирника" зургаас 1930 онд Испанийн нэг жижиг хотыг бөмбөгдсөн тухай биш харин дайны гай гамшигийг мэдэрсэн мэдрэмжийг хүлээн авдаг. Пикассо "Би энэ зурагт юу хэлэх гэснийгээ л хэлсэн" гэх аж. Бид Пикассогийн "Гуирника" зургийн агуулгыг тун товчоор "Дайн бол муу зүйл" гээд тодорхойлчихож болох юм л даа. Гэтэл Пикассо үүнээс хамаагүй өргөн агуулгатай зүйл хэлж байсан бол яахав?

Уран бүтээлчид өөрсдийн бүтээлд ямар нэг тодорхой утга өгч, тайлбарлал хийхээс ямагт зайлсхийсээр ирсэв. Хэрэв уран бүтээлч өөрийнхөө бүтээлд юу хэлэх гэснээ хэлсэн бол түүнийг тайлбарлаад байх шаардлага үгүй байхсан.

Урлагийн бүтээл нь агуулгатай юу, үгүй юу гэдэг талаар сэтгэгчид янз бүрийн үзэл баримталж байжээ.

Нэг хүн Пикассогоос таны зурагт байдаг улаан бухын толгойн дүрслэл нь Европд фашизм өндийн гарч ирсэнийг дүрсэлсэн биз дээ гэж асуухад тэрээр "Үгүй, энд улаан бухын л толгойг зурсан юм" хэмэсэн байдаг.

**Лев Толстой: Урлаг бол сэтгэлийн
хөдөлгөөний илэрхийлэл.**

- ▲ Урлаг бол хүний амьдралын гарцаагүй байх ёстой нөхцлүүдийн нэг мөн.
- ▲ Урлаг нь хүний дотоод, гүнзгий сэтгэлийн илрэл учраас хүмүүсийн хоорондын харилцаа болж байдаг.
- ▲ Ердийн хэл нь хүмүүсийн ердийн оюун санааг дамжуулан илэрхийлдэг бол урлаг нь хүмүүсийн дотоод сэтгэлийн гүнний итгэл, найдвар, мөрөөдөл, мэдрэмж зэргийг илэрхийлдэг.
- ▲ Урлаг бол нэгний оюун санааг нөгөөд дамжуулдаг зүйл мөн.
- ▲ Урлагийн хүч чадал, шалгуур нь "халдварлах чадвар" юм.
- ▲ "Сайн урлаг" гэдэг бол сэтгэл мэдрэмжийг сайн дамжуулагч мөн.
- ▲ Урлагийн агуулга амьдралтай холбоотой байдаг учир юмс үзэгдлийг ухаарахад тусалдаг.

**Сюзан Сонтаг: Урлагийг
тайлбарлахуйн эсрэг**

- ▲ Урлагийн бүтээл бол зөвхөн илэрхийлэл төдий биш.
- ▲ Урлаг бол нууцлаг хэлбэрийг гаргаж байх ёстой.
- ▲ Урлагийн бүтээлийг үгээр тайлбарласнаараа түүний нууцлаг зүйлийг нь үгүй болгон өөртөө тохируулж, цэвэр урлагийн бүтээл биш болгож байгаа хэрэг.
- ▲ Урлагийг тайлбарлахын оронд гоо сайхны мэдрэмж рүү оч, тэр чинь аяндаа юу болохыг хэлээд өгнө.

**А.К.Брадлей: Урлагийн төлөөх
урлаг**

- ▲ Агуулга, хэлбэр хоёрыг оюун ухаандаа л салгаж болдог болохоос бодит байдал дээр бол салгаж үл болно гээд агуулга, хэлбэр хоёрыг нэгтгэсэн онол гаргах оролдлого хийсэн. Аягыг хийсэн агуулга нь энэ, хэлбэр нь энэ гээд тус тусад нь салгаад харуулах боломжгүй. Тодорхой хэлбэртэй болгохын тулд тухайн хэлбэрийг бий болгогч материал хэрэгтэй. Урлагийн бүтээлийг бий болгосон материал гэдэг нь заавал хэлбэржсэн байх ёстой. Тэгэхээр хэлбэр, агуулгын тухай бодох юм уу ярьж болох авч бодит байдал дээр нэг нь нөгөөгүйгээр оршино гэж байхгүй.
- ▲ Бодитой байгаа зүйлийг урлагийн бүтээлийн агуулга гэж үзэж болохгүй.
- ▲ Эцсийн эцэст амьдрал, урлаг хоёр өөр өөр зүйл гэдгийг л харуулсан.



IX бүлэг. ӨНӨӨГИЙН ФИЛОСОФИ ЗАРИМ ЧИГЛЭЛҮҮД

1. Орчин үеийн философийн үндсэн баримтлалууд I (позитиозм, прагматизм, герменевтак)

Орчин үеийн философи гэдэг ойлголтын утга

Орчин үеийн философи гэдэгт сэргэн мандалтаас хойших үеийн философийг, уламжлалт биш философи буюу XIX зууны 20-30-аад оноос хойших философийг, бүр явцуу утгаар XX зууны 70-аад оноос хойших философийг хамруулж ойлгодог. Орчин үеийн философид амьдралын философиос эхлээд позитивизм, түүний хэлбэрүүд, шинэ кантч, гегелч философи, неореализм, марксизм, неомарксизм, прагмативизм, феноменологи, герменевтик, экзистенциализм, фрейдизм, неофрейдизм, структурализм, постструктурализм, постмодернизм гэх мэт олон үзэл сургаал багтана.

Позитивизм

Позитивизмийн түүхэн хэлбэрүүд	Түүхэн цаг хугацаа	Гол төлөөлөгчид	Үндсэн асуудал
Эхэн үеийн позитивизм	XIX зууны II хагас	О.Конт, Ж. С.Милль, Г. Спенсер	Туршлагын мэдлэгийн психологийн ба индуктив логикийн аспектыг голчлон авч үзсэн.
Эмпирио-критицизм	XIX, XX зууны зааг	Э.Мах, Р.Авенариус	Хоёр зууны зааг дээр байгалийн шинжлэлд гарсан хувьсгалт үйл явцын утга учрыг ухамсарлах, тайлбарлахад гол асуудал чиглэгдсэн.
Неопозитивизм	XX зууны 30-60-аад он	Р.Карнап, М.Шлик, Б.Рассел, Ж.Мур, Л. Витгенштейн	Шинжлэх ухааны мэдлэгийн агуулгын үндсэн байдалд анализ хийх нь гол асуудал байлаа.
Постпозитивизм	XX зууны 60-аад оноос хойш	М.Полани, С.Тулмин, Т.Кун, И.Лакатос, К-Поппер, Ж.Агасси, П.Фейерабенд	Шинжлэх ухааны мэдлэгийн түүхэн динамик, танин мэдэхүйн нийгэм-соёлын детерминацийг голчлон авч үзжээ.

Позитивизмыг үндэслэгч гэгддэг О.Контын үзлээр хүн төрөлхтний сэтгэлгээ дараах гурван шатыг дамжин хөгжжээ.



Позитив буюу шинжлэх ухаанч сэтгэлгээний шатанд бид юмсыг байгаагаар нь тэмдэглэн буулгаж, үзэгдлийн зөв зураглалыг тодорхойлон тогтоож, үүний үндсэн дээр баримт хоорондын холбоог нээхийг эрмэлзэх учиртай. Энэ хандлага туршлагыг онцолдог орчин үеийн зарим нэг сургаалд хүчтэй нөлөө үзүүлсэн.

Гэхдээ позитивистуудын үздэгчлэн баримт нь зөвхөн физик уг чанартай биш, басхүү психик шинжтэй болохыг эмпириокритицизм тодруулсан билээ. Иймээс эмпириокритикчдын үзлээр баримт бол саармаг шинжтэй.



Энэ нь мэдлэгт субъектын нөлөө чухал байдгийг сануулж буй юм.

Неопозитивизм шинжлэх ухааны онолын аливаа үндэслэлийг энгийн хэллэгт хөрвүүлж, түүнийгээ бодит байдал дээр нотлон шалгах верификацийн зарчмыг дэвшүүлсэн.

Харин постпозитивизмын зарим төлөөлөгч шинжлэх ухааны онол үүсэхээсээ алдаатай байдаг бөгөөд онолын үндэслэлийг бодит байдал дээр нотлож биш, няцааж шалгах нь үр дүнтэй гэж үздэг. Шинжлэх ухааны мэдлэгийн өсөлтийг загварчлахдаа К.Поппер дараах бүдүүвчийг дэвшүүлсэн.

$$P_1 \rightarrow TT \rightarrow EE \rightarrow P_2$$

Дээрх² бүдүүвч нь шинжлэх ухааны мэдлэг асуудлаар эхлээд асуудлаар төгсдөг болохыг харуулж байна.

Т.Куны үзлээр шинжлэх ухааны мэдлэгийн үнэн эсэх нь асуудлыг шийдэх арга, зарчим, итгэл үнэмшил, үнэлэмжээрээ нэгдсэн өөрөөр хэлбэл нэг парадигмын хүрээнд байгаа эрдэмтдийн нийгэмлэгийнхэнээс ихээхэн хамаардаг бөгөөд шинжлэх ухааны мэдлэг нь

² P1-Problem1, TT-Tentative Theory, EE-Error Elimination, P2-Problem2.



$$P_1 \rightarrow TT \rightarrow EE \rightarrow P_2$$

гэсэн замаар хөгждөг³. Нэг парадигм хязгааргүй ноёрхсон үед шинжлэх ухааны хөгжил хэвийн явагддаг гэсэн түүний үзлийг П.Фейрабэнд шүүмжилсэн юм. Тэрээр тухайн нэг онол хэчнээн нотолгоо бүхий, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн байлаа ч түүнд үл зохицох онолыг боловсруулдаг байх ёстой гэх пролиферацийн зарчмыг дэвшүүлж, шинжлэх ухааны танин мэдэхүйд түгээмэл нэг аргазүйд итгэх биш, харин түүнийг үл дагах эпистемологийн анархизмыг сурталчилан ямар нэг үзэл онол хандлагыг "бүгд зөвшөөрөгдөнө" хэмээн хүлээн авах хэрэгтэй гэж үзжээ.

Прагматизм

XX зуунд Америкт үүссэн прагматизм шинжлэхуааны төдийгүй аливаа мэдлэгийг бидний амьдрал үйл ажиллагаанд үр ашгаа өгч байгаа эсэхээр нь үнэлэхийг санал болгож эхэлсэн юм.

Чарльз Пирс /1839-1914/

прагматизм гэдэг нэр томъёог анх философид оруулсан. Сэтгэхүйн үр дүнг үнэн үү, худлаа юу гэх нь гол биш, харин тавьсан зорилгод нь хэрэгтэй юу, үгүй юу гэдэг үүднээс үнэлэх нь гол гэж тэрээр үзжээ.

Уильям Жеймс /1842-1914/

ойлголт, үзэл санаа, онол зэргийн утгат чанар бол тэдгээрийн практикуур дагвараар тодорхойлогддог гэсэн семиотик дүгнэлтийг хийсэн.

Жон Дьюи /1859-1952/

шинжлэх ухааныг элдэв багажаар дүүрэн хайрцаг хэмээн үзээд, хүн туршлагынхаа явцад ямар багаж хэрэглэхээ сонгодог гэсэн баримтлалыг боловсруулсан. Үүнийг "инструментализм" гэж нэрлэдэг.


Прагматистуудын үзлээр бид ямар нэг багажийн хэлбэр, дүрсийг биш, харин ямар нөхцөлд, яаж хэрэглэдэгт суралцах хэрэгтэй юм. Иймд бидний эзэмшсэн мэдлэг зохих нөхцөлд үр дүнтэй ажиллаад, бидэнд үр ашгаа өгч байвал үнэн байна.

Герменевтик

Байгалийн шинжлэх ухааны төдийгүй нийгэм-хүмүүнлэгийн ухааны мэдлэгийг хэрхэн ойлгож ухаарах талаар шинэ зүйл хийж чадсан өөр нэг философи бол герменевтик философи мөн. Эртний грек хэлний "герменевтик" гэдэг үг "тайлбарлах" гэсэн утгатай. Дундад зууны үеийн Европт уг нэр томъёо христос шашны ариун номлолыг тайлбарладаг урлаг ба аргын нэр болжээ.

Фридрих Шлейермахер /1768-1834/ герменевтикийг ойлгохуйн урлаг ба техник болохын хувьд боловсруулж, текстийг ойлгох олон чухал зарчмыг илрүүлэн тайлбарласан. Тэрээр герменевтик тойрог хэмээх ойлголтыг гарган, текстийг тайлбарлах дивинацийн зарчмыг дэвшүүлсэн юм.

³ P1-Paradigm1, NS-Normal Science, A-Anomalies, C-Crisis, R-Revolution, P2-Paradigm2



Дивинацийн зарчим ёсоор тайлбарлагч нь орон зай, цаг хугацаа, нөхцөл байдлын саадыг даван туулж, өөрийгөө зохиогчийн байр суурин дээр хэр тавьж чадна тэр хэрээр тексийг зөв ойлгоно гэж сургадаг.

Ганс-Георг Гадамер /1900 онд төрсөн/ герменевтикийн зорилт бол ойлгохуйн аргыг боловсруулахад биш, харин ойлгохуйн уг чанарыг болон түүний хэрэгждэг нөхцөлийг тайлбарлах явдал гэж үзжээ. Түүнчлэн тэрээр дивинацийн зарчмын оронд эдүүгээчлэх зарчмыг дэвшүүлсэн билээ.

Текстийг зохиогчоос нь илүү, зөв ойлгох нь чухал биш, харин одоогийн нөхцөл байдлын үүднээс ойлгох нь чухал.

Г.Гадамерийн үзлийн үүднээс ертөнц бол гагцхүү хэлэнд илэрч, хэл нь герменевтик туршлагын орчин болдог. Өөрөөр хэлбэл ертөнцийн тухай хүний туршлага заавал хэлний шинжтэй болно.

Хэл бол ойлгохуйн үйл явц хэрэгждэг универсаль орчин мөн. Ийм үйл явцын хэрэгжилтийн арга нь тайлбарлахуй байдаг... Ойлгохуйн үйл явц бүхэлдээ хэлний үзэгдэл

Герменевтикийн судлах зүйл нь үнэний асуудал биш, харин ойлгохуйн асуудал байдаг билээ.



2. Орчин үеийн философийн үндсэн баримтлалууд II (Амьдралын философи, экзистенциатазм, феноменологи, фрейдизм, постструктурализм)

Амьдралын философи

Гол төлөөлөгчид: Артур Шопенгауэр, Фридрих Ницше, Анри Бергсон, Вильгельм Дильтей, Георг Зиммель, Освальд Шпенглер нар юм.

Үндсэн асуудал "Амьдрал гэж юу вэ?"

А.Шопенгауэр: Дур зорго бол цаггүй, орон зайгүй, энэ нь түүний цор ганц гэдгийг хэлдэг. Миний дур зорго бол үнэхээр цорын ганц ерөнхий дур зорго юм. Дур зорго бол жинхэнэ нүгэл, зайлах аргагүйгээр амьдралыг дагалддаг зовлонгийн хариуцлага. Мөн түүнийхээр мэдлэг бол зовлонгийн эх сурватж мөн. Хүнийг зөвхөн танин мэдэгч хувьд нь биш хүсэл зоригтой амьтан болох талаас нь илүүтэй авч үзсэн бөгөөд түүнийхээр ер нь хамгийн гол зүйл бол амьдрах хүсэл зориг юм.

Ф.Ницше: Эзэрхэх хүсэл зориггүйгээр юу ч урагшлан хөгждөггүй бөгөөд эзэрхэх хүсэл зориг өөрөө хийгээд эзэрхэх хүсэл зоригийг хүнд төрүүлж байгаа бүхэн сайхан, харин сул доройгоос үүдэлтэй бүхэн муухай байдаг гэж үзсэн.

Эрх чөлөөт хүн "Эзэн-Бурхан нас барсан" гэдгийг ухамсарлах ёстой бөгөөд бидний чармайн зорьж байгаа зүйл бол Эзэн-Бурхан биш, харин хүний дээд хэв маяг мөн гэж тэрээр сурталчилдаг.

Экзистенциализм

- ▲ Францын экзистенциалистууд: ЖЛ.Сартр, А.Камю, Г.Марсель, Мерло-Понти
- ▲ Германы экзистенциалистууд: К.Л.Ясперс, М.Хайдеггер
- ▲ Оросын экзистенциалистууд: Н.А.Бердяев, Л.Шестов, Ф.Достоевский

Экзистенциализмын үндсэн асуудал: Хүний ахуйн уг чанарыг илрүүлэх явдал мөн. Рационализм бол ертөнцийг гаднаас нь авч үзэхдээ хүний оршихуйн уг чанарыг ойлгож чаддаггүй, харин бид үүнийг экзистенциаль замаар дотроос нь ойлгох болно гэж тэд үздэг.

Карл Ясперс: Хүнийг салангид ганц бодгаль маягаар ойлгох явдал буруу. Бодгаль хүмүүсийн хамаарал бол тэдний ахуйн урьдчилсан нөхцөл мөн. Бид бие биеэ харилцан ухамсартайгаар ойлгодгийнхоо ачаар бид болцгоодог. Харилцан хамаардаг шинж, нөгөөдөө хамааруулж болох тийм зүйл бол үнэн мөн. Бодгаль хүн хамааралд төдийгүй ирмэгийн нөхдөлд оршдог, тэр нь нэн түрүүнд үхэл, зовлон, тэмцэл, алдаа, айдас мөн. Ирмэгийн нөхцлийн эцсийн хязгаар нь үхэл ажээ.

Мартин Хайдеггер: Би-гийн ахуйг "Daseinw" буюу аэнд-ахуй (бэлэн ахуй)" гэдэг нэр томъёогоор илэрхийлдэг. М.Хайдеггер "экзистенци" гэдэг нэр томъёог С.Кьеркегорын философиос аваад: Dasein бол экзистенцид оршдог гэсэн. Гэхдээ М.Хайдеггерийн хувьд экзистенци дотор байгаль, хүний мөн чанар аль аль нь байдаг.

"Энэ үндэслэлд хүний үйл ажиллагаа ухамсарт шинжтэй, тэр нь угтан харах чадварт үндэслэдэг гэсэн санаа шингэсэн байхын зэрэгцээ эцэс, төгсгөл бол хүний ахуйн үхлийн шийдвэрлэгч тал мөн гэдэг гутранги үзэл ч шингэмэл.

Эзкистенциализмын гол төлөөлөгчид болох Жан Пол Сартр, Албэрт Камю нар хүн өөрийгөө бүтээх боломжтой байхын хамт ганцаардсан, тодорхойгүй байдалд ордогийг, хүн амьдралд бууж өгөхгүй тэмцэхийн утга учрыг үзүүлсэн.

Феноменологи

Үндэслэгч нь: Эдмунд Гуссерль

Э.Гуссерлийн хувьд феномен буюу үзэгдэл гэдэг бол бодитой юм үзэгдэл биш, харин хүний ухамсарт илт тодорхой байдлаар өгөгдсөн санаалаг мөн чанар юм. Хүний ухамсар анхнаасаа өөрийн судлагдахуун болох феномен руу чиглэсэн шинжтэй байдаг. Огт судлагдахуунгүй, хоосон ухамсар байх боломжгүйн адил ухамсартай холбоогүй феномен орших бололцоогүй гэж үзжээ.

Мэдрэхүйн буюу ухамсрын үйлийг Э.Гуссерль нээсис хэмээн нэрлэж, харин тэрхүү нээсисын чиглэсэн судлагдахууныг нозма гэж нэрлэсэн байна. Ийнхүү нээсис, нозма хоёрын нэгдлийг феноменологи философид феномен хэмээх ойлголтоор тэмдэглэдэг. Феноменуудыг дүрслэн тодорхойлохын тулд тэдгээрийн талаар гарсан аливаа тайлбар, интерпретацийг хашилтанд авах буюу феноменологи редукцийн эхний үе шат болох "эпохе" хэмээх үйлийг хэрэгжүүлэх хэрэгтэй гэж Э.Гуссерль үзсэн юм.

Фрейдизм

Үндэслэгч нь: австрийн психологич, сэтгэцийн эмгэг судлаач Зигмунд Фрейд.

Үндсэн асуудал: Ухамсаргүй сэтгэцийн үйл явцуудыг судлах.

Сэтгэцийн гурван үндсэн давхраа байдаг тухай дүгнэлт хийжээ. Ухамсаргүй бол хүний сэтгэцийн идэвхтэй илрэгч, үндэс бөгөөд хамгийн агуулгатай хэсэг мөн. Тэр нь өөрөө хүний ухамсарт хэзээ ч ордоггүй, орлооч түрэгдэн гарах агуулгыг багтаадаг. Ухамсаргүй, түүний агуулга бол невроз өвчин болон бие хүний сэтгэц дэх мөргөлдөөний гол уг сурвалж аж. Учир нь, ухамсаргүйд инстинктийн хоёр үндсэн төрөл багтдаг нь амьдралын инстинкт (эрос), үхлийн инстинкт (танатос) хоёр юм. Энэ хоёр инстинкт бол сэтгэцийн амьдралын суурь, үндсэн, төрөлх мөргөлдөөний үндэс болж, үл эвлэрэх харилцаанд байдаг. Сублимаци бол сэтгэцийн энергийг нэг төлвөөс нөгөө рүү шилжүүлэхүй, жишээ нь бэлгийн дур хүслээ спортын юм



уу урлагийн үйлдлээр солихуй мөн. Ийм үзлийн үүднээс урлагийн бүтээл, шинжлэх ухааны нээлт зэрэг бол сублимацийн тодорхой тодорхой бүтээгдэхүүн мөн.

Швейцарийн психологич Карл Густав Юнг (1875-1961) ухамсаргүйн асуудлаар өөр үзэл илэрхийлж: бие хүний сэтгэцийн доод төвшин төдийгүй дээд төвшин бас ухамсаргүй байж болно гэжээ. Улмаар тэрээр ухамсаргүй бол ухамсрын босгоноос гадагш түрэгдсэн бодгаль,



субъектив зүйл төдийхөнийг биш, харин нэн түрүүнд хамтын, тодорхой эзэнгүй, бүр эртнээс улбаатай сэтгэцдэг агуулгыг өөртөө багтаадаг гэж үзсэн байна. Тэрхүү хамтын ухамсаргүйг тээгч анхдагч дүрүүд байдгийг туршилтуудаараа тогтоогоод, тус бүрийг нь "архетип" хэмээн илэрхийлжээ.

Постструктурализм

Постструктурализм бол XX зууны 70-80-аад онуудад анх Францад, дараа нь Өрнөдийн бусад олон оронд дэлгэрсэн структуралист (бүтэцчилэх) баримтлалуудыг хянан үзэх замаар философи ба хүмүүнлэгийн ухааны салбарт үүссэн онол, арга зүйн баримтлалуудын цогц мөн.

Дэвшүүлсэн гол асуудал: Постструктуралистуудын үзлээр уламжлалт сэтгэлгээний аргаар ертөнц гэдэг "текстийн" утгыг хэзээ ч ухаарч чадахгүй юм. Тийм учир өмнөх үед гарсан номлол, сургаалууд бүгд "хуурмаг түүх" төдий зүйл мөн. Харин бүхнийг яруу найрагчдийнх шиг "яруу сэтгэлгээгээр" сэтгэж, философичдын оюунаар боловсруулсан цагт тэдгээрийн утгад нь нэвтэрч болох юм.

Деконструкци арга: Урлаг, утга зохиолын бүтээлүүдийг судалдаг постструктуралист арга бол уран зохиол дахь өгүүлэгддэггүй болон уншигчид, зохиогчийн аль алины нь анхааралд өртөхгүй үлдчихдэг "үлдэц утгуудыг" олж нээхийг зорьдог.

Структурализм ба постструктурализмын ялгаа

Постмодернизм

Структурализм	Постструктурализм
Судалгааны Судалгааны объектдоо тэмдэглэгдэгч, тэмдэглэгч хоёрын тодорхой харилцаа холбоон дахь статик цэгц байдал, хос хоёр эсрэг зүй тогтол, логик байгууламж зэрэг бүтэцлэг зүйлсийг онцолсон байдаг.	Бүтцийн хүрээний гаднахь түүх ба динамик, янз янзын тохиолдол, учрал, жич жич үйл явдал, эрх чөлөө, захирах захирагдах харилцаа, эрх мэдэл, мөн цухалдал (аффект) зэрэг бүтэцлэг биш зүйлсийг онцолжээ.

Постмодернизм бол постструктурализмын чухал чухал үндэслэлийг шүүмжлэлтэй боловсруулан, улмаар тэдгээрийг шинэ агуулгатай болгосны үр дүн мөн.



Постмодернизмд постструктурализмаас ялгагдах чухал чухал философи зарчим байдаг. Тухайлбал постмодернизм бол секуляризац (сүм хийдийн нөлөөг бууруулах онол, практик) ба дегуманизаци (хүн төвт биш үзэл) бий болох урт удаан үйл явцын бүтээгдэхүүн мөн. Энэ бол биологиос авахуулаад космологи хүртэлх янз бүрийн шинжлэх ухааны хөгжлийн гарцаагүй үр дүн ажээ. Үүнд, ойрын биш ирээдүйд хүн амьдрах аргагүй мөнх хүйтэн юм уу гамшигт халуун бий болох тухай эрдэмтдийн таамаглал нь хүн бол эцсийн эцэст орчлонгийн төв биш, харин байгалийн олон аашны золиос мөн гэсэн дүгнэлтэнд гарцаагүй хүргэж, энэ нь ертөнцийн тухай постмодернист онолын баримтлалууд бий болох чухал уг сурвалж болж байна.

Урлагийн философи онолд холбогдох постмодернизмын хамгийн гол шинжүүд:

- ▲ Хүн төрөлхтний уран сайхны бус үйл ажиллагаанд (тухайлбал улс төр, шашин, мэдээлэл зүй) урлагийн үзүүлэх нөлөөг онцлон тэмдэглэх;
- ▲ бичлэгийн плюрализмыг эрхэмлэх;
- ▲ өмнөх үеүдийн урлагийн бүтээлүүдээс их хэмжээний ишлэл авч өөрийн бүтээлдээ хэрэглэх;
- ▲ өмнөх үеийн соёлын гоо сайхны уламжлалыг егөөдөх;
- ▲ урлагийн бүтээлүүдийг бүтээн туурвихдаа тоглоомын аргыг хэрэглэх зэрэг ажээ.

Өмнөх үеийн урлагт	Постмодернизмын үед
"уран бүтээлч-урлагийн бүтээл,	"урлагийн бүтээл-үзэгч"



3. Хүний философийн орчин үеийн зарим чиглэл

Экзистенциализм

Оршино гэдэг нь хийжоролддог, сонголтой тулгардаг, сонгодог, шийдвэр гаргадаг, биелүүлдэг тодорхой хувь хүн байхыг хэлнэ.

Хүний оршихуйн талаар олон зүйлийг дэлгэн тавьсан **экзистенциализм** нь орчин цагийн хэлбэрээрээ Парист Дэлхийн II Дайны дараахан үүссэн ч түүний үндсэн асуудлууд Данийн **С.Кьеркегорын** бүтээлүүдэд анхлан илэрчээ.

С.Кьеркегорын хувьд **оршихуй** хэмээх нэр томъёо **хувь хүний байхуйг** илэрхийлдэг. Хүн амьдралдаа аливаа зүйлийн өнгөн талд шохоорхох гоозуйн, тодорхой хариуцлагын мэдрэмж рүү хөтлөгдөх ёс зүйн, эцэст нь угга учиргүй **зайлшгүйн эсрэг тэмцэх шашны** гэсэн гурван шатыг туулдаг гэж үзсэн.

М. Хайдеггер хүн төрөлхтний түүх гэж юу болохыг, орчин үеийн түгшүүрт ертөнцөд хүн хэрхэн хандаж, ямар хувь заяа эдлэхийг цоо шинээр ухаарах ёстойг философийн үүднээс тайлбарлах зорилт тавьжээ.

Тэрээр хүний оршихуйг илэрхийлэхийн тулд **Dasein** хэмээх ойлголтыг ашигласан бөгөөд **тэнд эсвэл энд** байх гэсэн утгатай энэ үгээр хүний амьдрал **өнгөрсөн, одоо, ирээдүй** гурван цагийн холбоонд цогцолдог өвөрмөц ахуй болохыг илэрхийлэхийг оролдсон. Үүнийг түүний алдарт бүтээл "Ахуй ба цаг хугацаа"-наас дэлгэрэнгүй үзэж болно.

Ж.П.Сартр: Хүний хувьд оршихуй нь мөн чанараасаа урьтдаг.

- ▲ Хүн оршин байснаар л өөрийн мөн чанарыг олж тогтоодог болохоос хүнд цаанаас заяасан нийтлэг мөн чанар үгүй.
- ▲ Сонголт нь хүний эргэн тойрон үргэлж байдаг бөгөөд сонголт хийх тэр мөчид сонголтыг өөрөө хийх гэдэг утгаараа хүн ямагт ганцаарддаг. Хүн юу сонгосноороо өөрийгөө бий болгодог, үхлээс урьтаж өөрийгөө бүтээх эрх чөлөөгөөр бүрэн хангагдсан.

А.Камю хүний амьдрал утга учиргүйгээс, энэ нь хүний хэрэгцээ шаардлага, ертөнцийн утгагүй анир чимээгүй хоорондын сөргөлдөөнөөс тогтдог гэж үзсэн. Гэхдээ хүн утга учиргүйтэй эвлэрээд суух биш харин түүнтэй тэрсэлж л оршихуйгаа байлдан олж авдаг.

Фрейдизм

З.Фрейд сэтгэц дэх эмгэг гажилтуудыг ажигласан судласанаар хүний ухамсарт ухамсаргүйн хүрээ байдгийг илрүүлсэн. Хүний ухаан нь **ухамсаргүй, нийгмийн ухамсар, ухамсар** гэсэн гурван бүрдэлтэй.

- ▲ Ухамсаргүй бол зөн билиг, хүсэл, сэтгэл догдлол, бэлгийн дур, түрэмгийлэх зөнгийн цогц.
- ▲ Нийгмийн ухамсар бол зан үйлийн дүрэм, эцэг, эхийн хорио, нийгмийн шаардлагаар бүрдэнэ.
- ▲ Ухамсар нь энэ хоёрын дунд байнга тарчилдаг бөгөөд ухамсаргүйг нийгмийн ухамсараар хэт дарвал неврозод ордог.

Харин ухамсаргүйдээ хэт захирагдвал нийгмийн зүгээс эсэргүүцэлтэй тулгарна. Гэхдээ ухамсаргүйн мулгуу хүчийг нийгэмд эерэг болгон гаргах өөрөөр хэлбэл сублимаци хийх бололцоо ямагт байдаг ажээ. Үүнийг бид тэмцээн, уралдаан, урлаг зэрэгт хамгийн ихээр мэдрэх боломжтой.

Түүний шавь К-Юнг хамтын ухамсаргүйн асуудлыг гүнзгийрүүлэн судлажээ.

- ▲ Хамтын ухамсаргүй нь ертөнцийг ойлгож, ухаарахуйн балар эртний аргууд болох архетипийн нийлбэр цогцоос бүрдэнэ.
- ▲ Ухамсар нь хүний зориг хүслийг чиглүүлдэг бол энэхүү архетипүүд хүний зөн билгийг чиглүүлнэ.
- ▲ Архетипүүд бүхэл бүтэн ард түмэн, түүхэн эрин үед нөлөө үзүүлсэн домог, шашин, философийг бүтээсэн. Шашны улбаатай домгууд сэтгэл шаналсан ард түмэнд сэтгэхүйн эмчилгээний төрөл болдог гэж тэрээр танин тайлжээ.

Эхэндээ Фрейдийн нөлөөг авч, түүний үзэл санааг хөгжүүлж, дараа нь Фрейдын психоанализыг нийгэм, хүний тухай, юуны өмнө хүнийсгэлийн тухай марксист сургаалтай нэгтгэхийг эрмэлзсэн хүн бол Эрих Фромм байлаа.

- ▲ Сэтгэл мэдрэлийн өвчин бол хүүхдийн хүсэл, хоосон санаа насанд хүрсэн хүний ухамсрыг дүүргэж байх үеийн нэгэн зүйл эмгэг.
- ▲ Насанд хүрсэн мэдрэлийн өвчтөн бол угтаа хүнийссэн амьтан юм.
- ▲ Хүн экзистенциаль асуудлын өмнө итгэл алдрах, хүчин мөхөсдөх, үхээнц доройгоо мэдрэх байдлаа эвдэн бусниулах, устгах эрмэл злэл ээр хаацайлахыг бас оролддог байна. Гадна байгаа бүхнийг дотоод түгшүүрт байдлынхаа шалтгаан гэж үзээд түүнийгээ сүйтгэх эрмэлзлэлээр нөхөхийг оролдож болно. Тийм сүйтгэлийн эцсийн оногдохуун нь хүн өөрөө юм.



4. Герменевтик, постструктурализм, постмодернизм



Герменевтик философи нь М.Хайдеггерийн зарим санаагаар дамжин постструктурализмтай холбогдсон байдаг. Гэхдээ энэ холбоог постструктурализмаас эргүүлэн хөөж олбол илүү үр дүнтэй байж мэднэ. Постструктурализмын үндсэн үзэл санааг бүрдүүлдэг деконструкци хэмээх ойлголтыг анх францын философич Жак Деррида боловсруулсан юм. М.Хайдеггерийн Destruktion, Abbau

зэрэг ойлголтыг зорилгодоо тохируулж орчуулах оролдлогын үед деконструкцийн тухай санаа орсон гэж Ж.Деррида хэлсэн байдаг.

Деконструкци үүсэх тэр үед "структурализм" ноёлж байсныг бид мэднэ. "Деконструкци" нь чухам энэ хандлага руу хандсан мэт байдаг, учир нь энэ үг бүтцэд онцгой анхаарсан утгыг илэрхийлдэг. Деконструкцичлах гэдэг бол бас л бүтэцлэх хандлага мөн. Гэхдээ бас бүтэцлэхийн эсрэг хандлага ч мөн. Түүний хувь заяа энэхүү хоёрдмол утга дээрээ заримдаа тулгуурладаг. Бүтцийг задлах, хэсэглэх, ангилах тухай яригдаж байгаа ч энэ бол ямар нэг негатив утгатай ажиллагаа биш. Эвдэх гэдгээс илүүгээр эмхэлж цэгцээгдсэн ямар нэг "ансамбль" мэтээр, үүний тулд түүнийг шинээр байгуулах гэж л ойлговол зохино. Гэхдээ харагдах негатив талыг нь хичнээн зөөлрүүлээ ч гэсэн үгийн грамматикаар нь (де-) түүнийг тооцохыг энэ үг шаардсаар байна. Деконструкцид анхаарлаа хандуулахдаа энэхүү эсрэг тэсрэг утгыг ямагт тооцох хэрэгтэй. Энэ нь эцсийн үр дүнгээрээ нурааж, эвдэх гэхээсээ илүүгээр бүтээж, босгох утгыг заадаг.

"Бүтэцлэх, бүтцийг эвдэх" энэхүү хоёрдмол утга дээр деконструкци хэрэгждэг.

Уг хандлага генетик утгаараа философийн герменевтикийн үндсэн зарим зарчимтай холбогддог. Философийн герменевтикт тухайлбал Г.Гадамерийн үзсэнээр текстийг зохиогчоос өөрөөс нь илүү ойлгох нь гол бус, харин түүнийг одоо цагийн нөхцөл байдлын үүднээс харж өөрөөр ойлгох нь чухал байдаг. Деконструкци бол энэ хандлагын гүнзгийрсэн хэлбэр гэж хэлж болно. Гэхдээ өөрөөр ойлгох гэдэг нь судлагдахуунд өөрийн субъектив байр сууринаас хандахыг шаардаж буй хэрэг огтхон ч биш, харин утга санаа, утга холбогдлын цоо шинэ хослолыг олж харна гэсэн үг. Түүнээс гадна герменевтик эргэлзлийн тухай сургаал нь текст аливаа тайлбарлалд нээлттэй байх шинжийг онцолдог бөгөөд Гадамерийнхаар тайлбарлал хэзээ ч төгс байдаггүй. Тэгэхээр текстийг байгаагаар нь ойлгох нь чухал бус, харин өнөөгийн бидний хувьд юуг илтгэж байна вэ гэдэг үүднээс ойлгох нь чухал. Чухам энэ хандлагаараа тэрээр И.Кантаас эхэлсэн уламжлалын хүрээнд байгаа юм. Учир нь Кантын үзлээр юмс байгаагаараа юу вэ гэдгийг бид хэзээ ч танин мэдэж чадахгүй боловч бидний хувьд юу вэ гэдгийг танин мэдэж болно. Бидний хувьд юмс юу вэ гэдгийг загварчлах замаар байгаагаараа байгаа юмсын утгыг бид оноодог. Гэхдээ энэ үйл явц К.Попперийн утгаар хэзээ ч


Текстийг зохиогчоос өөрөөс нь илүү ойлгох нь гол бус, харин түүнийг одоо цагийн нөхцөл байдлын үүднээс харж өөрөөр ойлгох нь чухал.

төгсгөлөг биш бөгөөд засвар, залруулга, шинэ утга бүрдэлдэх орчин нээлттэй. Утгаа илэрхийлсэн (актуаль) текст өөрийн бүх бололцоог бүрэн шавхчихсан биш хэмээн ойлговол илүү зохистой. Иймд боломжит утгыг түүнээс эшлэн ургуулах ёстой. Чухам эндээс деконструкцийн утга тодордог. Бидний ойлгож буйгаар Кант анхлан ухаарсан, Поппер онцгойлон илэрхийлсэн мэдлэгийн ертөнцийн бие даасан шинж нь өнөө цагийн ухаарлын үүднээс бол утгын хувьсамтгай шинж, өөрийгөө өөрөөр илэрхийлэх боломжийг анхнаасаа агуулдаг гэх мэт шинжүүдээр бас тодорхойлогдох болж байна. Г.Гегелийн үзэж байсанчлан утга тогтвортой бус учраас ойлгохуй ч бас



хөдөлгөөнтэй, хувьсамтгай байх нь зүйн хэрэг. Тэгэхээр судлагдахуун болж буй зүйлээс нэгдэл, адилсалыг биш ялгаа, ялгаралыг анхаарах хэрэгтэй ба ялгаа бүр нь шинэ ухаарлыг төрүүлэх, өмнөх бүтцийн өөр хувилбарыг бий болгох боломжийг бидэнд бүрдүүлнэ. Деконструкци нь энэ бүх ханддагаараа зохиогчийг бүр тодруулбал субъектийг голлон анхаарах хандлагыг үгүйсгэж, "зохиогчийн үхлийн" тухай ярихад хүргэж буй юм. Дараа

дараагийн үзэл баримтлалуудад деконструкцийн үзүүлсэн нөлөө их төдийгүй деконструктивизм, постмодернизм зэрэг чиглэлүүдийн үндсэн зарчмууд түүний хүрээнээс давж гардаггүй.



Философид постмодернизм хэмээх нэр томъёо постструктурализм, деконструкционизм, мультикультуризм, жендер судлал, уран зохиолын онол зэргийг багтаасан бүхэл бүтэн хөдөлгөөнийг илэрхийлнэ.

Постмодернизм хэзээ үүссэн, тэр нь юу болох талаар нэгдсэн ойлголт байдаггүй. Түүнийг тодорхойлоход хүнд байдгийн учир нь тэрээр урлаг, уран барилга, хөгжим, кино, уран зохиол, харилцаа холбоо, хувцас дизайн, техник технологийг хамарсан маш олон салбарт илэрдэгт оршино.

Постмодернизм юуны өмнө агуу нарратив буюу метанарративын санааг үгүйсгэдэг. Тэрээр постмодерн үед мэдлэгийг үнэлэх шалгуур өөрчлөгдсөнийг илэрхийлж, үүнд хэрхэн зохицох талаар үнэтэй санааг "Постмодерн төлөв" хэмээх бүтээлдээ далдуур илэрхийлсэн.

Лиотарын үгээр бол метанарративт үл итгэх нь постмодерн юм.

Түүнчлэн постмодерн ертөнц симуляциар тодорхойлогддог. Бид "симуляцийн эрин үе"-д амьдарч байна. Симуляцийн процесс симулякрыг буюу "объект, үйл явдлын хуулбарыг" бүтээдэг.



Жан Бодриардын үзэж байгаагаар постмодерн эринд

- ▲ Тэмдэг өөрсдөдөө болон өөр тэмдэгт арай мэрий хамаардаг болжээ.
- ▲ Тэмдэг бодит байдал хоорондын ялгаа багасч, үгүй болж байна.
- ▲ Медиа нь бодит байдлын толь байхаа болж, харин өөрөө бодит байдал болж, бодит байдлаас илүү бодитой болж байна.

